# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

# 2007 – 2015




Баянхонгор, 2007



Нээлттэй Нийгэм Форум

Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага

Бодлого судлалын төв

Баянхонгор сум

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форум болон Бодлого Судлалын Төвийн дэмжлэгтэйгээр Баянхонгор аймгийн Баянхонгор сумын төр, захиргаанаас сумынхаа иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн төлөөлөлтэй хамтран оролцооны зарчмаар энэхүү стратегийг боловсруулав. Нээлттэй Нийгэм Хүрээлэн, «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага», Нээлттэй Нийгэм Форум энэхүү стратегийн агуулга, мэдээллийн баталгаажилт, чанарын талаар хариуцлага хүлээхгүй.

DDC
338.9’517
Э-17

ISBN 978-99929-0-374-0

Хянан тохиолдуулсан: Б.Мөнхсоёл, Ё.Доржбат, М.Цогт, С.Лочинлхам, Б.Эрдэнэбаатар

Эхийг бэлтгэсэн: Ч.Эрдэнэбат
Хавтасны дизайнер: Ц.Одончимэг

Хэвлэсэн газар: «ADMON» ХХК, Монгол

© Зохиогчийн эрхийг Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ эзэмшинэ.

# Гарчиг


Өмнөтгөл . . . v
Товчилсон үг . . . vi
Өмнөх үг . . . vii
Оршил . . . ix

**Бүлэг 1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн нийтлэг асуудлууд . . . 1**

1.1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн ач холбогдол . . . 1
1.2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндэслэл . . . 3
1.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн агуулга, мөн чанар . . . 5

**Бүлэг 2. Стратеги боловсруулах үйл ажиллагаа . . . 7**

2.1. Үндсэн зарчим, арга зүй . . . 7
2.2. Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын ба зохицуулалтын арга хэмжээ . . . 9
2.3. Олон нийтийн оролцоо ба зөвшилцөл . . . 15
2.4. Бизнесийн орчны судалгаа . . . 15
2.5. СВОТ шинжилгээ . . . 16
2.6. Алсын хараа-зорилго-зорилт-хөтөлбөр-төсөл . . . 17
2.7. Хүлээгдэж буй үр дүн . . . 19
2.8. Стратегийн хэрэгжүүлэлт . . . 20
2.9. Стратеги хэрэгжүүлэх зохион байгуулалтын асуудлууд . . . 21

**Бүлэг 3. Баянхонгор сумын танилцуулга . . . 23**

3.1. Сумын нутгийн удирдах байгууллага, тэдгээрийн бүтэц . . . 23
3.2. Гадаад харилцаа . . . 26
3.3. Газар зүй, цаг уурын нөхцөл, байгалийн нөөц баялаг . . . 26
3.4. Хүн ам зүй: өсөлт, хүний нөөц, чадавхи . . . 28

**Бүлэг 4. Сумын эдийн засгийн хөгжлийн тойм, хэтийн төлөв . . . 30**

4.1. Сумын эдийн засгийн хөгжлийн тойм ба хэтийн төлөв . . . 30
4.2. Төсвийн санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт . . . 31
4.3. Нийт бүтээгдэхүүний үлйдвэрлэл . . . 32
4.4. Төрийн байгууллага ба хувийн хэвшлийн үйл ажиллагааа . . . 33

4.5. Зах зээл, маркетинг . . . . . 36
4.6. Боловсрол, соёл, аялал жуулчлал, эрүүл мэндийн үйлчилгээ . . . . . 37
4.7. Дэд бүтэц ба бусад үйлчилгээ . . . . . 40

**Бүлэг 5. Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги . . . . . 43**

5.1. Бизнес орчны судалгааны гол үр дүн . . . . . 43
5.2. СВОТ шинжилгээний дүн . . . . . 45
5.3. «Алсын хараа-Зорилго-Зорилт-Хөтөлбөр-Төсөл» матриц . . . . . 49
5.4. Төсөл хэрэгжүүлэлтийн матриц . . . . . 53
5.5. Төслийн эрэмбийн матриц . . . . . 59
5.6. Бизнесийг дэмжих стратеги чиглэлүүд . . . . . 62
5.7. Төслийн товч танилцуулга . . . . . 65

# Өмнөтгөл

Монгол шиг шилжилтийн эдийн засагтай орнуудын хөгжлийн тэргүүлэх зорилгуудын тоонд шинээр төрөн гарч буй хувийн хэвшлийнхэнд зориулж бизнес эрхлэх тааламжтай орчин бүрдүүлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжилд (ОНЭЗХ) зориулсан нэгдмэл, олон талт төлөвлөгөөг өөрсдийн санаачилгаар боловсруулах явдал ордог.

Сүүлийн жил гаруй хугацаанд Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Нээлттэй Нийгэм Форумаас Монгол улсын 4 суманд орон нутгийн ард иргэдийн цаашдын хөгжлийн хэрэгцээгээ илүү сайн төлөвлөж, удирдах чадавхийг бэхжүүлэх ажлыг санаачилан хэрэгжүүлж байна. Энэхүү «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх нь» (DELTA) хэмээх төслийг өмнө нь ННХ, Дэлхийн Банкнаас Зүүн Европт хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн хэрэгжүүлсэн юм. Үүний үндсэн санаа нь орон нутгийн хүн амын томоохон бүлгүүд, түүний дотор төр засаг, хувийн хэвшил, иргэний нийгмийнхэн хамтран хөгжлийн таатай нөхцөл, боломжуудыг шинжлэх, алсын хараа, зорилго, зорилтуудаа тодорхойлох, улмаар тэдгээрт хүрэхэд чиглэсэн тодорхой, ач холбогдол бүхий төсөл, алхмуудыг боловсруулж гаргахад оршиж байсан юм.

Таны өмнө байгаа стратегийн баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь тус төслөөс гарч буй хамгийн анхны биет үр дүнгүүд юм. Харин сумын түвшинд бий болоод байгаа хөгжлийн шинэ түншлэлүүд, тухайн сумдын «бизнес эрхэлж» байгаа шинэ арга барил буюу илүү олныг хамарсан, оролцоот хэлбэр нь нүдэнд тэр бүр ил харагдахгүй үр дүнгүүд юм. Цаашид энэхүү төлөвлөлтийн арга зүйг бусад янз бүрийн шийдвэр гаргах үйл явцад хэрэглэх боломжтой, хэрэглэх ч ёстой юм.

Энэ завшааныг тохиолдуулан Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ард иргэд, Бодлого судлалын төвийнхөн болон энэхүү стратегийг амжилттай боловсруулахад хувь нэмрээ оруулсан бусад бүх мэргэжилтнүүдэд талархлаа илэрхийлэхийг хүсч байна.



П.Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал



Скотт Абрамс
Будапештийн ННХ-ийн Орон нутгийн захиргаа, төрийн албаны шинэчлэлийн санаачилгын Орлогч захирал

# Товчилсон үг

| | |
|---|---|
| ДЕЛТА | «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх» төслийн англи нэрийн эхний үсгийн хураангуй |
| ОНЭЗХС | Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги |
| СЭЗХС | Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги |
| СЗДТГ | Сумын засаг даргын тамгын газар |
| СИТХ | Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурал |
| ННФ | Нээлттэй Нийгэм Форум |
| ННХ | Нээлттэй Нийгэм Хүрээлэн |
| ОНУТҮШС | Орон нутгийн удирдлага, төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага |
| БСТ | Бодлого судлалын төв |
| ОУБ | Олон улсын байгууллага |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| БОС | Бизнес орчны судалгаа |
| БХА | Бизнес хөгжлийн алба |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэр |
| ААН | Аж ахуйн нэгж |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| ХЭАА | Хувиараа эрхлэх аж ахуй |
| ИНТ | Иргэдийн Нийтийн Хурал |



# Өмнөх үг

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн «Орон Нутгийн Удирдлага ба Төрийн Үйлчилгээг Шинэчлэх Санаачлага» хөтөлбөрөөс зүүн Европын орнуудад амжилттай хэрэгжүүлсэн «Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх - ДЕЛТА» төслийн арга зүйн ба техник ажиллагааны дэмжлэгтэйгээр Баянхонгор сумын эдийн засгийн хөгжлийн 2015 он хүртлэх дунд хугацааны стратегийг боловсруулав.

Сумын эдийн засгийн алс хэтийн хөгжлийн бодлогын баримт бичиг болох дунд хугацааны стратегийг боловсруулах явцад дээр дурдсан арга зүй, практик үйл ажиллагааны зарчим, оролцооны арга хэрэгслийг бүтээлчээр ашигласан нь сум орныхоо хөгжлийн хэтийн төсөөлөл болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөлтийн арга хэмжээг бодит байдалд нийцүүлэн үнэн зөв томъёолоход зохих үр дүнгээ өгснийг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Сумын эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратегийн алсын хараа, түүнд хүрэх зорилго, зорилтууд болон хөгжлийн хөтөлбөр, төслүүдийг боловсруулахдаа орон нутгийн удирдлага, бизнес эрхлэгчид, иргэд, олон нийтийн байгууллагын оролцоог өргөжүүлж, түншлэл, хамтын ажиллагааг идэвхжүүлэх замаар тэдний нийтлэг хүсэл тэмүүлэл, чин эрмэлзлэл, санал бодолд үндэслэсэн бөгөөд энэ нь орон нутгийн бизнесийн орчны судалгаа, эдийн засгийн орчны нөхцөл байдлын шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэг, чөлөөт ярилцлага зэрэг арга хэрэгслүүдээр дамжин хэрэгжсэн юм.

ЭЗХ-ийн стратеги нь сумын хэтийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хувийн хэвшлийн бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэхэд орон нутгийн удирдлагын зүгээс нэн түрүүнд авч хэрэгжүүлбэл зохих гол арга хэмжээг Төлөвлөлтийн комисс, ажлын хэсгүүдийн оролцоотой

тодорхойлон тусгасан төдийгүй түүнд чиглэсэн орон нутгийн онцлог бүхий хөтөлбөр, төслүүдийг боловсруулж оруулснаараа төр-хувийн хэвшлийн байгууллагын түншлэлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Сумын эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги хэрэгжсэний үр дүнд төрийн үйлчилгээний байгууллагыг бэхжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн мэдээллээр хангах, төрөл бүрийн сургалт зохион байгуулах, зар сурталчилгааг өргөжүүлэх замаар бизнесийн хөгжлийн орчин мэдэгдэхүйц сайжирч, түүнээс улбаалан хувийн хэвшлийг дэмжих, ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийт иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, байгаль орчны доройтлыг бууруулах зэрэг сумын эдийн засгийн хэтийн хөгжлийн бодлогын зангилаа асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн ахиц дэвшил гарах болно.

Сумын эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх үйлсэд тус сумын иргэд, байгууллага, малчид, бизнес эрхлэгчид, манай түншүүд идэвхтэй оролцож, өөрсдийн бодит хувь нэмэр оруулах чин эрмэлзэл дүүрэн байгаа хэмээн найдаж байна. Түүнчлэн хандивлагчид, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудаас сайн санааны тусламж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана гэдэгт чин сэтгэлээсээ итгэж байна.

Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд<br>Баянхонгор хотын захирагч<br>М.Цогт

# Оршил

Монгол улсыг бүхэлд нь хамарсан эдийн засаг-нийгмийн шинэчлэлтийн хүрээнд тус сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн хүрсэн түвшинг хадгалах, цаашид ахиулах, үр ашгийг нь олон нийтэд жигд хүртээхэд сумын төр, захиргааны байгууллага, бизнес эрхлэгчид түлхүү анхаарах явдал цаг үеийн хойшлуулшгүй зорилт болж байна. Ирээдүйд хөгжил өргөжин тэлэх суурь болох зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх асуудал хөгжлийн шинэ зорилготой холбогдон сумынхны өмнө чухлаар тавигдаж байна.

Зах зээлд шилжих явцад болон шилжилтийн дараах жилүүдэд сумын эдийн засгийн хөгжил, бизнесийн бүтэц, чадавхид олон чухал дэвшил, өөрчлөлтүүд бий болсон бөгөөд энэ үйл явц одоо ч үргэлжилсээр байна. Зах зээлд шилжихээс өмнө төрийн ба хоршооллын өмчийн том аж ахуйнууд үйлдвэрлэл, үйлчилгээнд давамгайлж байсан бол эдүгээ хувийн өмчид суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл энэхүү байр суурийг эзлэсэн явдал эдийн засаг, бизнесийн хөгжлийн асуудлыг шинэлэг арга барилаар авч үзэх бодит шаардлагыг бий болгож байгаа гол хүчин зүйл юм.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг сумын түвшинд хангахад туслалцаа дэмжлэг авах, санхүүжилтийн эх үүсвэр олохын тулд хандивлагчид, хөрөнгө оруулагчдыг татах дорвитой арга хэмжээ хэрэгжүүлж, амьд ажил өрнүүлэх цаг үе ирээд байна. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг орон нутгийн бизнес орчныг сайжруулах чиглэлд улам гүнзгийрүүлэх хэрэгтэй байна. Сумын төр, захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагуудаас дүрэм журам, зохицуулалт гаргахдаа сумынхаа эдийн засгийг цэцэглүүлэн хөгжүүлэхийн тулд бизнес эрхлэгчдээс идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломжийг хангах, тэдэнд тулгарч буй асуудлуудыг зохистой шийдвэрлэх явдлыг эн тэргүүнд тавьдаг байх нь зүй ёсны шаардлага төдийгүй шинэ хандлага, шинэ арга барилын үндсийн үндэс болох учиртай.

Сумынхаа бизнесийг идэвхжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, хүн амын амьдралын чанарыг тасралтгүй сайжруулахад орон нутгийн бизнесийн өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх шинэ үзэл баримтлал, шинэлэг арга замаар хандах нэн төвөгтэй үүрэг хариуцлагыг орон нутгийн удирдлага, бизнес эрхлэгчид өөртөө хүлээх шаардлагатай боллоо.

Ийм нөхцөлд одоо үйл ажиллагаа явуулж буй бизнесийг чадавхижуулах, шинээр бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах таатай нөхцлийг бүрдүүлэх асуудлыг сумын төр, захиргаа стратегийн зорилтын хэмжээнд тавьж ажиллах ёстой юм. Цаад агуулгаараа, энэ нь нөөц боломжоо орон нутгийнхаа хөгжлийн төлөө зохистой ашиглах, хэрэглэгчдийн эрэлт таашаалд нийцсэн бүтээгдэхүүн, ажил

үйлчилгээг зах зээлд гаргах тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэлүүдээ оновчтой тодорхойлох, энэ дагуу дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийг иж бүрнээр боловсруулахад сумынхан өөрсдөө ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай гэсэн үг. Сумын эдийн засгаа амжилттай хөгжүүлж, тогтворжуулах асуудалд ийн хандваас бүх боломж, нөөцөө хамгийн ухаалгаар үр өгөөжтэй ашиглах зохистой арга замаа олж сая чадна.

Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги (ЭЗХ)-ийн зорилго, зорилт, төслүүдийнхээ харилцан уялдааг олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд сайтар хангах, түншүүд, оролцогчдын чадавхи, чин эрмэлзлийг оновчтой тусгасан байх зарчмыг стратеги боловсруулах явцад барьж ажиллав. Ийнхүү нийтээр чармайн ажиллаж сумын эдийн засгийн хөгжлийн стратеги боловсруулах ажлаа амжилттай дуусгалаа. Эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд сумынхны бүх бүлэг, давхарга өөрийн оролцоо, хувь нэмрээ оруулах боломжийг энэ стратеги бүрдүүлж өгснийг тэмдэглэх нь зүйтэй.



# БҮЛЭГ 1

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН НИЙТЛЭГ АСУУДЛУУД

## 1.1. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн ач холбогдол

Юуны өмнө, сумын эдийн засгийн хөгжлийн иж бүрэн стратегитэй болсон явдал ДЕЛТА төслөөс тус суманд үзүүлсэн бодитой дэмжлэгийн шууд үр дүн мөн гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Манай сумын удирдлага, бизнес эрхлэгчид, иргэд орон нутгийнхаа хөгжлийн тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлаар «ямар ч түвшинд нүүр улайхгүй тулж ярих, хэлцэх» нэн чухал боломжоор хангагдлаа хэмээн стратегийнхээ ач холбогдлыг зангидан томъёолж байна.

Сумынхны хүсэл тэмүүлэл, чин эрмэлзлийг тусгасан «Эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги» нь хөгжлийн асуудлаар өргөн хүрээтэй түншлэл, хоршилт, хамтын ажиллагааг өрнүүлэх хэтийн удирдамж болохоос гадна сумын эдийн засаг-нийгмийн хөгжлийн явц, өрнөлийг үнэлэх, дэвшигдэн буй шинэ зорилго,

зорилтыг олон нийтийн оролцоотойгоор тодорхойлон шийдвэрлэж байх шаардлагад төгс нийцсэн баримт бичиг болж чадсан юм.

Сумын хөгжлийн ирээдүйн чиг баримжаатай холбоотой үзэл баримтлалын ба стратегийн чиглэлүүдийг тодорхойлох, шинэчлэн томъёолох хэрэгцээ шаардлага цоо шинээр гарч ирээгүй, ДЕЛТА төслөөс өмнө ч гэсэн яригддаг байсан билээ. Сумын төр, захиргааны ба төрийн үйлчилгээ эрхлэх байгууллагуудын хувьд олон жилийн өмнөөс тулгамдсаар ирсэн энэ асуудлыг зохистой шийдвэрлэн хэрэгжүүлэх боломж хараахан гараагүйд хэргийн учир оршиж байгаа юм. Энэ талаас нь авч үзвэл, ДЕЛТА төслийг манай суманд хэрэгжүүлсэн нь цаг үеэ олсон чухал үйл явдал болсон билээ.

Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг сайжруулах, орон нутгийн бизнесийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах орчинг бүрдүүлэх, орон нутгийн бизнесийг дэмжихэд сумын удирдлагын зүгээс тавьж буй хүчин чармайлтыг оновчтой чиглүүлэх асуудал бодитой тулгарахын цагт үр өгөөжтэй, хэрэгжих боломжтой стратегийг хэтийн баримжаатайгаар боловсруулах арга зүйн ба мэргэжлийн дэмжлэг, мэдээлэл ямагт дутагддаг, тэр чинээгээр сумын хөгжлийг багагүй удаашруулдаг, саатуулдаг байсан юм.

Орон нутгийн эдийн засгийг зах зээлд нийцүүлэн салбарлуулан өргөжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг зохистой өөрчлөх талаар сумын төр, захиргаанаас зохих хүчин чармайлт тавьж ажиллаж ирсэн билээ. Хамгийн гол нь бүтээлч түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд сумын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зохистой механизм бий болгох, зах зээлийн зөв гольдролд оруулахад тэдгээр арга хэмжээ төдийлэн бүтэмжтэй болж чадаагүй юм.

Эдүгээ суманд байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний бизнес тэр бүр санасан хэмжээгээр өргөжин тэлэхгүй, шинээр бизнес эрхлэх санаачлага оролдлого бүхэн ажил хэрэг болж хараахан чадахгүй байгаа нь бизнесийн өсөлтийг дэмжих санхүүгийн найдвартай эх үүсвэр дутмаг байгаатай холбоотой. Түүнээс гадна бизнес эрхлэх орчин нь бизнесийн чадавхийг дээшлүүлэхэд тэр бүр тааламжтай бус байгаа явдал зохих сөрөг нөлөөтэй гэж дүгнэж болно.

Ер нь сумын төр, захиргаа нь эдийн засгийн хөгжил, бизнесийн дэвшлийг идэвхгүй ажиглагч юм уу хөндлөнгөөс шууд оролцогч биш, харин эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, амьдралын чанарыг дээшлүүлэх гол нөхцөл болох бизнесийг хөгжүүлэхэд эрхзүйн зохицуулалт, шаардлагатай бусад дэмжлэгийг үзүүлдэг, үйл ажиллагаанда хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэхийг бүх талаар эрмэлздэг, өөрөө санаачилдаг, олон нийтийг манлайлан чиглүүлдэг түнш байхыг туйлаас эрхэмлэх цаг ирээд байна.

Сумын төр, захиргаа нь янз бүрийн сонирхол бүхий бизнесийн ба иргэний нийгмийн бүлгүүдийг хөгжлийн асуудал дээр зохион байгуулж төвлөрүүлэх, хамтран ажиллах арга хэлбэрээр тэднийг дэмжих бүрэн чадавхитай байгууллага мөн болохыг стратеги боловсруулах явцад хуримтлуулсан туршлага маань харууллаа. Олон улсын байгууллагаас үзүүлсэн дэмжлэгийн ачаар хөгжлийн шинэ стратегитэй болсноор бизнесийг дэмжин хөгжүүлэх үйл ажиллагааг орон нутагтаа үр ашигтай зохицуулах, зохион байгуулахад төр, захиргааны зүгээс явуулах үйл ажиллагааны механизмаа тодорхойлж авлаа, шинээр сэтгэх, ажиллах нэн таатай нөхцөл бүрдлээ.

ДЕЛТА төслийг хэрэгжүүлэхэд оролцсон хандивлагч ба хэрэгжүүлэгч байгууллагууд, төслийг гүйцэтгэгчид бидний хамтын чармайлтаар бүтсэн эдийн засгийн хөгжлийн стратеги маань манай сумын эдийн засаг, бизнес цэцэглэн хөгжих баталгаа болж чадсан гэдэгт гүнээ итгэж байна.

## 1.2. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндэслэл

Сумын олон нийтийн чин эрмэлзэлд тулгуурлан тэдний идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр анх удаа боловсруулсан сумын ЭЗХ-ийн стратеги нь орон нутгийн эдийн засаг ба бизнесийн хөгжлийг дэмжих орчинг боловсронгуй болгох талаар тулгамдаж буй болон ирээдүйн чиг хандлагатай холбоотой нэн тэргүүний асуудлыг оролцооны зарчимд тулгуурлан тодорхойлох хамгийн дөхөмтэй, хэрэгжих боломжтой арга замыг эрэлхийлсэн хамтын хүчин зүтгэлийн үр дүн билээ. Тэргүүлэх ач холбогдолтой хэмээн хамтаараа тодорхойлсон зорилгоо амжилттай хэрэгжүүлснээр стратегиийн үр шимийг олон нийтэд хүртээх, олон нийтийн зүгээс зүй зохистой хүртэх суурь нөхцлийг бүрдүүлж чадах юм.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төрийн үйлчилгээг сумын төр, захиргаанаас хэрэгжүүлж буй арга зам, хэлбэр нь эргээд эдийн засгийн дотоод боломж, давуу байдал, гадаад таатай нөхцлийг аль болох өгөөжтэй ашиглах, бизнесийг тогтоон барих, өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр явуулах үйл ажиллагааны чанар, үр дүнд шууд болон дам нөлөө үзүүлдэг, тэр ч учраас эдийн засаг, бизнест зайлшгүй харгалзах хүчин зүйл юм.

Бизнес эрхлэгчид, байгууллага, иргэдэд тэгш үйлчлэх зохистой орчинг бүрдүүлэх явдал төр, захиргааны үндсэн зорилго мөн. Үнэн чанартаа, аливаа бизнесийн хүрээ, түүний хэмжээ далайц бол бизнеийн орчныг бизнестэй шууд холбодог хүчин зүйл хараахан биш. Энэ ч учраас сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах явцад өмчлөл, зохион байгуулалтын хэлбэр, хэмжээгээр нь ялгаварлахгүйгээр үйлдвэрлэл,

үйлчилгээ явуулж буй иргэд, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах нийтлэг зарчмыг сумын төр, захиргаанаас баримталсан болно.

Орон нутгийн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сумын эдийн засгийн хөгжилд таагүй нөлөөлж байгаа, нөлөөлж болзошгүй орчны болон бусад хүчин зүйлсийг залруулах, зөөлрүүлэх, саад бэрхшээл, эрсдэлийг багасгах, даван туулах арга замыг агуулгын болоод хэлбэрийн хувьд оновчтой сонгоход стратегийн үндсэн баримжаа чиглэсэн болно. Стратегийн гол томъёолол, бүтцийг эцэслэн боловсруулахаас өмнө явуулсан бизнес орчны судалгаа болон СВОТ шинжилгээ нь эдийн засаг, бизнесийн хөгжлийн одоогийн байдал, хүрсэн түвшинг тодруулах, хэтийн чиглэл хандлагын талаар сумынхны үнэлэмж, төсөөллийг нэгтгэсэн суурь мэдээлэл бүрдүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Сумын төр, захиргаа болон олон нийтийн хамтын хүчин чармайлтын бодит үр дүн, эдийн засгийн хөгжлийн илүү өндөр түвшинд хүрэхийн төлөө иргэд, бизнесийнхэн, төр, олон нийтийн байгууллагуудын нийтлэг хүсэл тэмүүлэл, ирээдүйн тухай санал төсөөллийг төлөөлж байгаа гэдэг үндэслэлээр бидний боловсруулсан дунд хугацааны стратегийн агуулгыг тодорхойлох боломжтой.

Сумынхаа орчмын бүс нутгийн хүний ба байгалийн нөөц, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн төлөв байдал, соёл, түүхийн өв сан зэрэг чухал ач холбогдол бүхий хэд хэдэн хүчин зүйлсийг стратеги боловсруулахад харгалзан үзсэн болно. Эцэст нь, манай сумын харьцангуй давуу талууд, олон нийтийн идэвх зүтгэл, чин эрмэлзэлтэй холбоотой аливаа боломж бүхнийг стратегид тусгахыг эрмэлзлээ.

«Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай» хуулийн 8 дугаар зүйлийн 1-д «Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь ...нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж...», «Сум, дүүргийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй», мөн хуулийн 18.1.2-ын «а»-д «...нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах;» хэмээн тус тус заасан нь сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах эрх зүйн үндэслэл болж өглөө.

Хувийн хэвшлийнхнээс ихээхэн идэвх чармайлт, санаачлага гаргаж сумын төр, захиргаатай хамтран ажиллаагүйсэн бол стратеги боловсруулах тухай бодохын ч хэрэггүй байсныг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Стратеги боловсруулах үйл ажиллагаа нь өөрөө сумынхны дунд тодорхой хүлээлт бий болгосон төдийгүй хүлээлтээ ахиц амжилттай, бодит үр өгөөжтэй ажил хэрэг болгох, стратегийг үр

дүнтэй хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг хариуцлагын талаар энэ ажилд оролцсон, хувь нэмрээ оруулсан хүмүүст нийтлэг ойлгоцыг тогтоож өглөө.

Бүтээлч хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр жимс болсон стратеги маань амжилттай хэрэгжинэ гэдэгт сумын төр, захиргааны байгууллага, иргэд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд бүрэн итгэж байна. Стратегид тусгасан төслүүд, бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлээ үр дүнтэй хэрэгжүүлэх замаар алсын хараа, зорилго, зорилтдоо хүрэхэд байгаа нөөц боломжоо туйлын зохистой хуваарилан ашиглах болон чадавхи, давуу талаа хариуцлагатай зохицуулах асуудал олон нийтэд үр өгөөжийг хүртээх боломжийг хангах талаасаа нэн чухал гэдгийг цохон тэмдэглэж байна.

Баянхонгор сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2007 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд сумын стратегийг хэлэлцэн дунд хугацааны (2007-2015) хөгжлийн чиг баримжаа, ялангуяа бизнес хөгжих орчныг сайжруулах, төрийн үйлчилгээг шинэ шатанд гарган сайжруулах алсын харааг оновчтой томъёолж, энэ хүрээнд стратегийн зорилго, зорилтууд, төслүүдийг зөв тодорхойлж чадсан гэж үзээд санал нэгтэй баталсан болно.

## 1.3. Сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн мөн чанар, агуулга

Бизнесийн орчинг цаашид улам сайжруулж, боловсронгуй болгоход олон нийтийн оролцоо, хүчин чармайлтыг дэмжин идэвхжүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хандивлагчид, хөрөнгө оруулагчдаас дэмжлэг туслалцаа үзүүлж болох гол чиглэлүүдийг оролцооны зарчмаар тогтоосон явдал стратегийн гол агуулгыг тодорхойлж байна. Орон нутагтаа бизнес хөгжүүлэх орчныг сайжруулахад тулгамдаж буй цаг үеийн ба алс хэтдээ шийдвэрлэвэл зохих асуудлуудын талаархи олон нийтийн мэдлэг туршлага дээр тулгуурлан энэхүү стратегийг боловсруулсан нь түүний мөн чанарыг илэрхийлнэ.

Арга зүйн хувьд, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг төлөвлөхөд баримталж байгаа сүүлийн үеийн үзэл баримтлал, онол-практикийн үндсэн асуудлуудыг стратеги боловсруулах ажиллагааны бүх шатанд харгалзсан болно.

Баянхонгор сумын эдийн засгийн хөгжлийн стратегийн гол зарчмыг товчлон тодорхойлбол:

- Дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг хангах асуудлыг сумын төр, захиргаа, иргэд, бизнесийн ба олон нийтийн байгууллагатай бүх түвшинд

холбох замаар эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгох, төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг чанаржуулах,

- Бизнесийг өргөжүүлэх, салбарлуулан хөгжүүлэх, шинээр бизнес эхлэхэд бизнеийн орчноор дамжуулан сумын төр, захиргаанаас үзүүлэх дэмжлэгтэй холбоотой төслүүдийг оролцогчдын туршлага мэдлэг, санал төсөөлөл дээр үндэслэн тодорхойлох,
- Орон нутгийн бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг нэгтгэх замаар хөгжлийн алсын хараа, нийтлэг зорилгоо стратегийн хэлбэрээр тодорхойлох жишээг сумын олон нийтэд бодитойгоор харуулах,
- Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн дэвшлийг хангах, өсөлт бий болгох, олон нийтийн бүтээлч оролцоо, хувь нэмрийг өргөжүүлэхэд оролцогчдыг хөтлөх хэрэглүүр болох талаас нь стратеги төлөвлөлтийг таниулан ойлгуулах,
- Санхүүгийн ба техникийн дэмжлэг үзүүлдэг хандивлагчид, хөрөнгө оруулагчдад хандах, нөлөөлөх арга хэрэглүүр болгон ашиглах үндэслэл, боломжтой холбон стратегийг хүлээн авах нийтлэг хандлага, ойлголтыг олон нийтийн дунд бэхжүүлэх,
- Хамтач уур амьсгалийг бэхжүүлж, нээлттэй, ажил хэрэгч байдлыг хангах, эдийн засаг, бизнесээ хөгжүүлэх, өргөжүүлэх хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй орчинг бүрдүүлэх зэрэг болно.



# БҮЛЭГ 2

# СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 2.1. Үнсэн зарчим, арга зүй

Олон нийтийн идэвхтэй, чин эрмэлзэлт оролцоог хөхүүлэн дэмжих янз бүрийн арга хэрэгслийг ашиглах боломжийг хангах үндэслэлээр сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ зорилгоор бий болгосон албан ёсны бүтцийн хүрээнд болон нээлттэй хэлэлцүүлэг, зөвшилцөл зэрэг арга хэмжээгээр дамжуулан олон нийтийг стратеги боловсруулах үйл ажиллагаанд оролцуулж чадсан юм. Олон нийтийн саналын үндсэн дээр сумын хөгжлийн эдийн засаг, бизнесийн хөгжил, тогтвортой өсөлтийг хангах нийтлэг ба гол гогцоо асуудлаа хамтын оюун ухаанаар тодорхойлох зарчмыг хангахад стратеги боловсруулах үйл ажиллагааг чиглүүлэв.

***Үндсэн зарчим.*** Сумын ЭЗХ-ийн стратегийг боловсруулахад баримталсан гол зарчмууд:

- Эдийн засгийн өсөлт, бизнесийн хөгжлийг нийгмийн амьдрал, байгаль орчин, иргэдийн амьжиргааны чанарын тулгамдсан асуудлуудтай холбох, зөв тэнцвэржүүлэх,
- Орон нутгийн бизнесийн хөгжил, хөрөнгө оруулалтын уур амьсгалыг сайжруулахад сумын төр, захиргааны байгууллагаас гүйцэтгэх үүргийг тодорхой болгох,
- Эдийн засгийн ололт, бий болсон өсөлтийг тогтворжуулахад төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг чиглүүлэн дэмжлэг үзүүлэх,
- Стратеги төлөвлөлтийг олон нийтийг хамарсан бүтээлч үйл ажиллагааны хэлбэрээр сумын захиргааны түвшинд зангидан зохион байгуулах,
- Үйл ажиллагаа явуулж буй бизнесийг дэмжих, орон нутагтаа тогтоон барих асуудлыг шинэ бизнес бий болгохтой эн тэнцүү авч үзэх,
- Гадаад эх үүсвэр, хүчин зүйлд дулдуйдахыг эрмэлзэхээс илүү дотоод нөөц боломжоо энэ чиглэлд дайчлахад анхаарах,
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийг сумын эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх арга хэрэглүүр болгон ашиглах,



***Арга зүйн асуудлууд.*** Сумын ЭЗХ-ийн стратегийг боловсруулах ажлыг Нээлттэй Нийгэм Хүрээлэн, «Орон нутгийн удирдлага ба төрийн үйлчилгээг шинэчлэх санаачлага» хөтөлбөрөөс Дэлхийн Банктай хамтран боловсруулж Албани, Косово зэрэг орны хэд хэдэн хотуудын эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулахад хэрэглэгдэж баталгаажсан арга зүйгээр гүйцэтгэлээ. Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах үйл ажиллагааг процессийн хэмжээнд зөв зохион байгуулахад нэн зохимжтой, эмх цэгцтэйгээс гадна бизнесийн хөгжлийн орчинг бодлого, зорилготой сайжруулахад чиглэгдсэн алсын хараа, зорилго, зорилт, түүнчлэн төслүүдийг дунд хугацааны баримжаатайгаар олон нийтийн оролцоо, харилцан ойлголцолд тулгуурлан боловсруулахад тохиромжтой хэмээн энэхүү арга зүйг сонгосон болно.

Орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, идэвхжүүлэх үйл ажиллагааг стратеги боловсруулах арга зүйн хүрээнд хамтруулан хэрэгжүүллээ. Юуны өмнө, бизнес хөгжихөд ахиц өөрчлөлт авчрах тэнцвэржсэн орчин бүрдүүлэх замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт бий болгоход сумынхны хүчин чармайлт, байгаа нөөц боломжийг уялдуулан зохицуулах асуудал стратеги боловсруулах арга зүйн үндэслэл болсон юм.

## 2.2. Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын ба зохицуулалтын арга хэмжээ

Стратеги боловсруулахад баримталсан зохион байгуулалтын зарчим нь сумын ЗДТГ, төслийн үндсэн багаас гадна олон нийт, оролцогчдыг стратеги боловсруулах үйл ажиллагаанд түншлэлийн журмаар зохион байгуулалттайгаар шууд оролцуулах боломжийг хангахад чиглэгдсэн болно. Энэ зорилгоор сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээтэй холбогдсон арга хэмжээг хариуцсан бие даасан төлөөллийн бүтцийг сумын ИТХ юм уу Засаг даргын шийдвэрээр томилж ажиллуулах замаар иргэдийн оролцоог үндсэнд нь хангалаа.

***Төлөвлөлтийн Комисс.*** Баянхонгор сумын ИТХ-ын 2007 оны 1 дүгээр сар 08-ний өдрийн 02 тоот тогтоолоор Төлөвлөлтийн комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсан болно. Засаг даргаар ахлуулсан тус комисс стратеги боловсруулах ажлыг зохицуулалт, удирдамжаар хангах, явцыг үнэлэхтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахад гол үүрэгтэй ажиллаж ирлээ.

СЭЗХ–ийн стратеги боловсруулахад оролцсон төлөөллийн бүтэц



Сумын эдийн засаг-бизнесийн хөгжлийн асуудлаар зөвшилцөх, шийдвэр гаргахад оролцох мэдлэг, дадлага туршлага, чин хүсэл зэргээр нь төлөвлөлтийн комиссын бүрэлдэхүүнд оруулах хүмүүсийг сонгов. Сумын засаг дарга болон ИТХ-ын дарга, төслийн үндсэн багийн гишүүдээс гадна комиссын удирдлагын дор байгуулагдсан ажлын хэсэг тус бүрээс 2-3 хүнийг комисст орууллаа.

**Төлөвлөлтийн комиссын бүрэлдэхүүн:**

Комиссын дарга: **М.Цогт**
Сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч

Нарийн бичгийн дарга: **Э.Мөнхтуяа**
Сумын бизнес хөгжлийн албаны менежер

Гишүүдэд:

1. **Л.Доржхорлоо**
   Сумын ИТХ-ын дарга
2. **С.Лочинлхам**
   Төслийн үндсэн багийн ахлагч, Засаг даргын орлогч бөгөөд төрийн сангийн төлөөлөгч
3. **П.Баатар**
   Төслийн үндсэн гишүүн, хотын менежер, дэд бүтэц хариуцсан түшмэл
4. **Ж.Билгүүн-Очир**
   Төслийн үндсэн багийн гишүүн, «Барууншанд» ХХК-ийн захирал
5. **Л.Гүрсэд**
   Төслийн үндсэн багийн гишүүн, сумын ЗДТГ-ын статистикч
6. **Д.Оюундэлгэр**
   ХҮДС-ийн захирал
7. **Ш.Лхагвасүрэн**
   ЗДТГ-ын дарга, ерөнхий менежер
8. **Ч.Батсүх**
   «Гэгээн шавь» багийн засаг дарга



9. **Ж.Алтанцэцэг**
   «FM-107» радиогийн захирал
10. **Ө.Амаржаргал**
    Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
11. **Ц.Эрдэнэ-Очир**
    Аймгийн Халамж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
12. **Г.Энхтүвшин**
    «Галт идэр» ХХК-ийн захирал
13. **Ж.Төмөрбаатар**
    «Унага трейд» ХХК-ийн захирал

Төлөвлөлтийн комисс нь стратеги боловсруулах үйл ажиллагааг зохицуулахаас гадна төрийн ба хувийн хэвшлийн байгууллагуудын идэвхтэй, чин эрмэлзэлтэй оролцоог хангах, тэдний дунд өргөн хүрээтэй ярилцлага, зөвшилцлийг олон хэлбэрээр зохион байгуулах, өрнүүлэхэд анхаарч ирлээ. Энэ комисс стратегийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт үнэлгээгээр хангах, шаардлагатай засвар өөрчлөлтийн асуудлаар нэгдсэн шийдвэр гаргах чиглэлээр ДЕЛТА төсөл дууссаны дараа үргэлжүүлэн ажиллах юм.

**Т*өслийн үндсэн баг.*** Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулах бүтцийн цөм болж ажилласан төслийн үндсэн баг нь энэ ажилд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд цаашдаа стратегийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, засвар өөрчлөлт оруулах үндэслэл, санал боловсруулах асуудлыг хариуцан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах болно. Төслийн үндсэн баг нь төсөл хэрэгжүүлэгч ба гүйцэтгэгч байгууллагууд, түншүүд болон эдийн засгийн хөгжлийн асуудлыг сонирхон оролцох хүсэлтэй иргэд, байгууллагуудтай хамтран ажиллахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн болно.

Төслийн үндсэн багийг сумын Засаг даргын 2006 оны 07 сарын 26-ны өдрийн 91 тоот захирамжаар доорх бүрэлдэхүүнтэйгээр томилж ажиллууллаа.

Багийн ахлагч: **С.Лочинлхам**
Сумын Засаг даргын орлогч, төрийн сангийн төлөөлөгч
Багийн гишүүд:

1. **Л.Гүрсэд**
   Сумын ЗДТГ-ын статистикч
2. **П.Баатар**
   Баянхонгор хотын менежер
3. **Ж.Билгүүн-Очир**
   «Барууншанд» ХХК-ийн захирал
4. **Э.Мөнхтуяа**
   Бизнес хөгжлийн албаны менежер




Төслийн үндсэн багт эдийн засагч, технологич, инженер зэрг янз бүрийн мэргэжлийн хүмүүсийг ажиллуулсан нь стратегийг иж бүрэн, үндэслэл сайтай, мэргэжлийн түвшинд боловсруулахад ач холбогдолтой болов.

***Ажлын хэсэг.*** Сумын хөгжлийн стратеги боловсруулахад зөвлөх үүрэгтэй ажлын 4 хэсэг байгуулж төлөвлөлтийн комиссын шууд удирдлагын дор ажиллуулав. Ажлын хэсэг бүр янз бүрийн төлөөллийг оролцуулсан 10-аас дээш гишүүнтэй, дотроо сумын ИТХ-аас 2-оос доошгүй хүнийг төрийн удирдлагын ажлын хэсэгт заавал оруулах зарчим баримтласан бөгөөд төслийн үндсэн багийн нэг гишүүн ажлын хэсгийн ахлагчаар ажиллав. Ажлын хэсэг байгуулсан гол зорилго нь олон нийтийн оролцоог төлөөллийн журмаар хангах боломжийг өргөжүүлэх явдал байлаа. Ийнхүү ажлын хэсгүүд олон нийтийг ДЕЛТА төслийн суман дахь баг, бүтцүүдтэй холбох үүргийг чухлаар гүйцэтгэж ирлээ.

**Төрийн удирдлагын төлөөлөл:**

1. **С.Лочинлхам**
   Сумын засаг даргын орлогч, эдийн засагч ня-бо
2. **Д.Дондог**
   Аймгийн ЗДТГ-ын ажилтан, малын эмч
3. **Г.Батжаргал**
   Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, инженер
4. **Г.Цэрэн**
   Аймгийн ТӨХ-ны дарга, инженер

5. **Г.Жигжидсүрэн**
Аймгийн ерөнхий агрономич, агрономич
6. **М.Цог**
Сумын засаг дарга, багш
7. **Л.Доржхорлоо**
Сумын ИТХ-ын дарга, ня-бо
8. **Д.Батжаргал**
Сумын ИТХ-ын төлөөлөгч, хуульч
9. **Ш.Лхагвасүрэн**
Сумын ЗДТГ-ын дарга, инженер
10. **Ч.Батсүх**
YI багийн засаг дарга, малын эмч
11. **С.Балжинням**
YII багийн засаг дарга, кино механикч
12. **Х.Цэцгээ**
ЗДТГ-ын халамжийн ажилтан, ня-бо
13. **А.Тарва**
III багийн засаг дарга, мал зүйч
14. **Б.Оюун**
IY багийн засаг дарга, малын эмч
15. **Д.Уугацэцэг**
Y багийн засаг дарга, эдийн засагч
16. **С.Готов**
YIII багийн засаг дарга, малын эмч

**Иргэний нийгмийн төлөөлөл:**

2. **П.Баатар**
ЗДТГ түшмэл, ня-бо
3. **Б.Базар**
Өндөр настан, инженер
4. **Д.Алтанзаяа**
Дэлхийн зөн ОУБ-ын ажилтан, эмч
5. **И.Базардарь**
10 жилийн I сургуулийн багш, нийгмийн ажилтан
6. **Н.Мэндбаяр**
Халамжийн албаны мэргэжилтэн, багш
7. **Д.Баасанхүү**
Хүүхдийн төлөө төвийн дарга, багш

17. **Л.Цэрэндолгор**
Сумын ЗДТГ-ын нягтлан бодогч, нягтлан бодогч
18. **Ө.Амаржаргал**
Сумын ИТХ нарийн бичгийн дарга, багш
19. **Ц.Алзахгүй**
Сумын ИТХ-ын ажилтан, нягтлан бодогч, эдийн засагч
20. **Н.Оюун**
II багийн засаг дарга, бараа судлаач
21. **Д.Цэрэнхорлоо**
Өрхийн эмч, эмч
22. **Ш.Хүрэлбаатар**
Сумын газрын даамал, газар зохион байгуулагч
23. **С.Батсүрэн**
Сумын ЗДТГ-ын ХХАА-н байцаагч, мал зүйч





8. **Г.Болортунгалаг**
Баянхонгор телевизийн сурвалжлагч, сэтгүүлч

9. **Б.Олзвой**
   «Шинэ үе-залуучууд холбоо»-ны тэргүүн, сэтгүүлч
10. **М.Мөнхбат**
   Татварын албаны дарга, ня-бо эдийн засагч
11. **Ж.Алтанцэцэг**
   «FM-107» радиогийн захирал, сэтгүүлч/сурвалжлагч
12. **Р.Дагдан**
   ЭХҮйлдвэрийн дарга, инженер
13. **А.Хоогой**
   Өндөр настан, сэтгүүлч
14. **Л.Цэдэндамбаа**
   Өндөр настан, хуульч
15. **Ц.Рэнбуу**
   ХЭАХНийгэмлэгийн дарга, эмч
16. **Д.Өлзий**
   Өндөр настан, багш
17. **М.Бадам**
   Өндөр настан, улс төр судлаач
18. **Д.Даваадорж**
   МОНЦАМЭ-ийн сурвалжлагч, сурвалжлагч
19. **Ц.Очирбал**
   ХААХ Холбооны тэргүүн, эдийн засагч
20. **С.Баярмагнай**
   Говийн санаачлага төслийн зохицуулагч, багш
21. **М.Бямбаа**
   «Би Энхтөгөлдөр» ХХК-ийн захирал, инженер
22. **М.Батбаяр**
   Улс төрийн ажилтан, багш

**Төрийн үйлчилгээний төлөөлөл:**

2. **Л.Гүрсэд**
   Сумын статистикч, статистикч
3. **Д.Гэрэлээ**
   Нэгдсэн эмнэлгийн сувилагч
4. **С.Очирхуяг**
   Өрхийн эмч, эмч
5. **Ц.Эрдэнэ-Очир**
   Халамжийн албаны мэргэжилтэн, багш
6. **С.Баасанхүү**
   Нэгдсэн эмнэлгийн эрхлэгч, эмч
7. **Х.Пүрэвбаатар**
   «Аврал» ТББ-ын захирал, багш
8. **Н.Сайханцэцэг**
   ЗДТГ-ын нийгмийн ажилтан, багш
9. **Ш.Чимгээ**
   МСҮТөвийн захирал, багш
10. **Ю.Адъяа**
   БМДС-ийн захирал, эдийн засагч
11. **Н.Оюундэлгэр**
   ХҮДС-ийн захирал, эдийн засагч



12. **Д.Нацагдорж**
   МХ Газрын улсын байцаагч, мал зүйч
13. **Л.Баатар**
   МХГазрын улсын байцаагч, малын эмч
14. **М.Хосбаяр**
   «Чандмань» ХХК-ийн захирал, инженер
15. **Л.Мандал**
   Аймгийн БОА-ны дарга, инженер

16. **Г.Мандал**
    Дэд бүтцийн албаны дарга, инженер
17. **Т.Эрдэнэбат**
    Холбооны газрын дарга, инженер
18. **С.Оюунбилэг**
    «Соого Сейко» сургуулийн захирал, багш
19. **Б.Лхагвасүрэн**
    Монгол банкны захирал, эдийн засагч
20. **Б.Төмөрбаатар**
    ХААН банкны захирал, бараа судлаач
21. **Х.Ганбаатар**
    Аймгийн архитектор, архитекторч
22. **В.Гүрсэд**
    Хот тохижилт ойжуулалтын албаны дарга, инженер

**Бизнесийн төлөөлөл**

2. **Ж.Билгүүн-Очир**
   «Баруун шанд» ХХК-ийн захирал, багш
3. **Ж.Баярмаа**
   Татварын улсын байцаагч, ня-бо
4. **А.Энх-Амгалан**
   «Дэс булаг» ХХК-ийн захирал, багш
5. **Ч.Даариймаа**
   ЗДТГ-ын түшмэл, эдийн засагч
6. **П.Ренчинпэлжээ**
   «РМБ» ХХК-ийн захирал,
7. **Ц.Нарантуяа**
   Захын менежер, соёлын ажилтан
8. **Д.Гэрэлмаа**
   «Совин» төвийн эзэн, соёлын ажилтан
9. **М.Өлзий**
   Дунд захын эзэн, багш
10. **Ц.Даваасамбуу**
    «Наран» цехийн эзэн, инженер
11. **Д.Ирина**
    Захын менежер, улс төр судлаач
12. **Д.Дамбасүрэн**
    «Дулаан» ХХК-ийн захирал, инженер
13. **Д.Пүрэвсүрэн**
    «Зүүн шанд» ХХК-ийн захирал, ня-бо/эдийн засагч
14. **И.Батдэлгэр**
    «Сүлдэн тэнгэр» хоршооны эзэн, жолооч
15. **Ц.Батмөнх**
    «Ган мөнхжин»-ХХК-ийн захирал, инженер



16. **Д.Надмид**
    «Хонгорын сор»хоршооны эзэн, ня-бо/эдийн засагч
17. **Д.Батжаргал**
    «Чандмань» ХХК-ийн инженер, инженер
18. **Х.Наранчимэг**
    «Дорнын гэгээ» ХХК-ийн захирал, багш
19. **Ж.Төмөрбаатар**
    «Унага трейд» ХХК-ийн захирал, инженер
20. **Д.Сономдорж**
    «Наран ээж» ХХК-ийн захирал, жолооч
21. **Г.Энхтүвшин**
    «Галт идэр» ХХК-ийн захирал, инженер
22. **С.Өлзийжаргал**
    Бизнес эрхлэгч, оёдолчин

## 2.3. Олон нийтийн оролцоо ба зөвшилцөл

Сумын эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх олон нийт хүлээн зөвшөөрсөн, хэрэгжих боломжтой чиглэлүүдийг үзэл баримтлал сайтай, хэтийн баримжаатай, чанартай боловсруулах явдал сумын төр, захиргааны хувьд нэлээд тулгамдсан асуудал байсаар ирсэн билээ. Гэхдээ хөгжлийн стратегиэ ямар арга зүйгээр боловсруулахаа бүрэн гүйцэд төсөөлж чадаагүй, сумынхаа иргэд, байгууллагуудыг оролцуулах арга замаа үндэслэлтэй төлөвлөөгүй явж ирсэн тал байсныг ил тод хэлэх нь зүйтэй. Сумын эдийн засгийн хөгжлийн асуудлыг дан ганц захиргааны үүрэг, хариуцах ажил мэтээр ойлгодог явдал олон нийтийн дунд түгээмэл байсны дээр тэд өөрсдөө энэ үйл ажиллагаанд оролцож, хувь нэмэр оруулах иргэний үүргээ төдийлэн сайн ухаараагүй явж ирсэн тал ч бий.

Сумынхаа хөгжлийн үйл явцад хувь нэмрээ оруулах иргэний мэдлэг ойлголтыг батжуулах, чин эрмэлзлийг дэмжихэд төсөл эхлэхээс анхаарч зохих арга хэмжээ авч ирлээ. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн эхний шатны арга хэмжээ болох бизнес орчны судалгаа, СВОТ шинжилгээ нь иргэд, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн төлөөллийг хангалттай хэмжээнд хамарч чадсан юм. Түүнчлэн олон нийтэд ойлголт өгөх, оролцоог өрнүүлэх арга хэмжээг уулзалт, ярилцлага, багийн иргэдийн хурал зэрэг арга хэмжээний үед таниулан сурталчлах, мэдээлэл гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах зэргээр хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнд сумынхаа иргэдийн дийлэнхи олонхид нь тодорхой мэдээлэл хүргэж чадсан явдал төслийн ажил анхнаасаа оролцоог сайтар хангаж, олон нийтийг идэвхжүүлж чадсаныг гэрчилнэ.

Сумын ЭЗХ-ийн стратеги боловсруулахад төр, захиргаа, бизнес эрхлэгчид, төрийн үйлчилгээний болон олон нийт, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, хувь хүмүүс зэрэг нийтдээ 80-аад хүн албан үүргийнхээ дагуу болон төлөөллийн журмаар шууд оролцов. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажил, арга хэмжээнд аль болох олон байгууллага, хүнийг оролцуулахыг байнга хичээж ажилласны үр дүнд хүмүүсийн сэтгэлгээнд өөрчлөлт орж, төсөл, түүний үр дүнг жинхэнэ «өмчлөгчид» болохоо ойлгох, мэдрэх чухал нөхцлийг бүрдүүлж чадсан гэж үзэж байна.

## 2.4. Бизнесийн орчны судалгаа

Бизнесийн орчны судалгаа явуулах, түүний үр дүнг сумын эдийн эасаг-нийгмийн хөгжлийн олон жилийн үзүүлэлтүүдээр баталгаажуулах нь сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшин, өрсөлдөх чадвар, хэтийн төлөв, тулгамдаж буй асуудлыг үндэслэл, баримжаа сайтай тодруулах хамгийн боломжтой арга хэрэгсэл юм.

Бизнесийн орчны судалгааны хүрээнд бизнесийн хөгжил, орон нутгийн бизнесийг дэмжих орчны асуудлаар оролцогчдын санал бодол, үнэлэмжийг судлах санал асуулгыг таван бүлэгт хамаарах 41 асуултаар явуулснаас гадна сумын эдийн засгийн үндсэн статистик үзүүлэлтүүд болон бусад мэдээллийг сүүлийн 5-10 жилийг хамруулан цуглуулж, дүн шинжилгээ хийлээ. Бизнесийн орчны судалгааны дүнг СВОТ шинжилгээ хийх, цаашилбал бизнес орчны талаар сумын ЭЗХ-ийн стратегид тусгагдах гол үндэслэл, дүгнэлтүүдийг томъёолох суурь материал болгон ашиглав.

Эдийн засгийн хөгжлийг дэмжих, бизнес хөгжих таатай орчин бүрдүүлэхэд сумын төр, захиргааны зүгээс эдүгээ гүйцэтгэж буй үүргийг хувийн хэвшлийнхний үнэлгээнд тулгуурлан тодорхойлсон явдал энэ судалгааны нэг чухал үр дүн болсон юм. Тухайлбал:

1. Орон нутгийн бизнес эрхлэгчдийн санал дүгнэлтийг ул суурьтай таньж ойлгоход шаардлагатай мэдээ, тоо материал, баримт мэдээл цуглуулах
2. Сумын эдийн засаг-нийгмийн амьдралд оршин буй давуу ба сул талууд, бизнесээ өргөжүүлэх, өсөлт бий болгох, хадгалахад бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлуудтай холбоо бүхий мэдээ баримт хуримтлуулах
3. Бизнесийн орчинг сайжруулах, боловсронгуй болгох шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тухай бүр нь мэдэрч ажиллахын тулд орон нутгийнхны үнэлэмж, санал бодлыг судлах зэрэг болно.

Энэ судалгааг бүх шатанд амжилттай зохион байгуулж явуулахад бид бүх талаар анхаарч ажилласныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сумынхаа бизнес эрхлэгчдийг судалгаанд өргөн хамруулсны дээр тэдний гаргасан санал зөвлөмжийг ЭЗХ-ийн стратегид тусгасан явдал орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх шаардлага, арга замын талаар нийтлэг ойлголтод хүрэхэд чухал түлхэц өгсөн юм. Ийм байдлаар сумын эдийн засгийн өсөлтөд жинтэй нөлөө үзүүлсээр ирсэн, цаашдаа ч энэ нөлөө нь улам өсөх бизнесийн бүлгүүдийн санал үнэлэмжийг сумынхаа ЭЗХ-ийн стратегид тусгах үндсэн мэдээллээр хангаж өгсөнд бизнес орчны судалгааны ач холбогдол оршиж байгаа гэж үзэж буй болно. Төр-хувийн хэвшлийн түншлэлийг тогтворжуулах, сумын ЭЗХ-ийн стратегийг байнга хянан сайжруулах урт хугацааны удирдамж болох талаасаа бизнесийн орчны судалгааны үр дүн, дүгнэлтүүд чухал ач холбогдолтой юм.

## 2.5. СВОТ шинжилгээ

Бизнес орчны судалгааны дүнг задлан шинжлэх, сумын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох, бизнесийн орчныг сайжруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх стратегийн чиглэлүүдийг тогтоох зорилгоор СВОТ шинжилгээг явууллаа. Сумын бизнес эрхлэгчдэд тулгарч

байгаа гол асуудлуудыг тодорхойлж, үр дүн нь эерэг болон сөргөөр илэрч болох бүх талууд, тэдгээрийн зохистой шийдлийг хослолоор зэрэгцүүлэн томъёолоход СВОТ шинжилгээний зорилго, хандлага чиглэгдсэн болно. Ингэснээр эдийн засгийн хөгжлийн төсөөлөн буй зорилгодоо хүрэх хамгийн зохистой, хэрэгжих боломжтой хувилбарыг сонгож сумын ЭЗХ-ийн стратегийг дээр дурьдсан хандлагад тулгуурлан боловсруулах үндэслэлийг тодорхойлж чадлаа.

Давуу тал ба боломжийг өндөр үр дүнд хүрэх стратегийн ирээдүйн чиглэл гэдэг агуулгаар авч үзэн нягтлан тодруулахад СВОТ шинжилгээ чухал хэрэглүүр болж өглөө. Үүний чацуу оршин буй сул тал ба саад бэрхшээлийг даван туулахын тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойллоо. Сумын эдийн засгийн хөгжил, бизнес орчны өнөөгийн байдлыг нарийвчлан үнэлэх, эдийн засгийн хөгжлийн стратегийн гол шийдлийг СВОТ шинжилгээгээр тогтоолоо.

СВОТ шинжилгээг хийхдээ бизнес орчны судалгаанаас гарсан дүгнэлтийг сумын олон нийтээр хэлэлцүүлсэн дүн, эдийн засгийн холбогдох судалгаанд илүүтэй түшиглэсэн болно. Төрийн үйлчилгээ, бизнесийн хөгжлийн чиглэлээр СВОТ шинжилгээний матрицийн 4 элементийг тодорхойлсноор «Давуу тал-Боломж», «Давуу тал-Саад бэрхшээл», «Сул тал-Боломж», «Сул тал-Саад бэрхшээл»-ийн СВОТ хослолыг нарийвчлан шинжлэх боломж хангагдсан юм. Базаж хэлбэл, сумын ЭЗХ-ийн стратегийн алсын хараа, зорилго, зорилтыг томъёолж, төслүүдийг сонгоход СВОТ шинжилгээний дүн суурь мэдээлэл болж өглөө.

## 2.6. “Алсын хараа–зорилго–зорилт–хөтөлбөр–төсөл” матриц

***Алсын хараа:*** Сумын ЭЗХ-ийн стратегийн алсын хараа нь *с*умын нийт иргэдийн чин эрмэлзэл, хэтийн хүсэл тэмүүллийг тусгахаас гадна хэтийн ирээдүйд хүрэх түвшингийн талаархи тэдний төсөөллийг нэгтгэн илэрхийлдэг. Түүнчлэн стратегийн зорилго, зорилтод хүрэхэд олон нийтийг алсын хараа хөтөлнө. Нийгэм-эдийн засгийн ба бизнесийн хөгжил, эдийн засгийн чадавхи, байгалийн нөөц баялаг, бизнесийн дадлага туршлага, уламжлал, ёс заншил, язгуур урлаг зэрэг эдүгээ цагийн нөхцөл боломж, бодит байдал дээр тулгуурлан стратегийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлж өгдөг.

Нөөц боломжоо аль чиглэлд түлхүү зориулах, үр ашигтай дайчлан ашиглахад сумын захиргаа, олон нийтэд хөтөч болдог алсын харааг сумын эдийн засаг, бизнесийн хөгжлийн үйл явц, стратегийн үндсэн бүрдэл хэсгүүдийг цогцоор хамарсан, дунд хугацаанд хүрэх үр дүнгийн баримжаа чиглэлтэйгээр томъёолсон гэж үзэж байна.

Алсын хараа маань сумын эдийн засаг, байгаль орчин, ахуй соёл, түүхэн уламжлал дээр суурилсан болохыг нотлох онцлог нөхцөл байдлыг тодруулахыг оролдлоо. Алсын хараа уян хатан, стратегийг хэрэгжүүлэх явцад гарч болох өөрчлөлтөд нийцүүлэн хянан өөрчлөх, сайжруулах боломжтойгоор томъёологдсон болохыг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм.

***Зорилго:*** Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн стратеги нь угаасаа орон зайн ба цаг хугацааны хэмжүүрээр тодорхойлогдох дэвшил, ахиц өөрчлөлт бий болгох тухай асуудал билээ. Хүрч болох дэвшил, хэрэгжүүлэн бий болгох өөрчлөлтийг урьдчилан төсөөлж, тодорхойлох үндсэн дээр стратегийнхээ үр дүн, өгөөжийг хэрхэн томъёолохоо шийдэх чиг баримжаа авахад нь сумынхандаа дэмжлэг үзүүлэх үүднээс стратегийн зорилго тодорхойлох асуудалд хандсан юм. Алсын хараандаа амжилттай хүрэхэд хөтлөн залах үндсэн чиглэлийг тодорхойлохоос зорилгоо томъёолох ажлаа эхлэсэн болно. Сумын эдийн засгийн хөгжлийн нийтлэг ба тусгай асуудлуудад тулгуурласан, стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг багтаасан байх шаардлагыг тавьж ажиллалаа. Алсын хараа ба зорилтын амьд холбоог хангахуйцаар зорилгоо томъёолоход анхаарлаа.

***Зорилт:*** Зорилгоор дамжин алсын хараанд хүрэх, түүнчлэн хөтөлбөр, төсөлтэй зорилгыг холбох чухал хэрэглүүр нь зорилт юм. Стратеги болон тусгайлсан зорилго, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх боломжийг хангах үүднээс зорилтыг хүрэх түвшингийн үзүүлэлт, тоон хэмжигдэхүүнтэйгээр томъёолох зарчмыг баримтлалаа. Товчхон хэлэхэд, зорилтыг зорилгын шууд үргэлжлэл байхаар төсөөлж ажилласан болно. Сумын бизнес орчны судалгаа, СВОТ шинжилгээгээр тогтоогдсон давуу талаа бэхжүүлэх, сул талаа даван туулах, боломжийг зөв ашиглах, саад бэрхшээлийг үндэслэлтэй тооцож ажиллах боломжийг стратегийн зорилтууд сумынханд олгож байгаа юм.

***Хөтөлбөр:*** Хамтад нь хэрэгжүүлснээр тодорхой зорилт хангагдах талаас нь харж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр нь төслүүдийг бүлэглэх замаар томъёолсон хэд хэдэн хөтөлбөрийг стратегид оруулаа. Өөрөөр хэлбэл, зорилтыг зорилгоос шууд салбарлуулан гаргахад төвөгтэй байсны учир хөтөлбөрийг ийнхүү завсрын шатлал маягтайгаар боловсруулсан юм. Цаашдаа төслүүдийг нэгтгэн бие даасан томоохон хөтөлбөр боловсруулах суурь материал болох учраас стратегийн хөтөлбөрт ийнхүү ач холбогдол өгсөн болно.

***Төсөл:*** Уламжлалт аргачлалаар бол стратеги төлөвлөгөө боловсруулах ажил үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр үндсэндээ шувтардаг билээ. Харин үйл ажиллагааны төлөвлөгөөний оронд тодорхой хөтөлбөрөөс уламжлуулан боловсруулсан харилцан холбоо бүхий төслүүдийг стратегидээ тусгасан нь бидний хэрэглэсэн арга зүйн шинэлэг хандлага боллоо. Ийнхүү төсөл нь «алсын хараа-зорилго-

зорилт-хөтөлбөр-төсөл» гэсэн гинжин холбооны төгсгөл хэсэг болж байгаа юм. Товч танилцуулгыг төсөл тус бүрээр боловсруулж стратегид тусгасан болно. Төслийн танилцуулгад товч тодорхойлолт, хүлээгдэж буй үр дүн, зорилтот бүлэг, төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид, боломжит хувь нэмэр оруулагчид, урьдчилсан боломж, зэхэц нөхцөл, эрсдэлтэй хүчин зүйлс, шаардагдах хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх хугацаа, үр дүнгийн тогтворжилтийн талаархи товч мэдээллийг багтаалаа.

Тодруулан хэлэхэд, төсөл сонгох, боловсруулах ажлыг хэд хэдэн шат дамжлагатайгаар хэрэгжүүлсэн болно. Тухайлбал, олон нийтийн хэлэлцүүлэг, ажлын хэсгүүдийн саналыг төслийн үндсэн багийн хэмжээнд нэгтгэн боловсруулж гаргасан хувилбарыг Төлөвлөлтийн комиссоор хэлэлцэн зохих засвар, нэмэлт өөрчлөлт оруулж төслүүдийг эцэслэн боловсруулла. Баянхонгор сумын эдийн засгийн хөгжлийн стратегид нийтдээ 50 төсөл тусгагдсан болно.

***Бизнесийн хөгжлийг дэмжих стратеги чиглэлүүд.*** Эдийн засгийн өсөлт бий болгох, сум орноо хөгжүүлэхэд нутгийн бизнесийн үүрэг онцгой чухал учраас бизнесийн хөгжлийг дэмжих стратеги чиглэлүүдийг оролцогчдын хамтаар тодорхойлж стратегид тусгаж өглөө. Нийтдээ 38 чиглэлийг товчилсон тодорхойлолттойгоор энэхүү стратегид оруулав. Төслийн үндсэн баг, ажлын хэсгүүд, Төлөвлөлтийн комиссын шугамаар болон олон нийттэй хийсэн уулзалт, хэлэлцүүлэг, зөвшилцөөнөөр дээрхи чиглэлүүдийг тогтоосон юм.

## 2.7. Хүлээгдэж буй үр дүн

Сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлснээр олон талтай, тооны хувьд ч цөөнгүй чухал үр дүн гарна хэмээн төсөөлж байгаа бөгөөд хүлээгдэж буй зарим гол үр дүнг тодруулбал:

- Сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд сумаас оруулах хөрөнгө, хувь хандивыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгах асуудлыг шийдвэрлэхэд ИТХ, Засаг дарга, ЗДТГ-т чиглэл өгөх,
- Стратегийн дэд хэсгүүдийн хэрэгжилтийг хариуцсан алба, байгууллага, ажилтны үйл ажиллагааг зохицуулах чадавхи, боломжийг дээшлүүлэх,
- Стратегид тусгагдсан тэргүүлэх чиглэл төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран санхүүжүүлэх боломж өргөжих,
- ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэхэд оролцох, хувь хандив оруулах сонирхол бүхий орон нутгийн, үндэсний, олон улсын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, хандивлагчдыг татах, тэдэнд хандах боломж сайжрах,

- Сумын эдийн засгийг хөгжүүлэх чадавхи, орон нутгийн нөөц боломж тодорхойлогдсон, ашиглалт, эргэлтэд зохих хэмжээгээр орсон байх,
- Бизнес, бизнес орчны холбогдолтой мэдээллийн сүлжээ бий болж төлөвших, бэхжих,
- Төрийн үйлчилгээний байгууллагын чадавхи дээшилж, үйлчилгээний чанар сайжрах,

## 2.8. Стратегийг хэрэгжүүлэх

ЭЗХ-ийн стратеги нь сумын төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдийг эдийн засаг-бизнесийг хөгжүүлэх бодлого, гол гогцоо асуудалд чиглүүлэх албан ёсны баримт бичиг мөн. Энэ агуулгаараа тухайн үеийн шаардлага, нөхцөл байдлаас хамаарч стратегийг байнга хянан өөрчилж, шинэчилж байх ёстой.

Манай сумын ЭЗХ-ийн стратегийг хэрэгжүүлэх ажил хоорондоо нягт уялдаа бүхий 4 үндсэн арга хэмжээгээр дамжин хэрэгжинэ.

- Санхүүгийн эх үүсвэрийг идэвхжүүлэх, санхүүжилт олох,
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх,
- Хяналт үнэлгээг хугацаатай төлөвлөн хэрэгжүүлэх,
- Хянан сайжруулах, нэмэлт өөрчлөлт хийх,

Стратеги хэрэгжих хугацаа сумын одоогийн ба дараачийн сонгуулиар томилогдох удирдлагын бүрэн эрхийн хугацаанаас урт байх учраас түүний хувь заяа нь шинэ удирдлага үйл ажиллагааны залгамж чанарыг хэрхэн хадгалж, олон нийтийн оролцоог хэр зэрэг хангаснаас ихээхэн хамаарна.

Стратегиэ хэрэгжүүлэх гол оролцогч болохын хувьд хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр олох, гаргах үүрэг хариуцлага сумын төр, захиргаанд ногдож байгааг бид ойлгож ажиллах ёстой. Ер нь стратегийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах санал бэлтгэх, ИТХ-аар батлуулах асуудлыг сумын ЗДТГ хариуцах нь зүйтэй гэж үзэж буй болно. Өөрөөр хэлбэл, стратегийн болоод төслийн хэрэгжилтийг зохицуулах, стратегийг хянах, зохих нэмэлт өөрчлөлт оруулж байх асуудлыг Төлөвлөлтийн комисстой хамтран сумын ЗДТГ санаачилж, гаргасан шийдвэрийн биелэлтийг хариуцах юм. Санхүүгийн ба техник ажиллагааны туслалцаа дамжлэг авах асуудлаар сумын захиргаанаас хандивлагчид, засгийн газар, олон улсын байгууллага, хөрөнгө оруулагчдад хандаж, хамтран ажиллана.

Стратегийн хэрэгжилтийн явц гүнзгийрэхийн хэрээр энэ үйл явцад оролцох олон нийтийн сонирхол, идэвх дээшлэх нь мэдээж. Иймээс оролцогчидтой хамтран стратегийн хэрэгжилтийг байнга хянаж, үнэлж байх нь ололт амжилт, алдаа дутагдалдаа зарчмын дүгнэлт хийх, цаашилбал шинээр дэвшигдэн гарч ирэх асуудлуудыг оновчтой тодорхойлон стратегийн хүрээнд шийдвэрлэх боломжийг хангаж өгнө. Төсөл маань угаасаа сумынхны өмч учраас хяналт үнэлгээг хамтран хэрэгжүүлж байх үүрэг сумын удирдлага, олон нийтэд оногдох юм. Төлөвлөлтийн комисс энэ ажилд чухал үүрэг гүйцэтгэх болно.

## 2.9. Стратеги хэрэгжүүлэх зохион байгуулалтын асуудлууд

Стратегийн хэрэгжилт, хяналт үнэлгээний асуудлыг хариуцсан Төлөвлөлтийн комисс ажиллаж байгаа тухай өмнө өгүүлсэн билээ. Тус комисс жилдээ 1-2 удаа хуралдаж стратегийн хэрэгжилтийн талаар төслийн үндсэн багийн ахлагчийн тайлан, хяналт үнэлгээний дүнг авч хэлэлцэж зохих шийдвэр гаргаж байх юм. Түүнчлэн жилд нэг удаа, баримжаалбал арванхоёрдугаар сард ИТХ-аар стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж, стратегид оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар санал бэлтгэнэ. Комиссын бүрэлдэхүүн өөрчлөгдөж болох ч стратегийн хэрэгжилтийг бүх талаар дэмжих, хяналт үнэлгээ хийх ажил үүрэг нь хэвээр байх юм.

ЗДТГ нь стратегийн хэрэгжилтийг хангуулах асуудлыг шууд хариуцах ба дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

- Төлөвлөлтийн комисс, үндсэн багаас үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх,
- Стратегид нэр зааж тусгагдсан болон хэрэгжилтийн бусад үе шатанд шинээр оролцогчдоос хариуцах үйл ажиллагааг зохицуулах,
- Стратегийн хэрэгжилтийг олон нийтэд байнга мэдээлж, тэдний санал зөвлөгөөг тусгах, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх шинэ арга хэлбэрүүдийг санаачилж нэвтрүүлэх
- Стратегийн хэрэгжилтийн явцад 2 жил тутамд нэг удаа хяналт үнэлгээ хийж, стратеги хэрэгжиж буй байдал, тухайн үеийн шаардлага, нөхцөл байдалтай уялдуулан нэмэлт тодотгол хийх, ИТХ-аар батлуулах, бусад төсөл хөтөлбөрт тусгуулах

## 2.10. Стратегийн санхүүжилт

Улсын төсвөөс тодорхой хөрөнгө оруулалт авах талаар хөөцөлдөхийн чацуу орон нутгийн иргэд, нутгийн зөвлөл, бизнес эрхлэгчид, хандивлагчид, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудаас хөрөнгө оруулалт хийх явдлыг дээд зэргээр дэмжин ажиллаж, энэхүү стратегийг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудлыг хамтран шийдвэрлэх зорилт тавих юм. Орон нутгийнхнаас стратегид тусгагдсан арга хэмжээнд шууд хөрөнгө оруулах нь стратегийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх томоохон боломжийг хангана.



# БҮЛЭГ 3

# БАЯНХОНГОР СУМЫН ТАНИЛЦУУЛГА

## 3.1. Сумын нутгийн удирдлагын байгууллага, тэдгээрийн бүтэц

***Сум (хот) байгуулагдсан түүх.*** БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид (хуучин нэрээр)-ийн 1957 оны 115 тоот зарлиг, аймгийн АДХ–ын Гүйцэтгэх захиргааны мөн оны 91 тоот тогтоолоор Баянхонгор аймгийн төвд 3 хоринтой, хороо захиргааг байгуулснаар Баянхонгор сум (хот) бие даасан нэгж болох үндэс нь тавигджээ.

2004 оны 10 сард явагдсан орон нутгийн сонгуулийн дараа улс төрийн хоёр намын 25 төлөөлөл бүхий Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сум 7 баг (Номгон, Эрдэнэмандал, Дуурсах, Угалз, Цагаанчулуут, Гэгээн шавь, Цахир), Шаргалжуут



тосгон гэсэн нутгийн захиргааны 8 нэгжтэй. Сумын Засаг даргын тамгын газар төрийн сангийн төлөөлөгч, статистик, нийгмийн халамж, татвар, хүнс хөдөө аж ахуй, газар, байгаль орчин, нийгэм хамгаалал, иргэний бүртгэл мэдээлэл хариуцсан ажилтан, байцаагч нарыг оролцуулсан 30 гаруй хүн ажиллаж байна.

Баянхонгор хот нь байгуулагдсан цагаасаа орон нутгийн бие даасан хотын статустай байсныг 1992 оны шинэ үндсэн хууль батлагдсаны дараа хэрэгжүүлсэн засаг захиргааны шинэчилсэн хуваариар сум болгон өөрчилж Шаргалжуут тосгоныг харъяалуулснаар Баянхонгор сум байгуулагдсан юм. Гэхдээ Баянхонгор хотыг тус суманд харъяалуулсан учир сумын Засаг дарга нь хотын захирагчийн албыг хуулиар олгогдсон эрх хэмжээнд давхар хашдаг.

1945 оны 10 дугаар сарын 20-нд явагдсан БНМАУ-ын «Төрийн тусгаар тогтнолын төлөө» бүх нийтийн санал асуулгад Баянхонгор аймгийн иргэд улсын хэмжээнд

Нутгийн удирдлагын бүтэц



хамгийн түрүүнд саналаа 100 хувь өгсөн түүхэн үйл явдалд зориулан аймгийн төвд дурсгалын модон багана босгосон нь Баянхонгор хотын онцлог болсон юм. Энэхүү баганын суурин дээр БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойд зориулан 1974 онд босгосон шинэ багана хотын тус хотын ялгах тэмдэг болсон түүхтэй.

Баянхонгор сумын ЗДТГ–ын бүтэц



Баянхонгор сум нь эдийн засгийн Хангайн бүсэд багтана. Баянхонгор аймгийн хөгжлийн дунд хугацаа (2015 он хүртлэх)-ны хөтөлбөрт хил залгаа Баян-Овоо, Эрдэнэцогт, Эрдэнэцогт, Өлзийт зэрэг сумдыг хамарсан эдийн засгийн төв нь Баянхонгор хот байхаар төлөвлөгдсөн тул тус сумын ЭЗХ-ийн стратегийн алсын хараанд бүсийн төв болох гэсэн томъёолол тусгагдсан болно.



## 3.2. Гадаад харилцаа

«Нэг баг - нэг шилдэг бүтээгдэхүүн» хөдөлгөөний хүрээнд Япон улсын Ойта мужтай хамтран ажиллаж, шилдэг бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргах судалгаа хийх, бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа харилцан солилцох арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2002 оноос БНСУ, БНХАУ, Польш зэрэг улсуудтай хоёр талын харилцаа тогтоож, эдийн засаг-нийгмийн салбарт хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулж зарим ажлыг эхлүүлээд байна.

Цаашид хоёр талын хэлхээ холбоог улам өргөтгөх замаар сумынхаа эдийн засаг-нийгмийг хөгжүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, дэвшилтэт техник технологи, ноу-хау нэвтрүүлэх, гадаад худалдааг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад харилцаагаа өргөжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

## 3.3. Газар зүй, цаг уурын нөхцөл, байгалийн нөөц баялаг

***Газар зүйн байршил:*** Баянхонгор сум нь аймгийн нутгийн зүүн хэсэгт Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийт сумдтай хил залган тал хээрийн бүсэд далайн төвшнөөс 1845 метрийн өндөрт, 6.4 мянган хавтгай дөрвөлжин км талбай эзлэн оршино. Сумын төв нь Хангайн нурууны баруун өмнөд салбар Номгон уулын ар хормой, Түйн голын баруун эрэг дагуух элсэрхэг хөрстэй тал газар оршдог, хотыг цаашид тэлж өргөжүүлэх, барилгажуулахад тохиромжтой юм. Улаанбаатар хотоос 620, Арвайхээр хотоос 210, Алтай хотоос 400, Цэцэрлэг хотоос 195 км зайтай. Баянхонгор хотын дорхи газар 0.7 градус налуу, хөрсний усны динамик түвшин 6.0 метр тогтсон, хөрсний цэвдэгшилтгүй, байгалийн усны нөөц сайтай, газар чичирхийллийн балл 0.8 гэж тогтоогдсон нь цаашид тус хотыг өргөжүүлэн хөгжүүлэхэд тохиромжтой юм.

***Цаг уурын нөхцөл:*** Эх газрын эрс тэрс уур амьсгалтай, агаарын жилийн дундаж температур 0.5°C, олон жилийн дундаж дулаан +10.6°C, хамгийн халуун нь 7 дугаар сард тохиодог. Агаарын жилийн дундаж хүйтэн -11.6°C. Жилд дундажаар 238.2 мм тунадас унах ба хуртай жил 315.1 мм хүрдэг.

***Байгалийн нөөц баялаг:*** Сумын нутаг дэвсгэр нь хээр талын сийрэг өвсөрхөг болон бутлаг ургамалтай, газрын гадаргуу ерөнхийдөө тэгш, нам дор боловч, жижиг аараг толгод ихтэй Түй, Шаргалжуут зэрэг томоохон голын сав газар юм. Сумын нутаг дэвсгэр дэх байгалийн баялаг гүйцэд судлагдаагүй. Одоогоор төмрийн хүдэр, хүрмэн ба шохойн чулуу, сайн чанарын ааанги шавар, элс, хайрганы нөөц элбэгтэй, эдгээр нь сумын төвдөө ойрхон оршдог учраас барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж харьцангуй сайн. Тухайлбал, Номгон уулын хайрга сумын төвөөс 3 км, Шохойн булангийн шохой 6 км, Бумбатын шар шавар 12 км, Зээгийн элс 2 км-т байдаг. Эдгээр нөөцийг ашиглан жижиг үйлдвэрлэл хөгжүүлэх явдал тулгамдсан зорилт болж байна. Сумын төвөөс холгүй орших «Чулуу хагалаачийн дөрөлж»-өөс эрт дээр үед боржин чулуу бэлтгэж Ламын гэгээний хийдийг тохижуулж байсан ул мөр байдаг.

***Газрын нөөц:*** Аймгийн Газрын албаны мэдээгээр Баянхонгор сум нь 6400 га газартай. Хот суурингийн эдэлбэр 991.3 га газрын 77.9 га нь барилга байгууламжийн, 17.8 га нь үйлдвэрийн, 134.4 га нь гэр хорооллын, 767.6 га нь нийтийн эдэлбэрийн газарт хамаарна. Зам шугам сүлжээний 207.6 га газрын 55.3 га нь авто замын, 9.8 га нь агаарын тээврийн, 142.5 га нь эрчим хүчний үйлдвэрлэлийн, ойн сангийн 2.5 га газрын 1.5 га нь ойн, 1 га мод үржүүлгийн талбай, 47.4 га усан сан бүхий газрын 45.4 га нь ил усны, 2.4 га нь худаг бүхий газар байна.

Сумын газрын нөөц

| Газрын ангилал | | Хэмжээ, га | Газрын нөөцөд эзлэх хувь, % |
|---|---|---|---|
| Нийт нутаг дэвсгэр | | 6400.0 | 100.0 |
| 1. | ХАА-н эдэлбэр газар | 5145.2 | 80.4 |
| | • Бэлчээр | 5121.2 | 99.5 |
| | • Тариалангийн газар | 24.0 | 0.5 |
| 2. | Хот, суурины эдэлбэр газар | 991.3 | 15.5 |
| 3. | Зам, шугам сүлжээний газар | 207.6 | 3.2 |
| 4. | Усны эдэлбэр газар | 47.4 | 0.74 |
| 5. | Уул уурхайн газар | 6.0 | 0.09 |
| 6. | Ойн нөөц | 2.5 | 0.04 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Газрын алба, 2006*

## 3.4. Хүн ам зүй: өсөлт, хүний нөөц, чадавхи

***Хүн амын өсөлт.*** 2006 оны эцсийн байдлаар Баянхонгор суманд бүгд 26588 хүн суурин оршин сууж, үүнээс эмэгтэйчүүд 50.8 хувийг эзэлж байна. Нийт оршин суугчдын өсөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл 1999 онд хамгийн их буурснаа 2000 оноос аажмаар өсөх хандлагатай байна.

| 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2008 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23494 | 23293 | 19468 | 20501 | 22698 | 25150 | 26100 | 27160 | 26252 | 26588 |

***Хүн амын механик өсөлт.*** Хүн амын механик өсөлтийг сүүлийн 8 жилээр авч үзэхэд 2002 онд хамгийн өндөр байсныг эс тооцвол сүүлийн жилүүдэд буурч ирсэн байна. 2002 оноос өмнө механик өсөлт өндөр байсан нь зах зээлд шилжих эхний жилүүдэд хөдөөнөөс хот суурин руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн улс даяар нэлээд эрчимтэй явагдаж байсантай холбоотой. Түүнчлэн 1999-2002 онд тохиосон жил дараалсан ган, зудын улмаас малгүй болсон, малын тоо нь амьдралын хэрэгцээг хангахгүйд хүрч хорогдсон олон малчин өрх бусад сумдаас аймгийн төвд шилжин ирснээс өсөлт 2-3 дахин нэмэгдсэн юм. Сүүлийн жилд дээрхи шилжилт багассанаар механик өсөлт буурч байна. Харин нас баралт хэвийн үзүүлэлттэй байхад төрөлт буурч байгаа явдал хүн амын өсөлт саарахад зохих ёсоор нөлөөлж байна.

Хүн амын механик өсөлт, сүүлийн 8 жилээр

| | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төрөлт | 835 | 987 | 964 | 898 | 839 | 883 | 463 | 403 |
| Нас баралт | 116 | 121 | 142 | 173 | 182 | 135 | 192 | 188 |
| Шилжиж явсан | 319 | 339 | 309 | 493 | 427 | 574 | 494 | 366 |
| Шилжин ирсэн | 358 | 459 | 1120 | 2672 | 123 | 202 | 346 | 593 |
| Механик өсөлт | 758 | 986 | 1633 | 2904 | 353 | 376 | 123 | 442 |

*Эх сурвалж: Сумын статистикийн эмхтгэл, 2006*

***Хүн амын насны бүлэглэл.*** 2006 оны статистик мэдээгээр нийт хүн амын 30.4% нь 16 хүртэлх насны хүүхэд, 41% нь 35 хүртлэх насны залуучууд, 61-ээс дээш настай хүмүүс 6.7%-ийг тус тус эзэлж байна. Хүн ам ерөнхийдөө залуужих хандлагатай, ялангуяа нийт хүн амын 67.5%-ийг 35 хүртлэх насны хүүхэд, залуучууд эзэлж байгаа нь хүн амын өсөлтөд эерэг үзүүлэлт юм.

***Ажил эрхлэлт:*** Сүүлийн 3 жилийн дундажаар 9447 хүн ямар нэгэн ажил эрхэлж байгаа нь хөдөлмөрийн насны нийт хүний 56.5% нь ажлаар хангагдсан гэсэн үзүүлэлт юм. Ажил эрхлэгчдийн 44% нь эмэгтэйчүүд байна. Хүн амын дотор залуучуудын эзлэх хувийн жин өсч, ядуурал ихтэй байгаа өнөөгийн нөхцөлд сумынхаа бизнесийг өргөжүүлэх замаар ажлын байр бий болгох, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

Ажиллах хүчний тооны өөрчлөлт[1]

| Он | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тоо | 6032 | 6192 | 5132 | 4420 | 4788 | 5440 | 5564 | 7576 | 7606 | 7626 | 9447 |

*Эх сурвалж: Сумын статистикийн эмхтгэл, 2006*

2006 онд 935 хүн ажлын байраар хангагдсанаас 253 хүн байнгын ажлын байртай болжээ. Хөдөлмөрийн зах зээлд 933 хүн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамрагдаж 272 хүн шинээр мэргэжил эзэмшжээ. Хөдөлмөрийн насны 2874 хүн ерөнхий боловсролын сургууль болон их, дээд сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаагийн 60.6% нь эмэгтэйчүүд байна.

***Ажилгүйдэл:*** Тус сумын хувьд ажил эрхлэгчид ба ажилгүйчүүдийн тооны харьцаа нь шилжин ирэгсдийн тоотой чухал шүтэлцээтэй байдаг.

Ажилгүйдлийн үзүүлэлт

| Он | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тоо | 2144 | 3502 | 2957 | 2660 | 4216 | 5854 | 3598 | 3478 | 2241 | 2173 |

*Эх сурвалж: Сумын статистикийн эмхтгэл, 2006*

2001-2002 онд сумдаас аймгийн төвд шилжин ирэгсдийн тоо нэмэгдсэнээс дээрхи харьцаа нэлээд ойртож ирснийг жишээ болгон дурьдаж болох юм. Харин сүүлийн жилүүдэд ажилгүйчүүд нь цөөрөх байдлаар дээрхи харьцаа өөрчлөгдөж байгаа нааштай хандлагыг эндээс харж болно. 2006 оны эцсийн байдлаар ажил эрхлээгүй хүний 61.9%, хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа хүний 58.8% нь эмэгтэйчүүд байна.




[1] Цөөн мал бүхий болон орлогыг нь тодорхойлох боломжгүй бага орлоготой иргэдийн тоог оруулаагүй болно.



# БҮЛЭГ 4

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ОДООГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

## 4.1. Өрхийн амьжиргааны түвшин

2006 оны жилийн эцсийн байдлаар тус сумын нийт 6560 өрхийн бага орлоготой, ядуу, нэн ядуу 5096 өрхөд 19306 хүн байгаа нь нийт өрхийн 76.3% болж байна. Хүн амын 72.6% нь амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхөд хамаарагддаг. Дунд ба чинээлэг амьжиргаатай өрх 23.7%-ийг эзэлж байна. 2006 онд 49 өрх 2-3 өрөө орон сууц хувиараа барьж ашиглалтанд оруулсныг нэмж тооцвол бүх өрхийн 10 орчим хувь нь буюу 601 өрх тохилог орон сууцанд, бусад 5959 өрх гэр хороололд амьдарч байна.




## 4.2. Төсвийн санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт

Манай сумын төсөв сүүлийн 5 жилийн дүнгээр жил тутам 6-14.5%-иар өсөж ирлээ. Төсвийн орлого хэлбэлзлэл ихтэй байгаа нь тус сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй зарим үйлдвэр, байгууллагын орлогын албан татварыг аймгийн төсөвт шууд татдаг болсонтой холбоо юм. 2003 он хүртэл сум өөрийнхөө орлогоор бүрэн санхүүждэг байсан бөгөөд 2004 оноос «Төсвийн байгууллагын

Төсвийн орлого, зарлагын үзүүлэлт

| Үзүүлэлтүүд | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн нийт төсөв, сая төг** | 75.9 | 69.2 | 73.6 | 97.7 | 114.3 |
| **Орон нутгийн орлого, сая төг** | 75.9 | 69.2 | 24.5 | 31.5 | 48.8 |
| Орон нутгийн татвараас | 15.6 | 9.7 | 10.1 | 18.4 | 19.0 |
| Орон нутгийн тарифт төлбөрөөс | 57.8 | 57.1 | 13.0 | 11.9 | 28.4 |
| Бусад эх үүсвэрээс | 2.5 | 2.4 | 1.4 | 1.2 | 1.4 |
| **Төсвийн санхүүжилт, сая төг** | | | 49.6 | 66.2 | 65.5 |
| **Орон нутгийн орлого, %** | | | | | |
| Орон нутгийн татвараас | 20.5 | 14.0 | 41.8 | 58.7 | 38.9 |
| Орон нутгийн тарифт төлбөрөөс | 76.2 | 82.4 | 54.0 | 37.6 | 58.3 |
| Бусад эх үүсвэрээс | 3.3 | 3.6 | 4.2 | 3.7 | 2.8 |
| **Төсвийн санхүүжилт, %** | 3.2 | | 67.3 | 67.7 | 57.3 |

*Эх сурвалж: Сумын статистикийн эмхтгэл, 2006*




удирдлага, санхүүжилтийн тухай» шинэ хуулийг мөрдөх болсноор жилийн нийт төсвийн 57.3-67.7%-ийг улсын төсвөөс санхүүжүүлж байна.

Нийт зардлын 50.7%-ийг цалин хөлсөнд, 14.7%-ийг халаалтанд, 2.8%-ийг шатахуунд, 2.0%-ийг холбоонд, бусад зардалд 29.8%-ийг зарцуулсан байна. Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төслүүдийн хөрөнгө оруулалт мөнгөн илэрхийллээр 2006 онд 881.6 мянган төгрөгт хүрчээ. Орон нутгийн нийт төсөв ба орон нутгийн орлогын үзүүлэлт өсөх хандлагатай байгаа боловч нийт төсөвт орон нутгийн орлого 32.7-42.7%-ийг эзэлж байна.

Орон нутгийн төсвийн орлогын 38.9% нь орон нутгийн татвараас, 58.3% нь орон нутгийн тарифт төлбөрөөс, 2.8% нь бусад эх үүсвэрээс тус тус оржээ. Тус сум орон нутгийн төсвийн орлогыг давуулан биелүүлж ирлээ.

## 4.3. Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл, хамгийн өсөлтэй байгаа нь худалдаа, үйлчилгээний салбар бөгөөд сумын дотоодын нийт бүтээгдэхүүний 67.4%-ийг үйлдвэрлэж байна. Хүнс, хөдөө аж ахуй 19.4%, эрчим хүч, дулаан үйлдвэрлэл 8%, тээвэр, холбоо 4.8%, харин барилга, барилгын материал зэрэг бусад салбар дөнгөж 0.4%-ийг тус тус эзэлж байгаа юм. Тус сумын эдийн засагт голлох салбарын тоонд худалдаа, үйлчилгээ, мал аж ахуй орж байна.

Сумын хэмжээгээр 2006 оны байдлаар 12814.0 сая төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. 2005 оны эцсээр тус сум төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсоноор эрчим хүч дотоодын үйлдвэрлэл буурч, үүний улмаас ДНБ-ний өсөлт саарсан мэт харагдаж байна.

Сумын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сая.төг

| | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|---|---|---|---|---|
| Худалдаа | 116.4 | 134.3 | 123.4 | 147.6 | 835.5 |
| Үйлчилгээ | 5804.8 | 6309.9 | 6411.9 | 7169.0 | 7808.0 |
| Тээвэр | 20.0 | 26.0 | 28.0 | 29.2 | 31.4 |
| Холбоо | 392.3 | 471.2 | 547.5 | 562.3 | 592.6 |
| Эрчим хүч | 9374.7 | 8982.0 | 8622.9 | 3238.1 | 1028.6 |
| Мал аж ахуй | 1000.0 | 1300.0 | 1660.3 | 1990.0 | 2196.0 |
| Хүнс | 175.3 | 234.4 | 221.2 | 129.4 | 148.1 |
| Газар тариалан | 325.1 | 444.1 | 628.2 | 328.4 | 145.8 |
| Бусад | 149.3 | 50.5 | 70.7 | 26.9 | 28.0 |
| Дүн | 17357.9 | 17952.4 | 18314.1 | 13620.9 | 12814.0 |

*Эх сурвалж: Сумын статистикийн эмхтгэл, 2006*




Үнэн чанартаа, сумын ДНБ өсөлттэй байгаа нь эрчим хүчнээс бусад салбарын үйлдвэрлэл нэмэгдсэнээр нөхцөлдөж буй болно.

## 4.4. Төрийн байгууллага ба хувийн хэвшлийн үйл ажиллагаа

**Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбар.** Зах зээлд шилжихээс өмнө тус суманд байсан аж үйлдвэр, худалдаа, ахуйн үйлчилгээний улсын ба хоршооллын өмчийн байгууллагуудыг зах зээлийн шинэчлэлийн явцад татан буулгаж хувьчилсан билээ. Ийнхүү одоо үйл ажиллагаа явуулж байгаа хувийн аж ахуйн нэгж, компаний олонхи нь шинээр байгуулагдсан юм.




*Эх сурвалж: Сумын статистикийн эмхтгэл, 2006*



Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд Баянхонгор сумын ДНБ-ий 80 гаруй хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд нийтдээ 386 аж ахуйн нэгж, байгууллага бизнесийн тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Баянхонгор суманд 139 ХХК, 7 ХК, хадгаламж зээлийн 5 хоршоо, бусад үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг 71 хоршоо, 148 бичил бизнес эрхлэгч, 607 малчин өрх бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн ба хувийн хэвшлийн нийтдээ 1277 компани, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн бизнест 9540 гаруй хүн ажлын байраар хангагдан ажиллаж байна.

Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын судалгаа, 2006 оны байдлаар

| Сектор | Хувийн сектор | | Улсын сектор | | Бүгд | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нэгжийн тоо | Ажиллагсдын тоо | Нэгжийн тоо | Ажиллагсдын тоо | Нэгжийн тоо | Ажиллагсадын тоо |
| МАА | 607 | 1274 | | | 607 | 1274 |
| Газар тариалан | 142 | 320 | | | 142 | 320 |
| Хүнсний үйлдвэрлэл | 46 | 625 | | | 46 | 625 |
| Эрчим хүч, дулаан, ус | 6 | 269 | 2 | 87 | 8 | 356 |
| Барилга үйлдвэрлэл | 14 | 620 | | | 14 | 620 |

| Сектор | Хувийн сектор | | Улсын сектор | | Бүгд | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нэгжийн тоо | Ажиллагс-дын тоо | Нэгжийн тоо | Ажиллагс-дын тоо | Нэгжийн тоо | Ажиллагс-адын тоо |
| Уул уурхай | 2 | 349 | 1 | 178 | 3 | 527 |
| Бусад | 13 | 75 | | | 13 | 75 |
| **Дүн** | **830** | **3532** | **3** | **265** | **833** | **3797** |
| Худалдаа | 119 | 1429 | | | 119 | 1429 |
| Ахуйн үйлчилгээ | 21 | 321 | | | 21 | 321 |
| Тээвэр | 80 | 360 | | | 80 | 360 |
| Холбоо | 3 | 6 | 2 | 12 | 5 | 18 |
| Зочид буудал | 5 | 12 | | | 5 | 12 |
| Ресторан, гуанз | 51 | 308 | | | 51 | 308 |
| Бусад /ХЭАА, хоршоо/ | 91 | 162 | | | 91 | 162 |
| **Дүн** | **370** | **2598** | **2** | **12** | **372** | **2610** |
| Төрийн удирдлага | | | 10 | 350 | 10 | 350 |
| Санхүү, банк | 5 | 10 | 10 | 95 | 15 | 105 |
| Боловсрол | 1 | 40 | 6 | 1722 | 7 | 1762 |
| Эрүүл мэнд | 12 | 49 | 4 | 833 | 16 | 882 |
| Бусад | 24 | 34 | | | 24 | 34 |
| **Дүн** | **42** | **133** | **30** | **3000** | **72** | **3133** |
| **Бүгд** | **1242** | **6263** | **35** | **3277** | **1277** | **9540** |

*Эх сурвалж: Сумын статистикийн эмхтгэл, 2006*

Ажиллагсдын тоогоор нийт ажиллагсдын 40 орчим хувийг эзэлж байгаа үйлдвэрлэлийн салбар тэргүүлж, төрийн байгууллагууд ажлын байрны 1/3-ийг хангаж байна.

***Мал аж ахуй.*** Сумын ДНБ-д эзлэх хувийн жингээрээ хоёрдугаарт ордог МАА-н салбар нь сумын эдийн засагт ач холбогдол ихтэй хэвээр байна. Сумын малын сүргийн бүтцийг авч үзвэл, ямаа 49.5%, хонь 23.9%, үхэр 10.1%, адуу 2.7%, тэмээ 0.7%-ийг тус тус эзэлж байна. Нийт малын 96.5% нь малчид, мал бүхий иргэдийн 3.5% нь албан газар байгууллагын өмчид харъяалагддаг.



Малын тоо, 2006 оны эцсээр

| | Багийн нэр | Бүгд | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Номгон | 4542 | | 132 | 364 | 1312 | 2734 |
| 2 | Эрдэнэмандал | 7442 | 3 | 192 | 581 | 1957 | 4709 |
| 3 | Дуурсах | 5201 | 1 | 135 | 420 | 1471 | 3174 |
| 4 | Угалз | 14042 | 15 | 517 | 1061 | 4596 | 7853 |
| 5 | Цагаанчулуут | 6850 | 1 | 167 | 642 | 1679 | 3861 |
| 6 | Гэгээн шавь | 8541 | 15 | 306 | 474 | 2049 | 5697 |
| 7 | Цахир | 17207 | 37 | 296 | 919 | 4059 | 11896 |
| 8 | Шаргалжуут | 19989 | | 963 | 5418 | 4736 | 8879 |
| 9 | Албан газхууд | 3027 | | 14 | 233 | 2071 | 709 |
| Сумын дүн | | 86341 | 72 | 2722 | 10105 | 23930 | 49512 |

*Эх сурвалж: Сумын статистикийн эмхтгэл, 2006*

Малын тоо багуудад жигд биш, ямаа бүх малын тал хувийг эзэлж буй зэрэг нь цаашид анхаарах асуудал мөн. Сумын нийт хүн амын 13.8%-ийн амьжиргааны эх үүсвэрийг мал аж ахуй бүрдүүлдэг. Бүх малчин өрхийн 85.9% нь буюу 522 өрх 100 хүртэл толгой малтай байна. Гахай, шувууны аж ахуй сумын эдийн засагт нөлөөлөх хэмжээнд хүрч хөгжөөгүй, эхлэлийн байдалтай байна. Нийт 75 уст цэгтэйгээс өрөмдмөл худаг 15, усан сан 13, гар худаг 47 байна. Төрөл бүрийн малын 139 хашаатай. Хувийн хэвшлийн 4 мал эмнэлэг ажиллаж байна. Таримал тэжээл 6 тн, байгалийн хадлан ба гар тэжээл 55 тонныг бэлтгэжээ.

***Газар тариалан:*** 2006 оны мэдээгээр сумын хэмжээнд 1000 орчим өрх, 20 гаруй байгууллага 135.1 га-д газар тариалан эрхэлж байгаагийн 830 гаруй нь хашаандаа, 142 өрх Бор балгас, Бумбат, Хоолт, Шаргалжуутад тариалалт хийж, төмс 98.8 тн, хүнсний ногоо 43.7 тонныг хураан авчээ. 2006 онд нийтдээ хотын хэмжээгээр 9000 ширхэг хайлаас, улиас зэрэг мод гудамж талбайд тарьж, хот орчноо тохижуулсан байна.

## 4.5. Зах зээл, маркетинг

Тус сумын бүтээгдэхүүний борлуулалт, ханган нийлүүлэх зах зээл сумын байршил, үйлдвэрлэл, иргэдийн хэрэглээний шинж чанараар тодорхойлогдож байна. Хөдөө аж ахуйн түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүнийг бусад сумдаас авчран аймгийн




төвд борлуулж, өргөн хэрэглээний барааг Улаанбаатар хот, хилийн боомтуудаас татдаг. Аймгийн төвийг харъяалдаг учраас хүн ам илүү төвлөрч, зах зээл давуу хөгжсөн сум тул аймгийн нийт иргэдэд чиглэсэн худалдаа, үйлчилгээ үзүүлдэг нь сумын эдийн засгийн хөгжилд сайнаар нөлөөлдөг.

Цаашдаа аймаг, сумын дотоод хэрэглээг өөрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр хангах, үндэсний болон гадаад зах зээлд гаргах зорилт тулгарч байна. Энэ зорилгоор бөөний худалдааны сүлжээ бий болгож бусийн сумдыг өргөн хэрэглээний бараагаар хангах, тэдгээр сумдын ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүнийг авч бусад зах зээлд борлуулах болон боловсруулах ЖДҮ хөгжүүлэх, эрэлт ихтэй шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бренд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, гадаад худалдааг өргөтгөх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг нь орчин үеийн шаардлагын хэмжээнд хүргэж сайжруулах шаардлагатай байна. Түүнчлэн аялал жуулчлалыг үйлчилгээний шинэ салбар болгон хөгжүүлэх зорилт тулгамдаж байна.

## 4.6. Боловсрол, соёл, аялал жуулчлал, эрүүл мэндийн үйлчилгээ

***Боловсрол.*** 2006-2007 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 7 сургуульд 9434 хүүхэд суралцаж, 355 багштайгаар сургалт хүмүүжлийн ажлыг явуулж байна. Боловсролын салбарт нийт 1762 хүн ажиллаж байгаагийн 1234 нь эмэгтэйчүүд. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-д 13 мэргэжлээр 1031 хүүхэд, Худалдаа



үйлдвэрлэлийн дээд сургууль (ХҮДС) ба Нягтлан бодох бүртгэлийн «Хонгор» дээд сургууль (НБХДС)-д 360 оюутан суралцдаг. Энэ онд албан бус сургалтад 15194 насанд хүрэгчид, амьдрах ухааны сургалтанд 423 хүн тус тус хамрагджээ.

Нийт хүн амын дунд 18–35 хүртэлх насны залуучууд 30.2%-ийг эзэлж (7942), үүний 26.8% буюу 2128 хүн их, дээд сургууль, коллеж, МСҮТ-д суралцаж байна. Нийт хүн амын дотор сургуулийн өмнөх насны хүүхэд 1883, сургуулийн насны 9434, оюутан 2128, боловсрол эзэмшсэн хүн 10875 байна.

***Эрүүл мэнд.*** 2006 оны байдлаар тус сумын эрүүл мэндийн салбарт 254 хүн ажиллаж байгаагийн 223 нь эмэгтэйчүүд. Их эмч 51, бага эмч 17, эх баригч сувилагч баригч эмч 4, сувилагч 83 ажиллаж байгаагаас 70 ор бүхий хувийн эмнэлэгт 25, өрхийн 6 эмнэлэгт 25, бусад нь нэгдсэн эмнэлэгт ажиллаж байна. Эрүүл мэндийн эдгээр байгууллагууд жилдээ давхардсан тоогоор 189042 хүнд эрүүл мэндийн үзлэг хийж, 63387 хүнийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж байна. Цаашид хүн амын эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэх тогтолцоо бий болгох, орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн эмчилгээ оношлогооны чанарыг сайжруулах, бүх насны хүн амыг чийрэгжүүлэх, бялдаржуулах зорилт тавин ажиллах болно.

***Соёл урлаг, спорт.*** Тус суманд 400 хүний суудалтай хөгжимт драмын театр, кино театр, байгалийн түүхийн музей ажиллаж байна. 2006 онд урлаг, соёлын нэрт зүтгэлтэн С.Лувсанвандангийн нэрэмжит болсон хөгжимт драмын театр жилдээ 32.5 мянган хүнд урлагаар үйлчилж байна. Цаашид түүх-соёлын үл хөдлөх найман дурсгал болон соёлын өвийг гадаад дотоодод сурталчлах, урлагийн наадам зохион байгуулах, иргэдийн гар дээр байгаа соёлын өвийг нарийвчлан бүртгэж сан байгуулах зэргээр соёл урлагийн байгууллагын үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, аялал жуулчлалыг дэмжих чиглэлд анхаарна.





***Аялал жуулчлал.*** Баянхонгор сумын нутагт болон ойролцоо сумдад Шатар чулуу, Бичигт хад, Бор балгас, Хөшөөгийн ам, Ламын гэгээний хийдийн туурь зэрэг түүхэн домогт газрууд, сумын төвд тусгаар тогтнолын багана, найрамдал цогцолбор хөшөө, Эрдэнэмандал хайрхан цогцолбор зэрэг түүх, соёлын дурсгалууд олон байдаг.

Баялаг үзмэр бүхий Байгалийн түүхийн музей жилдээ 5875 хүнд үйлчилж байна. 1981 онд Баянговь сумын Бүгийн цавын хоолойгоос олж илрүүлсэн, тус музейд олон байрлуулж нийтэд дэлгэн үзүүлж буй, 70-130 сая жилийн өмнө амьдарч байгаад сөнөсөн Тарбозавр хэмээх махан идэшт аврага үлэг гүрвэлийн араг яс нь дэлхийд хосгүй байгалийн түүхийн олдвор юм.





Улс даяар алдартай эмчилгээ, сувилгааны 108 ундарга бүхий халуун хүйтэн хосолсон «Шаргалжуут» рашаан сувилал жилдээ 3000 гаруй амрагч, сувилуулагч, жуулчдад үйлчилж байна. Энэ бүхнээс гадна тус сум нь аймгийн төв сум учраас аймгийнхаа хангай, тал хээр, говь хосолсон хонгор нутгийнхаа байгалийн гоо үзэмжид түшиглэн бусад сумтай хоршин аялал жуулчлал хөгжүүлэх таатай нөхцөл бүрдүүлж, гадаад дотоодын жуулчид, тойрон аялагч, амрагчдын сонирхлыг татаж байна.

Дээр дурьдсан тааламжтай нөхцөл боломждоо тулгуурлан аялал жуулчлалыг орон нутгийн бизнесийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхийг зорьж байгаа цаашид хийх ажил их байна. Үүнд:

- Аялал жуулчлалын асуудлыг хариуцан зохицуулах сумын алба байгуулж, үндэсний сүлжээнд холбогдох
- Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, мэдээлэл сурталчилгаа, сургалтыг өргөжүүлэх
- Түүх, соёлын дурсгалт газрууд болон бусад сумдад аялах чиглэл, маршрут тогтоож, аймгийн жуулчлалын үйл ажиллагаатай уялдуулах

- Зам тээвэр, аялал жуулчлалын салбарт дотод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Шаргалжуутын халуун рашааныг түшиглүүлэн олон улсын амралт сувиллын төв байгуулах
- Аялал жуулчлалыг өргөжүүлэхийн тулд гар урлал, спорт, урлаг, соёлын наадам, зочид буудал, ахуйн үйлчилгээ, худалдаа зэрэг дагалдах үйлчилгээг хөгжүүлэх зэрэг болно.

## 4.7. Дэд бүтэц ба бусад үйлчилгээ

***Эрчим хүч, дулааны хангамж.*** Арвайхээр-Баянтээг-Баянхонгорын 210 кв-ын өндөр хүчдэлийн шугам 2005 он ашиглалтад орсноор аймгийн нийт хүн амын 32%-ийг эзлэдэг тус сумын айл өрхүүд, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагууд төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон юм. Тус сумын 607 малчин өрхийн 31.9% нь нарны үүсгэврээр хангагдсан. Баянхонгор хотод хэрэгжүүлж буй «Эрчим хүчний алдагдлыг бууруулах технологи нэвтрүүлэх» ажлын хүрээнд Угалз, Цагаанчулуут, Гэгээн шавь, Дуурсах багт 8 дэд станцын 71 км шугам сүлжээний шинэчлэл бүрэн хийгдлээ. Хотын төсөвт ба үйлдвэрлэл-үйлчилгээний байгууллагууд, орон сууцны халаалтыг төвлөрсөн 6 уурын зуухаар, харин аж ахуйн 68 нэгж, газрууд нам даралтын зуухаар дулаанаа хангаж байна. Цаашид:

- Баянхонгор хотын цахилгаан шугам сүлжээг шинэчлэн сайжруулах замаар айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийг цахилгаан эрчим хүчний шудрага хэрэглээнд сургах
- Хотын төвд төвлөрсөн дулаан хангамжийн систем барих суурь судалгааг хийж зураг төслийг боловсруулан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх
- «Буман нарны гэрэл» төслийг үргэлжлүүлэн 400 малчин өрхийг нарны эх үүсвэрээр хангах
- Шаргалжуутын халуун рашааны бүсэд хийсэн суурь судалгаагаар тогтоогдсон эрчим хүчний хэрэглээг хангах үүднээс 10кв-аас доошгүй хүчин чадалтай цахилгаан станц барьж төвийн эрчим хүчний сүлжээнд холбох зэрэг арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай.

***Харилцаа холбоо.*** Тоон телефон, интернет, факсын уламжлалт үйлчилгээнээс гадна тус суманд дотоод, гадаадад харилцах үүрэн телефоны Мобиком, Скайтел сүлжээний үйлчилгээ ажиллаж байна. Албан байгууллага, айл өрхүүдэд утсан холбооны интернет сүлжээ сүүлийн 2 жил нэлээд өргөжиж байгаа. Тоон станцын үйлчилгээг 1510 албан байгууллага, 1038 хэрэглэгч авч байна. Цаашид:

- Кабель шугамын өргөтгөл хийж, утасгүй холбооны 1000 хэрэглэгчийн дэд станц суурилуулах

- Одоогийн ашиглагдаж буй АТС-ийн багтаамжийг аажмаар нэмэгдүүлж цэгийн тоог 2400-д хүргэх
- Өндөр хурдны шилэн кабелийн шугам тавьж, байгууллагуудыг интернетийн болон интернетийн болон дотоод мэдээллийн сүлжээнд холбох
- Үүрэн телефоны операторуудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Сумын төвийн телевизийн сувгийн тоог нэмэгдүүлэх, сум өөрийн телевизийн студи, нэвтрүүлэгтэй болох зорилт тавьж байна.

***Авто зам.*** Баянхонгор сумын нутаг дээгүүр Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн 210 км сайжруулсан хайрган ба шороон зам, Баянхонгор-Алтай чиглэлийн 185 км шороон зам зэрэг улсын чанартай зам болон Баянхонгор-Шаргалжуутын чиглэлийн болон Эрдэнэцогт, Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Жинст, Баацагаан сумдын чиглэлийн орон нутгийн хөрсөн замууд дайрч өнгөрдөг. Цаашид:

- Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн 210 км замыг хатуу хучилттай болгох
- Баянхонгор-Шаргалжуутын чиглэлийн 54 км замыг хатуу хучилттай болгох
- Түйн голын гүүрийг засах
- Сумын төвийн гэр хорооллын замын нөхцлийг сайжруулах шаардлагатай байна.

***Усан хангамж.*** Хотын цэвэр, бохир усны нэгдсэн системийн байгууламжийг 2004 онд ашиглалтад оруулснаар бохир ус зайлуулах болон ундны усны хангамжийн асуудал тодорхой хэмжээнд шийдвэрлэгдэн оршин суугчдын амьдрах нөхцлийг сайжруулахад зохих ахиц гарсан билээ. Энэхүү систем нь цэвэр усны 16.5 км шугам, түүнчлэн жилдээ 352800 $м^3$ бохир ус зайлуулах хүчин чадалтай 10.8 км бохир усны ба ариутгах татуургын шугам, талбайн байгууламж зэргээс бүрддэг. Эрдэнэмандал хайрхны өвөрт байгуулсан 1000 тонн-ын багтаамжтай 2 усан сангаар жилдээ 504000 $м^3$ цэвэр ус түгээж байна. Цаашид:

- Инженерийн шугам сүлжээний үйл ажиллагаанд хяналт тавьж засвар тохируулгыг заагдсан хугацаанд нь хийх боломжоор хангах
- Баянхонгор хотын баруун хороололд ариутгах татуургын шугам шинээр тавих
- Гэр хорооллын иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усны гидроколонк болон ариутгалын татуургын шугамд холбох ажлуудыг гүйцэтгэх шаардлагатай байна.

***Банк, санхүүгийн үйлчилгээ.*** Улсын хэмжээнд банк, санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг ХААН, Хадгаламж, Худалдаа хөгжил, Монгол шуудан, ХАС зэрэг банкны салбар тус суманд үйл ажиллагаа явуулж бизнес эрхлэгчид болон иргэдэд шаардлагатай үйлчилгээ үзүүлж байна.

***Хог хаягдал.*** Баянхонгор хот 1961 онд одоогийн байгаа газраа суурьшсан залуу хот боловч хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй байсан, хогийн цэгийг 3-



4 удаа нүүлгэн шилжүүлсэн зэргээс хуучин хур хог хаягдал ихсэж, байгаль орчин бохирдон, хүн амын эрүүл мэндэд тааламжгүй нөлөөлөх хэмжээнд хүрээд байна. Хотоос жилд 990 $м^3$ хог хаягдал тээвэрлэн зайлуулж байна. Хотын хог хаягдлын одоогийн цэг нь хотын дээд талд байрладаг, иргэд байгууллагууд хог хаягдлаа замбараагүй асгаснаас хотын хүн амын ундны усны гол эх үүсвэр болсон Түйн голын усыг бохирдуулахад хүрээд байна. Иймд хотод хог хаягдлын зохистой менежмент хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.



# БҮЛЭГ 5

# СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

## 5.1. Бизнесийн орчны судалгааны гол үр дүн

Бизнесийн орчны судалгааг сумын үндсэн баг хариуцан 2006 оны 8–10 дугаар сард явууллаа.

**Судалгаанд оролцогчид**

- Бизнес эрхлэгчид 108, малчид 29, бүгд 137 хүн хамрагдлаа.
- Төлөөллийн хувьд үйлчилгээний салбар 23.2%, МАА - 17.2%, ЖДҮ - 15.1%, газар тариалан - 5.0%, барилга - 3.6%, уул уурхайн салбарын 0.7%, бусад төрлийн бизнес - 10.3%-ийг тус тус эзэлжээ.
- Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын 37.9%, ХЭАА-н 33.8%, бусад салбарын 18.1% нь судалгаанд хамрагдсан бөгөөд эдгээрийн дотор 10 хүртэл ажиллагсадтай нэгж 77.8%, 11-ээс дээш ажиллагсадтай нэгж 20.5%-ийг тус тус эзэлж байв.

**Судалгааны гол үр дүн**

*Эдийн засаг, бизнесийн хөгжил*

- Бизнесийнхээ ирээдүйг малчид 100%, бизнес эрхлэгчдийн 89% нь өөдрөгөөр үнэлсэн бол 11% нь явц муутай гэж үзэж байна.
- Оролцогчдын олонх буюу 53.9% нь мэргэшсэн ажилчдын хэрэгцээ их, хангамж муу байна гэжээ.
- Судалгаанд хамрагдагсдын 91.0% нь бизнесээ өргөтгөх, үүнээс 90.4% нь сумандаа өргөжүүлэх сонирхолтой. Төсөөлж буй арга замын хувьд, 40.5% нь үйлдвэрлэлээ эрчимжүүлэх, ялангуяа малчдын 50% нь МАА-г эрчимжүүлэх, 29.8% нь бараа үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах, бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх боломжийг сонирхдог гэж хариулжээ.
- Оролцогчдын 58.0% нь өөр ямар нэгэн бизнес шинээр эрхлэх бодолтойгоо илэрхийлжээ. Эдгээр хүмүүсийн 72.5% нь зах зээл хүрэлцээтэй учраас сум, аймагтаа бизнесээ байршуулах нь давуу талтай гэсэн бол 47.5% нь улсын хэмжээнд ба гадаадад бизнес эрхлэхэд өрсөлдөөн ихтэй учраас амжилт олохгүй гэж хариулсан байна.
- Оролцогчдын 33.3-47.3% нь газар, түүхий эд материал, ажиллах хүчний дадлага туршлага, эрчим хүч зэрэг бизнес хөгжүүлэх нөхцөл бололцоо хангалттай, 20-иод хувь нь тааруу болон муу гэж үзсэн байна. Харин төвлөрсөн замын нөхцөл муу байгаа нь шатахууны үнэ өсөж буй өнөө үед ноцтой саад бэрхшээл болох талтай гэж олонхи нь хариулжээ.
- Хөрөнгө оруулалтыг хамгийн их татаж байгаа салбарын тоонд боловсрол, эрүүл мэнд, газар тариалан, уул уурхайн салбарыг оруулжээ.
- Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид, малчид нийтийн ахуй үйлчилгээ, ЖДҮ, эрүүл мэнд, боловсрол, малын эрүүл мэнд, хөдөөгийн усан хангамжид ямар нэг мэдэгдэм ахиц гараагүй, эдгээрийг хамгийн их уналттай салбарууд хэмээн тодорхойлжээ. Иймэрхүү уналт зөвхөн үйлдвэрлэл, үйлчилгээнд төдийгүй төрийн үйлчилгээний байгууллагуудад ажиглагдаж байгааг анхаарах нь зүйтэй юм.
- Бизнес эрхлэгчдийн 61.2% нь бизнесийн орчны байдал сүүлийн жилүүдэд сайжирсан, харин малчдын 50% нь муудсан гэж үзсэн нь тэдний эрхэлж буй бизнесийн төрөлтэй холбоотой.
- Зам харилцаа муу, төрийн үйлчилгээнд оршин буй хүнд суртал, ажилгүйдэл бизнесийн хөгжилд хамгийн их саад болж байна. Мөн төрөл бүрийн татварын дарамт, архидалт, үнэ, зардлын өсөлт, ажлын байр олдохгүй байгаа, банкны зээлийн хүү өндөр, төв зах зээлээс хол, худалдан авах чадвар муу байна гэжээ.
- Сумын захиргаанаас бизнес эрхлэхтэй холбоотой лицензи зөвшөөрөл авахад 11.6 хоног зарцуулдаг энэ нь боломжийн гэж ихэнх нь, 41.0% нь урт байна гэж тус тус хариулсан байна.
- Судалгаанд хамрагдагсдын 8.3-26.6% нь сумын эдийн засгийн хөгжилд шинээр ажлын байр бий болгох, бизнесээ тогтворжуулан өргөжүүлэх,

мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, татвараа төлөх замаар хувь нэмрээ оруулна гэж хариулсан байхад 73.4-97.0% нь хариулт өгөөгүй байна.

*Сумын төр, захиргааны үйл ажиллагаа*

- Сумын захиргаатай бизнес эрхлэгчдээс харьцаж ажиллахад жилд дундажаар зарцуулж байгаа хугацааг боломжийн гэж хариулсан байна.
- Оролцогчдын 39.6-41.9% нь сумын ба үндэсний татварын албыг сайн ажилладаг, 32.2-47.2% нь сумын ЭЗ-ийн алба, ИТХ-ыг нөлөө багатай гэж үзжээ.
- Сумын эдийн засгийн хөгжлийг сумын захиргаа хамгийн их (32.7%) дэмждэг, хувийн хэвшлийн ба хоршоодын байгууллагууд 19.6-24.4% дэмждэг гэсэн бөгөөд харин 20.8% нь мэдэхгүй гэж хариулсан байна.
- Төрийн албаны үйл ажиллагааг улам шуурхай болгох, үндэсний ба орон нутгийн чанартай дэд бүтцийг сайжруулах, орон нутагт мөрдөгдөх дүрэм журам, зохицуулалтыг цаг үетэй зохицуулан боловсронгуй болгож байх, бизнесийн мэдээлэл, сургалт, зөвлөмжөөр хангахад захиргааны зүгээс анхаарч ажиллах нь бизнесийн хөгжлийг дэмжихэд чухал байна гэж судалгаанд оролцогчид үзжээ.

## 5.2. СВОТ шинжилгээний дүн

Бизнес орчны судалгаанд үндэслэн орон нутгийн эдийн засгийн орчны нөхцөл байдлын СВОТ шинжилгээг хийсэн бөгөөд уг шинжилгээний дүнд орон нутгийн эдийн засгийн давуу, сул талууд ба боломж, саад бэрхшээлийг тодорхойлогдож, түүнийг үндэслэн даваау тал ба боломж, саад бэрхшээлийн болон сул тал ба боломж, саад бэрхшээлийн хослолуудыг гаргаж стратегийг боловсруулахад ашигласан юм.

Ийнхүү сумын эдийн засгийн орчны нөхцөл байдалд СВОТ шинжилгээ хийсний үр дүнд:

- Эдийн засгийн зохих нөөцтэй, түүх соёлын дурсгалууд олонтой, замаас бусад дэд бүтцийн хөгжил харьцангүй сайн, уламжлалт үйлдвэрлэл, жижиг худалдаа эрхлэх туршлагатай, бизнес эрхлэгчдийн идэвх өрнөж байгаа, зах зээлээ өргөжүүлж байгаа гэх зэрэг 9 давуу тал,
- Хүн амын амьжиргааны түвшин доогуур байгаа, үйлдвэрлэл бизнесийн дэмжлэг, зохицуулалт, сургалт, мэдээлэл хангалтгүй, боловсруулах үйлдвэр хөгжөөгүй, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай, бүтээгдэхүүний зар сурталчилгаа хангалтгүй, түншлэл хамтын ажиллагаа сул, хот байгуулалт, тохижилтын ерөнхий төлөвлөгөө байхгүй, сахилга дэг журам хангалтгүй, газар нутаг, бэлчээр хүрэлцээгүй зэрэг 12 сул тал,

- Эдийн засгийн гадаад харилцаа хөгжиж байгаа, хандивлагчдын дэмжлэг, тусламжийг авч байгаа, төр засгийн болон ТББ-ын дэмжлэг нэмэгдэж байгаа, мэргэжилтэй ажилтан бэлтгэгдэж байгаа зэрэг 5 боломж,
- Зах зээлээс алслагдмал, зам муу, хөрөнгө оруулалт бага, хууль журам зарим талаар амьдралд нийцэхгүй байгаа, банкны зээлийн нөхцөл тааламжгүй, хүү өндөр зэрэг 8 саад бэрхшээл байгааг тус тус илрүүлэн тогтоов.

Эдгээр хүчин зүйлсийн агуулга ач холбогдлоор жишин хоорондн нь харьцуулах замаар Давуу тал-Боломжийн 14, Давуу тал-Саад бэрхшээлийн 20, Сул тал-Боломжийн 17, Сул тал-Саад бэрхшээлийн 20 хослолыг гаргаж ашигласан нь сумын эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулахад ихээхэн дөхөм үзүүлэв.

# СВОТ шинжилгээний матриц

| Дотоод орчны | | Гадаад орчны | |
|---|---|---|---|
| Давуу тал | Сул тал | Боломж | Саад бэрхшээл |
| 1. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх газар нутаг хүрэлцээтэй, байгалийн баялаг, ашигт малтмалын зарим нэг нөөцтэй<br>2. Түүх соёлын дурсгалт газар, рашаан сувилал, байгалийн түүхийн музей зэрэг аялал жуулчлал хөгжүүлэх боломж нөхцөлтэй.<br>3. Төвлөрсөн цахилгаан эрчим хүч, цэвэр, бохир усны нэгдсэн систем, хөдөлгөөнт холбоо, интернет, кабелийн ТВ–ийн сүлжээнд холбогдсон.<br>4. Бэлчээрийн МАА, газар тариалан, хүнсний ногоо, хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэх туршлагатай<br>5. Бизнес эрхлэх талаар олон нийтийн идэвх санаачлага өрнөж, ОНЭЗХ–д хувь нэмэр оруулах хүсэлтэй байгаа<br>6. Суманд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг өөр аймаг, сум, улсын хэмжээний зах зээлд болон экспортод гаргах чиглэлээр өргөжүүлэх бололцоотой<br>7. Аймаг, сумын удирдлага бизнесийн орчинг сайжруулахад анхаарч, бүх оролцогчидтой ОНЭЗХ талаар хамтран ажиллахад бэлэн байгаа | 1. Хүн амын амьжиргааны түвшин, худалдан авах чадвар буурч, ажилгүйдэл, ядуурал ихсэж, ажилгүйчүүдийн мэдлэг боловсрол, мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй<br>2. МАА–н бүтээгдэхүүн ба байгалийн баялгийг боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээний шинэ салбар хөгжихгүй байгаа<br>3. Хөрөнгө оруулалтыг татаж, зээл, санхүүгийн эх үүсвэрийг ашиглаж чадахгүй байгаа<br>4. Бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээ, нэр төрөл, хэв загвар, сав баглаа боодол, реклам, зар сурталчигаа хангалтгүй, бренд бүтээгдэхүүн байхгүй<br>5. Захиргааны үйл ажиллагаанд чирэгдэл, хүнд суртал гардаг, сумын удирдлагаас бизнес эрхлэхэд үзүүлэх дэмжлэг хангалттай биш<br>6. ТББ, албан бус зөвлөл, нийгэмлэг, холбоодын үйл ажиллагааны нөлөө бага, идэвх муутай, бизнесүүд хоорондоо хамтран ажиллаж чадахгүй байгаа | 1. Дэлхийн улс орнуудын төр, засаглалын тогтвортой байдал, олон талт хамтын ажиллагаа<br>2. Олон улсын донор ба хүмүүнлэгийн байгууллагын дэмжлэг тусламж<br>3. Төрийн дэмжлэг, улсын хөрөнгө оруулалт, санхүүжилт, зээлийн боломж сайжирч байгаа<br>4. Үндэсний хэмжээний холбоо, нийгэмлэг, ТББ–үүд нутгийн зөвлөл зэрэг албан бус байгууллагуудаас дэмжлэг авах боломжтой<br>5. Гадаад орнууд болон үндэсний хэмжээнд хэрэгцээтэй мэргэжилтнийг сургах, мэргэжил дээшлүүлэх боломж | 1. Хангап нийлүүлэх болон борлуулах төвлөрсөн том зах зээлээс алс хол<br>2. Зам харилцаа муу хөгжсөн, засмал зам, төмөр зам байхгүй, агаарын тээвэр өртөг өндөртэй<br>3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хүртээмж, улсын төсөв хүрэлцээгүй<br>4. Улс төр, бизнесийн гадны бүлэглэлүүд давамгайлж, шударга бус өрсөлдөөн үүсгэдэг.<br>5. Хууль, дүрэм, журам зарим талаар амьдралд нийцэхгүй байгаа<br>6. Орчин үеийн техник технологийн түвшинд бэлтгэгдсэн нарийн мэргэжлийн ур чадвар бүхий боловсон хүчин дутагдалтай<br>7. ЖДҮ хөгжүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөрүүд хэрэгждэггүй<br>8. Банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн нөхцөл хүнд, хүү өндөр, хугацаа богино |

| Дотоод орчны | | Гадаад орчны | |
|---|---|---|---|
| Давуу тал | Сул тал | Боломж | Саад бэрхшээл |
| 8. Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох боломж байгаа<br>9. МСҮТ төв болон 2 дээд сургуулиар мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтан орон нутагтаа бэлтгэж байгаа | 7. Сумын хэмжээнд сахилга дэг журам, ажлын хариуцлага шаардлагын хэмжээнд хүрээгүй, архидалтыг бүрэн арилгаж чадахгүй байна<br>8. Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө байхгүй, тохижилтын ажилд хөрөнгө санхүүжилт дутагдалтай, хог хаягдал, агаарын бохирдол ихтэй<br>9. Үйлдвэрлэлийг өргөжүүлж чадахгүй байгаа, том хэмжээний бизнес эрхлэгч байхгүй, жижиг, дунд бизнесүүд эрхлэгчдийн эрсдэл даах чадвар сул, үлгэр жишээ, загвар болохуйц хэмжээнд хөгжөөгүй<br>10. Суманд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг зах зээлийн нөхцөлд зохицуулах, дэмжлэг үзүүлэх эдийн засаг, бизнес мэдээллийн тогтолцоо хөгжөөгүй<br>11. Мал аж ахуй эрхлэх гол нөхцөл болсон нутаг бэлчээр хүрэлцээгүй, тэжээл, хадлан бэлтгэх бололцоо хомс<br>12. Сумын төсвийн эрх мэдэл дутмаг, зарим төлбөр хураамжийг бүрэн авч чаддаггүй | | |

## 5.3. “Алсын хараа–Зорилго–Зорилт–Хөтөлбөр–Төсөл” матриц

Алсын хараа. Газар нутаг, байгалийн баялаг, хүн ам, үйлдвэрлэлийн нөөц, дэд бүтцэд тулгуурлан боловсруулах үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бизнесийн таатай орчин бүрдүүлсэн, хүний хөгжил, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангасан, аймгийнхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогцолбор төв болно.

| Зорилго | Зорилт | Хөтөлбөр | Төсөл | No |
|---|---|---|---|---|
| **Зо1.** Хүний хөгжил, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангасан төрийн үйлчилгээ үзүүлнэ | **Зо1.Зт1.** Ерөнхий боловсролын сургуулиуд 3 ээлжээр хичээллэж байгааг 2015 он гэхэд 2 ээлжтэй болгох | **Зо1.Зт1.Хө1.** Ерөнхий боловсролын материаллаг баазыг бэхжүүлэх | **Зо1.Зт1.Хө1.Т1.** 960 хүүхдийн хичээлийн шинэ байр барих | 1 |
| | | | **Зо1.Зт1.Хө1.Т2.** 150 хүүхдийн цэцэрлэг шинээр барих | 2 |
| | | | **Зо1.Зт1.Хө1.Т3.** Боловсролын байгууллагуудыг компьютержуулах, компьютерийн программ хангамжийг сайжруулах | 3 |
| | | | **Зо1.Зт1.Хө1.Т4.** Сургуулийн өмнөх боловсрол олгох материаллаг баазыг өргөтгөх | 4 |
| | **Зо1.Зт2.** Мэргэшсэн ажилчдын хангамж 43.8% байгааг 2012 онд 80%-д хүргэх | **Зо1.Зт2.Хө1.** Иргэдийн боловсролын түвшинг дээшлүүлэх | **Зо1.Зт2.Хө1.Т1.** Дээд сургууль, МСҮ-ийн төв, бусад байгууллагыг түшиглэн төрөл бүрийн сургалт зохион байгуулах | 5 |
| | | | **Зо1.Зт2.Хө1.Т2.** Суманд шаардлагатай нарийн мэргэжлийн мэргэжилтнийг гадаадад сургах, дадлагажуулах | 6 |
| | **Зо1.Зт3.** Хүн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний хүчин чадал одоо 72 хүн/хоног байгааг 2015 он гэхэд 100 болгож нэмэгдүүлэх | **Зо1.Зт3.Хө1.** Эрүүл мэндийн үйлчилгээг чадавхижуулах | **Зо1.Зт3.Хө1.Т1.** Эмнэлгийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг шинэчлэх, өрхийн эмнэлгийг стандартын байраар хангах | 7 |
**Төслийн товч тодорхойлолт:** Сургуулийн ба сургуулийн өмнөх насны хүүхдүүд сувиллын хоол хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор сувиллын тусгай цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эмчилгээний чанартай сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг сургууль, цэцэрлэг зэрэг хүүхдийн байгууллагуудтай холбоход энэ төслийн зорилго чиглэгдэнэ. Сургууль, цэцэрлэгийн хоол хүнсэнд сүү, цагаан идээ өргөн хэрэглэх арга хэмжээг сумын захиргаанаас дэмжиж, санхүүжүүлэх учраас зохих байгууллага, ажилтнуудын шууд хяналтын дор санал болгож буй арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэглээг чанартай бүтээгдэхүүнээр бүрэн хангахын тулд бизнес эрхлэгчид шургуу ажиллах шаардлагатай болно. Ийм замаар төр–бизнесийн хамтын ажиллагаа хүүхдийн сувиллын арга хэмжээний хүрээнд хэрэгжинэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Сумандаа үйлдвэрлэсэн сүүн бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэнэ
- Сургуулийн ба сургуулийн өмнөх насны хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт дээшилнэ
- Орон нутагт үйлдвэрлэгч, хэрэглэгч, орон нутгийн захиргааны байгууллагуудын хооронд нийлүүлэлт, хэрэглээний гинжин холбоо тогтсон байх

**Зорилтот бүлэг:**
- Сургуулийн өмнөх насны ба ЕБС–ийн бага ангийн сурагчид
- Бага насны суурь өвчтэй хүүхдүүд

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Өрхийн эмнэлэгүүд
- ХХАА–н Газар
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- ХХААГазар
- Өрхийн 5 эмнэлэг /”Оточ мандал”, “Оточ номгон”, “Суппрессор”, “Энхбүрд”, “ЭБСУ”/
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Барилга барих газар, зураг төсөв бэлэн болсон
- Гинжин холбоо тогтоох боломж бүрдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Зах зээлийн ба хэрэглээний үнэ ханшны өсөлт

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 36.7**
- Материал – 17.6
- Тоног төхөөрөмж – 8.2
- Ажлын хөлс – 5.4
- Тээвэр – 2.5
- Бусад – 3.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 3.6 | | 33.1 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, ЗДТГ–ын нийгмийн бодлогын ажилтан Н.Сайханцэцэг, утас: 23616, 88446266

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил, 2007–2009

**Үр дүнгийн тогтворжилт:** Үйл ажиллагааны хамрах хүрээ нэмэгдэж тогтворжино

| №9 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт3.Хө1.Т3: Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сувиллын цогцолбор төв байгуулах | **Хөтөлбөр:** Зо1.Зт3.Хө1: Эрүүл мэндийн үйлчилгээг чадавхижуулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор сумын нийгмийн эмзэг давхрагад хамаарах ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эмийн бус эмчилгээгээр сувилан бие бялдрыг нь чийрэгжүүлэхэд зориулж амралт сувилгааны чанартай үйлчилгээний байр гаргаж тохижуулах, үйл ажиллагааг нь тогтвортой явуулахад зохих дэмжлэг үзүүлэхэд сумын захиргааны хүлээх үүрэг оршино. Энэ үүргээ бодитойгоор биелүүлэхийн тулд энэхүү төслийг санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Сувиллын үйлчилгээ эрхлэх шинэ цогцолбор төв байгуулахтай холбогдсон бүх арга хэмжээ, үйл ажиллагаа энэ төслийн хүрээнд хэрэгжинэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Төрөөс ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмж нэмэгдэнэ
- Ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай үйлчилгээ бий болно.
- Эмзэг давхрагын хүмүүсийн эрүүл мэндийн байдал сайжирна

**Зорилтот бүлэг:**
- Сумын 2500 ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй 1800 иргэн

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Халамжийн байгууллага
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
- Хандивлагчид
- Сумын ЗДТГ

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Үйлчилгээ явуулах зориулалтаар засварлах байрын асуудал шийдвэрлэгдсэн байх
- Ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа хийгдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Санхүүжилт их шаардагдана

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 25.0**
- Барилга засвар 15.0
- Тоног хэрэгсэл 8.0
- Ажлын хөлс 2.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 5.0 | | 20.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, Нийгмийн ажилтан Х.Цэцгээ, утас: 23240, 99819131, Аймгийн халамж, үйлчилгээний хэлтэс, Ц.Эрдэнэ–очир, утас: 99168605

**Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Эмзэг бүлгийн иргэдэд хүргэх үйлчилгээ тогтмолжино

| №10 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт4.Хө1.Т1: Хүн амын өвчлөл, эндэгдлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох судалгаа хийх | **Хөтөлбөр:** Зо1.Зт4.Хө1: Хүн амын өвчлөлийг бууруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Хүн амын дунд тархалт, халдварлалт өндөртэй байгаа шар, бэлгийн замын халдвар зэрэг олон өвчнийг бууруулах явдал сумын тухайд нэн тулгамдсан асуудал болоод байна. Хүмүүсийн амьдралын хэв маяг, чанарт сөргөөр нөлөөлдөг эдгээр халдварт ба эмчилгээ муу авдаг өвчний гаралт буурахгүй байгаа учраас эрүүл хүмүүст халдварлах магадлал өндөр байна. Одоогийн байдлыг нарийн судалж тогтоох, урьдчилан сэргийлэх, шалтгааныг арилгах, өвчтэй хүмүүсийг эмчлэн эдгэрүүлэх арга хэмжээг цогцолбороор судлах, шаардлагатай арга хэмжээг сумын хэмжээнд нэгтгэн төлөвлөхөд төслийн зорилго оршино.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Гол халдварт өвчний тархалт, өвчлөлийн байдал, эрсдэлт хүчин зүйлийг судалгаа хийгдэнэ<br>• Халдварт өвчний тархалт, халдварлалт, өвчлөл, эрсдэлт байдал буурна<br>• Эрүүл хүмүүсийн дунд халдварлалт, өвчлөл буурна | • Сумын нийт хүн ам |

| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
|---|---|
| • Эрүүл мэндийн байгууллагууд<br>• Сумын ЗДТГ | • Эрүүл мэндийн байгууллагууд<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |

| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
|---|---|
| • Халдварт өвчний тархалтын судалгаа хийх баг бүрдсэн | • Хүн амын эрүүл мэндийн мэдлэг муу<br>• Ядуурал их байгаа |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 6.3**

- Сургалт хийх – 1.0
- Сурталчилгаа хийх – 1.3
- Ажлын хөлс – 4.0
- Гарын авлага – 1.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 0.6 | 1.3 | 4.4 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, ЗДТГ-ын нийгмийн бодлогын ажилтан Н.Сайханцэцэг, утас: 23616, 88446266

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр нөлөө нь тогтвортой хэрэгжинэ |
|---|---|

| №11 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт4.Хө1.Т2: Эрүүл амьдралыг хэвшүүлэгч байгууллага, өрхийг сурталчлан өргөжүүлэх | **Хөтөлбөр:** Зо1.Зт4.Хө1: Хүн амын өвчлөлийг бууруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Гэр орон, ажлын байр зэрэг бүх орчинд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх гол үндэс нь нийт иргэдийн эрүүл амьдрах, ажиллах орчинг сайжруулахаас эхлэх ёстой. Хүн амын эрүүл мэндийг дээшлүүлэхэд хувь нэмэр болох нийгмийн чиглэлтэй санаачлагыг албан байгууллага, өрхийн түвшинд өрнүүлэх, үүний тулд орон нутагтаа байгаа тэргүүн туршлага, арга ажиллагааг сурвалжлах, дэлгэрүүлэх нь чухал юм. Олон байгууллага, айл өрх өөрийн боломжоор ажиллагсад болон өрхийн гишүүддээ оюун санааны ба эрүүл мэндийн таатай орчин бүрдүүлж чадаж буй нь санал болгож буй төслийг хэрэгжүүлэх үнэтэй, чухал практик алхам юм. Энэ төслийг 7, 8, 9, 10 дах төслүүдтэй холбоотой хэрэгжүүлснээр үр дүнд хүрэх болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Сумын хэмжээнд амьдрах, ажиллах таатай орчин бүрдүүлэх талаар амжилт олж буй тэргүүн туршлагыг сурвалжлах, нийтэд түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ хэрэгжинэ | • Сумын бүх айл өрх, байгууллага<br>• ААН |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Аймаг, сумын ЗДТГ<br>• Өрхийн эмнэлгүүд<br>• Байгуулагууд | • Эрүүл мэндийн байгууллагууд<br>• Хандивлагчид<br>• ТББ |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Шаардагдахгүй | • Хөрөнгө дутагдах |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 11.0**

- Сургагч багш бэлтгэх – 3.8
- Мэдээлэл сурталчилгаа – 2.5
- Шагнал урамшил – 3.7
- Бусад – 1.0

| **Орон нутгийн төсөв** | **Улсын төсөв** | Хандивлагчид |
|---|---|---|
| 2.0 | | 9.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Н. Сайханцэцэг, ЗДТГ-ын нийгмийн бодлогын ажилтан, утас: 23616, 88446266, Э.Мөнхтуяа, Бизнесийн хөгжлийн албаны менежер, утас: 9444696

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос 7 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Хүн амын эрүүл мэндийг дэмжигч айл өрх, байгууллагын хувь нэмэр нэмэгдсэнээр төслийн үр нөлөө үнэлэгдэнэ |
|---|---|

| №12 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт5.Хө1.Т1: Спортын ордон, цэнгэлдэх хүрээлэнг засварлах | **Хөтөлбөр:** Зо1.Зт5.Хө1: Спорт, соёл, урлагийн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Суманд байгаа тоног хэрэглэл, байгууламж ихэд муудсан, шаардлага хангахгүй болсны улмаас хүн амын дунд нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээ тогтмол явуулах шаардлагыг сумын зүгээс хангаж чадахгүйд хүрээд байна. Нийт хүн ам, түүний дотор хүүхэд, залуучуудад бие бялдрын зөв хүмүүжил олгох, аймаг, бүс, цаашилбал үндэсний хэмжээнд өрсөлдөх байнгын бэлтгэл сургууль хийх боломжоор тамирчдаа хангахтай холбогдон энэ асуудал нэлээд хурцаар тавигдаж байгаа юм. Санал болгож буй төслийн хүрээнд одоо байгаа спорт, нийтийн биеийн тамирын цогцолбор, цэнгэлдэх хүрээлэнг засварлах, тоноглох арга хэмжээ хэрэгжүүлнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Спорт, нийтийн биеийн тамирын байр, тоног хэрэглэл сайжрах<br>• Спортын ба нийтийн биеийн тамирын чтглэлээр зохион байгуулах арга хэмжээний тоо, хамрах хүрээ нэмэгдэх | • Нийт иргэд<br>• Хүүхэд залуучууд |

| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
|---|---|
| • Засгийн газар<br>• Аймгийн Биеийн тамир спортын хороо<br>• Сумын ЗДТГ | • Засгийн газар<br>• Аймгийн Биеийн тамир спортын хороо<br>• Хандивлагчид |

| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
|---|---|

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 50.0**
- Материал – 26.8
- Ажлын хөлс шимтгэл – 5.0
- Тээвэр – 2.3
- Цахилгаан – 0.9
- Бусад – 5.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | 30.0 | 20.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын Засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010, Хотын захирагчийн ажлын албаны менежер П. Баатар, утас: 23614 99448190

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Байр, тоноглол бүрэн засварлагдаж, шинэчлэгдсэнээр үр нөлөө нь тогтворжих нөхцөл бүрдэнэ |
|---|---|

| №13 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт5.Хө1.Т2: Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулах | **Хөтөлбөр:** Зо1.Зт5.Хө1: Спорт, соёл, урлагийн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Суманд хүүхэд залуучуудын парк байгуулах ажил 1990-ээд онд эхэлсэн боловч эцсийн шатанд санхүүгийн эх үүсвэр дутагдсанаас шалтгаалж барилгын ажил нь одоо хүртэл дуусаагүй байна. Иргэдийн тодорхой хэсэг, түүний дотор хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдэнд зориулсан олон нийтийн арга хэмжээг янз бүрийн хэлбэрээр зохион байгуулах газартай болох явдал өнөөгийн байдлаар нэн тулгамдаж байна. Иймээс паркийн барилгын ажлыг аль болох ойрын хугацаанд дуусгах, залуучуудын байгууллагын хүсэж буй цогцолбор болгон ашиглахаар тусгайлан тохижуулах шаардлагатай байна. Цогцолборыг барьж дуусган ашиглалтад оруулбал сумын бизнес эрхлэгчид автомат тоглоом байрлуулах, фитнесс төв байгуулах, төрөл бүрийн үйлчилгээ байршуулах, цэцэрлэгжүүлж зүлэгжүүлэх зэргээр олон төрлийн ажил, бизнес хөгжүүлэх боломж нээгдэнэ. Дутуу орхисон барилгыг барьж дуусгаваас Баянхонгор хотын өнгө төрхөд мэдэгдэм өөрчлөлт орно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах газартай болох<br>• Хотын өнгө үзэмж сайжирна | • Нийт иргэд<br>• Хүүхэд залуучууд |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Одоогийн хүүхдийн паркийг эзэмшиж байгаа байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ<br>• Аймаг, сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид | • Засгийн газар<br>• Аймаг, сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Барилгын ажлыг цогцолбор болгон гүйцээх зураг төсөл хийгдсэн байх | • Санхүүжилт дутагдах |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 150.0**

- Зураг төсөв – 2.0
- Материал – 98.5
- Тоног төхөөрөмж – 21.0
- Ажлын хөлс – 25.5
- Бусад – 3.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 5.0 | 20.0 | 125.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ-ын дарга Ш.Лхагвасүрэн, утас: 22353, 99447332, 3-р багийн засаг дарга А.Тарва

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 7 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл дууссаны дараах анхны жилээс үр нөлөө нь тогтворжино |
|---|---|

<table>
<tr><td>No14</td><td colspan="2">Төслийн нэр, код: Зо1.Зт5.Хө1.Т3: Хүүхэд, залуучуудын соёлын төв, номын өргөө байгуулах</td><td colspan="2">Хөтөлбөр: Зо1.Зт5.Хө1: Спорт, соёл, урлагийн хөгжлийг дэмжих</td></tr>
<tr><td colspan="5">Төслийн товч тодорхойлолт: Хүүхэд, залуучуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэн ёс суртахууны хүмүүжил эзэмшүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, орчин үеийн шинэ мэдээлэл, урлаг уран сайхны үйлчилгээгээр тогтмол хангах боломжийг сайжруулахын тулд хүүхэд залуучуудын соёлын төв, номын өргөө, урлагийн тайз бүхий төв шинээр байгуулах, тохоөрөмжлөхөд төслийн зорилго оршино. Одоогоор ашиглагдахгүй байгаа номын сангийн жижиг барилга, соёлын төвийн байрыг засварлан дээрхи зориулалтаар ашиглах боломжтой. Соёлын төв, номын өргөө байгуулах ажлын хүрээнд дотоод тохижилт, тоног төхөөрөмж шинэчлэх, шинээр суурилуулах арга хэмжээ төсөлд тусгагдана.</td></tr>
<tr><td colspan="3">Хүлээгдэж буй үр дүн:<br>• Хүүхэд залуучуудын соёлын төв, номын өргөөг шинээр байгуулах<br>• Хүүхэд залуучуудын ёс суртахууны хүмүүжил сайжирна</td><td colspan="2">Зорилтот бүлэг:<br>• Хүүхэд залуучууд<br>• Нийт иргэд<br>• Бизнес эрхлэгчид</td></tr>
<tr><td colspan="3">Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:<br>• Засгийн газар<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид</td><td colspan="2">Боломжит хувь нэмэр оруулагчид:<br>• Засгийн газар<br>• Бизнес эрхлэгчид</td></tr>
<tr><td colspan="3">Урьдчилсан боломж, нөхцлүүд:<br>• Дэд бүтцэд холбогдох боломжийг урьдчилан хангасан байх</td><td colspan="2">Эрсдэлтэй хүчин зүйлс:<br>• Орон нутгаас гаргах санхүүгийн эх үүсвэр хомс байх</td></tr>
<tr><td colspan="3">Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:</td><td colspan="2">380.0</td></tr>
<tr><td colspan="2">Орон нутгийн төсөв</td><td>Улсын төсөв</td><td colspan="2">Хандивлагчид</td></tr>
<tr><td colspan="2"></td><td>380.0</td><td colspan="2"></td></tr>
<tr><td colspan="5">Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас: Сумын Засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010</td></tr>
<tr><td colspan="2">Хэрэгжүүлэх хугацаа: 3 жил</td><td colspan="3">Үр дүнгийн тогтворжилт: Төсөл хэрэгжсэний дараа үр нөлөө нь тогтвортой болно</td></tr>
</table>

| №15 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт5.Хө.1.Т4: Шаргалжуут тосгонд соёлын төв барих | **Хөтөлбөр:** Зо1.Зт5.Хө1: Спорт, соёл, урлагийн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Шаргалжуут тосгон сумаасаа 65 км хол, бөглүү газар оршдог учраас төвлөрсөн дэд бүтэцтэй холбох, янз бүрийн үйлчилгээг сумаас шууд хүргэхэд хүндрэл учирдаг. Шаргалжуутын малчдын олонхи нь тосгоноосоо хамгийн ойр нь 50 км-д нутагладаг тул соёл урлагийн үйлчилгээ хүргэж чадахгүй байна. Манай улсад алдартай халуун хүйтэн хосолсон рашаан сувилал нь олон тооны аялагчид, амрагч, сувилуулагчид жил бүр ирдэг чухал газар юм. Гэтэл зочид, айлчлагчдад зориулсан урлаг соёлын үйлчилгээ зохион байгуулах зориулалтын байртай болох явдал шаардагдаж байна. Соёлын төв шинээр барих, бүрэн тоноглох төслийг ЭЗХ-ийн стратегид тусган хэрэгжүүлэх саналыг сум, тосгоны олон нийтээс гаргасан бөгөөд соёлын шинэ төв нь урлаг соёлын үйлчилгээг сайжруулахад чухал хувь нэмэр болно. Түүнчлэн тосгоны хөгжил, өнгө үзэмжид сайнаар нөлөөлнө.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Тосгонд урлаг, соёлын үйлчилгээ явуулах боломж дээшилнэ
- Амралт, сувиллын тав тух, хүмүүсийг татах чадвар сайжирна
- Төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ

**Зорилтот бүлэг:**
- Тосгоны хүүхэд залуучууд
- Нийт малчид, иргэд

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Аймгийн боловсрол, соёлын газар

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Засгийн газар
- Аймгийн боловсрол, соёлын газар

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 15.0**
- Материал – 12.0
- Цалин хөлс – 5.0
- Тээвэр – 3.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | 15.0 | |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, С.Готов, Шаргалжуут багийн засаг дарга

**Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл дууссанаар үр нөлөө нь тогтворжих нөхцөл бүрдэнэ

**№16**

**Төслийн нэр, код:** Зо1.Зт5.Хө1.Т5: Тарбозавр үлэг гүрвэлийн араг ясыг засаж бэхжүүлэх

**Хөтөлбөр:** Зо1.Зт5.Хө1: Спорт, соёл, урлагийн хөгжлийг дэмжих

**Төслийн товч тодорхойлолт:** Одоогоос 70–30 сая жилийн өмнө сөнөж мөхсөн Тарбозавр хэмээх үлэг гүрвэлийн араг яс нь дэлхийд хосгүй байгалийн түүхийн олдвор бөгөөд жуулчид, сонирхогчдын анхаарлыг маш ихээр татдаг. 1981 онд Баянговь сумын Бүгийн цавын хоолойгоос олж илрүүлсэн махан идэшт аварга гүрвэлийн араг ясыг тус сумын байгалийн түүхийн музейд байрлуулснаас хойш бэхжүүлэх, сэлбэх ажил хийгдээгүй болно. Иймд энэхүү үнэ цэнэ бүхий үзмэрийг сэргээн засварлах, бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай болсны учир сумын олон нийт энэ ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх боломж, сонирхолтой байгууллага, мэргэжлийн хүмүүсийг төсөл хамтран хэрэгжүүлэхэд урьж байгаа болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Дэлхийд хосгүй аварга гүрвэлийн бүтэн араг ясыг сэргээн засварлах, хадгалалт, үзмэрт байх хугацааг уртасгах
- Гадаад дотоодын жуулчид, аялагчдыг татах газар бий болох
- Дотоод, гадаадад зохиогдох оролцох боломж нэмэгдэнэ

**Зорилтот бүлэг:**
- Гадаад, дотоодын жуулчид
- ЕБС–ийн сурагчид

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Аймгийн байгалийн түүхийн музей
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Гадаад, дотоодын ТББ
- Палентологийн хүрээлэн
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:** 3.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | | 3.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, Орон нутгийг судлах музейн захирал Д.Маахүү, утас: 23449, 99440415

**Хэрэгжүүлэх хугацаа:** 1 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний 6 сарын дараа байнгын үзмэрт байрлуулна

| №17 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт5.Хө1.Т6: Түүх, соёлын үнэт үзмэр, үл хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварлах, хамгаалах | **Хөтөлбөр:** Зо1.Зт5.Хө1: Спорт, соёл, урлагийн хөгжлийг дэмжих |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Үзмэрийн тоогоороо улсад хоёрт ордог байгалийн түүхийн музейгээрээ тус сум алдартай билээ. 1981 онд ашиглалтад орсон энэ музей үзмэрийн баялаг сантай. Гэтэл үзмэр, чихмэлүүдийг сэргээн засварлах төлөвлөгөөт хугацаа аль хэдийнээ өнгөрсөн, энэ хугацаанд нэг ч удаа сэлбэн засаагүй, үзмэрүүд үзвэрийн чанарын шаардлагыг хангахаа больсон тул олон нийтэд дэлгэн чөлөөтэй үзүүлэх боломж нь улам хумигдсаар байна. Ийм учраас Байгалийн түүхийн музейн үзмэрийг сэргээн засварлах, хамгаалахад туслах талаар гадаад, дотоодын донор, хөрөнгө оруулагчдад хандаж сумын ЗДТГ-аас уриалга гаргасан билээ. Байгалийн түүхийн музейн түүх, соёлын үнэт үзмэр, үл хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварлах, шаардлагын дагуу хадгалах, найдвартай хамгаалалттайгаар дэлгэн үзүүлэх боломж бүрдүүлэхэд төслийн үйл ажиллагааг чиглүүлэхийг зорьж байгаа болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Музейн үзмэрийн сан сэргээн засварлагдах, найдвартай хамгаалалттай болгох
- Үзэгчид, жуулчид, аялагчдын сэтгэл ханамж нэмэгдэх

**Зорилтот бүлэг:**
- Гадаад, дотоодын жуулчид
- Иргэд
- Үндэсний түүхийн музей

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Аймгийн ЗДТГ
- Музей
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- БОЯ
- Аймгийн Байгаль орчны газар
- Хандивлагчид
- Дотоодын ТББ

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Ихээхэн муудаж гэмтсэн үзмэрийг сэргээн засварлахад их хугацаа, ажил шаардагдах магадлалтай

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 16.3**
- Амьтны чихмэл – 3.3
- Шилэн хорго – 2.0
- Материал бодис – 8.5
- Ажлын хөлс – 2.5

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | 2.0 | 14.3 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, Орон нутгийг судлах музейн захирал Д. Маахүү, утас: 23449, 99440415

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Үзмэрийн хадгалалт, ашиглалтын хугацаа уртасна

<table>
<tr><td>№18</td><td>Төслийн нэр, код: Зо1.Зт6.Хө1.Т1: Хоёр зуун айлын орон сууц барих</td><td>Хөтөлбөр: Зо1.Зт6.Хө1: Орон сууцны хангамж сайжруулах</td></tr>
<tr><td colspan="3">Төслийн товч тодорхойлолт: “40000 орон сууц” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдэд зориулан 200 орон сууц шинээр барих чухал хоёр зорилтыг хангах үүднээс стратегид тусгахаар энэхүү төслийг дэвшүүлж байгаа юм. Орон сууцны нөхцлөө сайжруулах явдал өрх айл, хүн бүрийн санаа зовоосон асуудал мөн бөгөөд шинээр барих орон сууц нь олон өрх айл, хүмүүсийн амьдрах орчны ая тухтай байдлыг үлэмж дээшлүүлж, амьдралын хэв маягийг сайжруулан өөрчлөх болно.</td></tr>
<tr><td colspan="2">Хүлээгдэж буй үр дүн:<br>• Иргэдийн тохилог орон сууцны хангамж нэмэгдэх<br>• Орон сууцны нөхцлийг сайжруулахад төрийн албан хаагчид, залуу гэр бүлд зохих дэмжлэг үзүүлэх<br>• Хотын өнгө үзэмж, барилгажилт сайжрах</td><td>Зорилтот бүлэг:<br>• Төрийн албан хаагчид<br>• Залуу гэр бүл<br>• Ахмад настнууд</td></tr>
<tr><td colspan="2">Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:<br>• Засгийн газар<br>• Сумын ЗДТГ<br>• Барилгын компаниуд</td><td>Боломжит хувь нэмэр оруулагчид:<br>• Засгийн газар<br>• Сумын ЗДТГ<br>• Хөрөнгө оруулагчид</td></tr>
<tr><td colspan="2">Урьдчилсан боломж, нөхцлүүд:<br>• Шинэ орон сууцыг дэд бүтцээр хангах боломжтой байх<br>• Орон сууц барих газар төлөвлөгдсөн</td><td>Эрсдэлтэй хүчин зүйлс: Байхгүй</td></tr>
<tr><td colspan="3">Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 2600.0<br>• Материал – 2067.5<br>• Ажлын хөлс шимтгэл – 462.8<br>• Тээвэр – 52.9<br>• Цахилгаан – 16.8</td></tr>
<tr><td>Орон нутгийн төсөв</td><td>Улсын төсөв</td><td>Хандивлагчид</td></tr>
<tr><td></td><td>2600.0</td><td></td></tr>
<tr><td colspan="3">Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас: Сумын Засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010</td></tr>
<tr><td>Хэрэгжүүлэх хугацаа: 7 жил</td><td colspan="2">Үр дүнгийн тогтворжилт: 200 орон сууц баригдаж эхлэснээс үр нөлөө нь хэрэгжиж эхлэнэ</td></tr>
</table>

| №19 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт6.Хө1.Т2: Хувийн орон сууцны ипотек зээл нэвтрүүлэх хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** Зо1.Зт6.Хө1: Орон сууцны хангамж сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байгаагаас шалтгаалан тохилог орон сууцны хангамж манай сумaнд сүүлийн жилүүдэд олигтой сайжрахгүй байна. Одоогоор банкнаас олгож буй орон сууцны зээлийн нөхцөл таатай бус, ялангуяа орлого багатай өрхүүд орон сууц барих зээл авах асуудал хүндрэлтэй хэвээрээ байгаа юм. Гэр хорооллын айл өрхүүдэд ч гэсэн хувийн орон сууц барих хөрөнгө ихээр шаардагдаж байна. Санал болгож буй төсөл нь хувийн орон сууц барихад ипотек зээлийн үйлчилгээ нэвтрүүлэх замаар зээл авах барьцааны асуудлыг зохистой байдлаар шийдвэрлэн банкны үйлчилгээг иргэдэд ойртуулах боломжийг турших, нэвтрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Төсөл хэрэгжсэнээр айл өрх, иргэдийн амьжиргааны нөхцөл сайжрах болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Хувийн орон сууцны ипотек зээл олгох боломжийг судалж нэвтрүүлэх<br>• Гэр хорооллын иргэдийн тохилог орон сууцны хангамж нэмэгдэнэ<br>• Гэр хорооллын үйлчилгээ сайжирна | • Гэр хорооллын иргэд<br>• Залуу гэр бүл |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Сумын ЗДТГ<br>• Барилгын байгууллага | • Гэр хорооллын иргэд<br>• Банк, санхүүгийн байгууллага<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Орон сууцны хөтөлбөр боловсрогдсон<br>• Дэд бүтэц хөгжсөн | • Зээлийн /барьцаа, зээлийн хүү/ нөхцөл тааламжгүй хэвээр байх |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 5.0**
- Сургалт – 1.5
- Сурталчилгаа – 0.5
- Цалин шимтгэл – 3.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | | 5.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын Засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010, ЗДТГ-ын статистикч Л.Гүрсэд, утас: 22542, 99448196

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Ипотек зээл нэвтэрч, сууц баригдаж эхлэснээр үр нөлөө нь тогтворжино |
|---|---|

| №20 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт6.Хө1.Т3: “Баянхонгор баялаг” сан байгуулах | **Хөтөлбөр:** Зо1.Зт6.Хө1: Орон сууцны хангамж сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор сумын нийт өрхийн 90% нь гэр хороололд амьдарч байна. Хүмүүсийн орон сууцны ба амьдралын нөхцлийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг энэ тоо нотолж байна. Сум, түүний дотор Баянхонгор хотын хөгжлийн хамгийн гол асуудлын нэг нь гудамж, гудамжны хоорондын газрыг тохижуулах, айл өрхүүд хоршин хувийн орон сууц барих санаачлагыг дэмжих, амьдралын наад захын хэрэгцээг хангах зорилгоор сумын иргэдийн гар дээр сул эргэлтэд байгаа мөнгийг зохистой ашиглах, зээл авах боломжийг хангах зорилгоор мөнгөн хөрөнгийн эргэлтийн сан бүрдүүлэхэд оршиж байна. Төслийн гол зорилго нь олон нийтээрээ зөвшин тодорхойлсон үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөрсдөө бүрдүүлж, сан байгуулж чадах эсэх, тэрхүү сангаа банк бус санхүүгийн байгууллага болгон өргөтгөх боломжийг гэр хорооллын хүрээнд туршихад чиглэгдэнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Гэр хорооллын айл өрхүүдээс эргэлтийн сан байгуулах боломжийг туршин тогтоох
- Гэр хорооллын тохижилт үзэмж сайжрах
- Банк бус байгууллага үүсгэн байгуулах анхан шатны үйл ажиллагааг эхлүүлэх

**Зорилтот бүлэг:**
- Гэр хорооллын айл өрхүүд

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- ЗДГазар
- Багийн удирдлага
- Оршин суугч өрх айлууд

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Банк бус санхүүгийн байгууллагууд
- Бизнес эрхлэгчид/хөрөнгө оруулагчид
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Эргэлтийн сан байгуулахад хувь оруулах айл өрх, хүмүүсийг тогтоосон байх
- Туршилтын талаар хүмүүст сурталчилж ойлгуулсан байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Сан байгуулах мэдлэг, мэдээлэл дутмаг байх

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 110.0**
- Сангийн эргэлтийн хөрөнгө 94.7
- Байрны зардал 8.7
- Цалин шимтгэл 6.6

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 10.0 | | 100.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын Засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010

**Хэрэгжүүлэх хугацаа:** 1 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл дуусcанаас нэг жилийн дараа

| №21 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт7.Хө1.Т1: Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний лаборатори байгуулах | **Хөтөлбөр:** Зо1.Зт7.Хө1: Хүн амыг эрүүл хүнсээр хангах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Чанарын ба эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангахгүй хүнсний ба бусад бүтээгдэхүүний улмаас хэрэглэгчдийн эрх ашиг зөрчигдөж, эрүүл мэндээрээ хохироход хүрч байна. Энэ нь суманд үйлдвэрлэсэн болон гаднаас оруулж буй хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналт сул, түүнчлэн чанар муутай, эрүүл бус хүнсийг гадагш гаргаж, хүнсний бүтээгдэхүүнд шаардлагатай хяналт тавих талаар доголдсоор байгаатай холбоотой юм. Байршлын хувьд Баянхонгор сум нь бусад сумд руу гарч буй бараа, бүтээгдэхүүний урсгалын гол төв болж байдаг онцлогтой. Ийм нөхцөлд хүнсний аюулгүй байдлын хяналтын орчинг сайжруулж, хүнсний чанар, аюулгүй байдалд хяналт тавих орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий лаборатори бий болгоход төслийн зорилго оршино.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтын лаборатори байгуулах<br>• Хүнсний аюулгүй байдал дээшлэх | • Сумын иргэд<br>• Бусад сумын хэрэглэгчид<br>• Бизнес эрхлэгчид |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Сумын ЗДТГ<br>• Аймгийн стандарт хэмжил зүйн төв<br>• Аймгийн мэргэжлийн хяналтын газар | • Хүнсний захууд<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Лабораторид ажиллах мэргэжлийн хүмүүс бэлтгэгдсэн байх | • Хүнс үйлдвэрлэгчид, борлуулагчид хамрагдахгүй байх |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 12.0**
- Тоног төхөөрөмж 9.9
- Байрны зардал 1.1
- Сургалт 1.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Орон нутгийн төсөв |
|---|---|---|
| 2.0 | 8.0 | 2.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** ЗДТГ-ын статистикч Л.Гүрсэд, утас: 22542, 99448196, Ч.Даариймаа, ЗДТГ-ын түшмэл, утас: 99449215

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Нэг жилийн дараа бодитой үр дүн гарна |
|---|---|

| №22 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт7.Хө1.Т2: Аймгийн төвийн ундны усны чанарыг сайжруулах | **Хөтөлбөр:** Зо1.Зт7.Хө1: Хүн амыг эрүүл хүнсээр хангах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Энэхүү төслийн зорилго нь хүн амын ундны усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоож паспортжуулах, ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх өндөр бүтээмж бүхий тоног төхөөрөмжөөр тоноглох замаар хэрэглэгчдийг чанартай, цэвэр усаар найдвартай хангах арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

| Хүлээгдэж буй үр дүн: | Зорилтот бүлэг: |
|---|---|
| • Ундны усны эх үүсвэрийг хамгаалалтад авах<br>• Суманд нийлүүлж буй ундны усны чанар сайжрах<br>• Усыг сумандаа цэвэрлэх, савлах бизнес өргөжих | • Нийт иргэд<br>• Албан байгууллага аж ахуйн нэгжүүд |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Аймгийн усны асуудал эрхэлсэн байгууллага<br>• Бизнес эрхлэгчид | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• “Чандмань” ХХК<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Ундны усны түгээлтийн сүлжээ тавигдсан байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй<br>• |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 18.0**
- Зураг төсөв 1.2
- Барилга 6.2
- Тоног төхөөрөмж 8.0
- Цалин шимтгэл – 2.6

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.0 | | 17.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 9449423, Ч.Даариймаа, ЗДТГ-ын түшмэл, утас: 99449215

| Хэрэгжүүлэх хугацаа: 2 жил | Үр дүнгийн тогтворжилт: 6 сарын дараа тогтвортой |
|---|---|

| №23 | **Төслийн нэр, код:** Зо1.Зт7.Хө1.Т3: "Эрүүл, аюулгүй хүнс" сумын хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** Зо1.Зт7.Хө1: Хүн амыг эрүүл хүнсээр хангах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын хүн амын дийлэнхи нь хүнсний эрүүл ахуйн талаар мэдлэг муутай, хэрэглээний соёл зөв төлөвшөөгүй байгаа нь хүнсний чанар, аюулгүй байдал сайжрахад таагүй нөлөөлж байна. Сумынхаа хүн амыг сүү цагаан идээ, төмс хүнсний ногоо, хүнсний бусад бүтээгдэхүүнээр хангах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор "Эрүүл хүнс" сумын хөтөлбөр боловсруулах, зохистой хэрэглээний талаар олон нийтийн мэдлэг, соёлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн сурталчилгаа явуулахад төслийг чиглүүлнэ.

| | |
|---|---|
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• "Эрүүл, аюулгүй хүнс" сумын хөтөлбөр боловсрогдоно<br>• Хүн амын хэрэглээний соёл дээшлэнэ<br>• Суманд үйлдвэрлэсэн аюулгүй бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэнэ | **Зорилтот бүлэг:**<br>• Нийт иргэд<br>• Нийтийн хоолны газрууд<br>• ТББ |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Аймгийн эрүүл мэндийн газар<br>• Сумын ЗДТГ<br>• Хүнс боловсруулагчид, борлуулагчид, нийтийн хоолны газрууд | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Хандивлагчид<br>• Сумын ЗДТГ |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Ажлын мэргэжлийн баг, сургагчид бэлтгэгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 11.0**
- Сургалт – 3.1
- Судалгаа – 2.7
- Тээвэр – 1.5
- Цалин шимтгэл – 3.7

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.0 | | 10.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Үр өгөөжийг хэрэглэгчид нэг жилийн дараа хүртэнэ |
|---|---|

| №24 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт1.Хө1.Т1: Баянхонгор–Шаргалжуутыг холбосон хатуу хучилттай зам тавих | **Хөтөлбөр:** Зо2.Зт1.Хө1: Зам, гүүрийн нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Орон даяар алдартай Шаргалжуут рашаан сувилал нь гадаад, дотоодын амрагч, жуулчдыг татдаг чухал газар болоод байна. Энэ бүсэд аялал жуулчлал, амралтыг өргөжүүлэхэд хүндрэлтэй, тэр бүү хэл ноцтой саад болж буй хүчин зүйл нь замын нөхцөл муу, түүнээс болж цаг их зарж, илүү зам туулж удаан явахад хүрдэг явдал юм. Улаанбаатар хотоос Шаргалжуут амралт орох сайжруулсан болон засмал зам байхгүй, тосгон орох шороон зам бартаа ихтэй учраас аймгийн төв заавал хүрч, тэндээс эргэж 100 шахам км илүү явах болдог. Санал болгож буй төслөөр Баянхонгор хотыг Шаргалжуут тосгонтой холбосон хатуу хучилттай зам тавих нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад ихээхэн хөнгөлөлттэй болохын дээр аялал жуулчлал, амралт сувилалыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулна.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Жуулчид, амрагчид, аялагчдын тоо нэмэгдэх
- Шаргалжуут тосгон орох хугацаа, богиносч, хөдөлгөөний ая тух сайжирна

**Зорилтот бүлэг:**
- Тосгоны нийт иргэд
- Амрагч жуулчид

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Засгийн газар
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Засгийн газар
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Зам тавих зураг төсөл, төсөв боловсруулж засгийн газарт хүргүүлсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 1350.0**
- Материал – 1049.6
- Ажлын хөлс шимтгэл – 229.9
- Тээвэр – 40.5
- Зураг төсөв – 30.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | 675.0 | 675.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт, утас: 2945, 99442010, Захирагчийн ажлын албаны менежер П. Баатар, утас: 23614, 99448190

**Хэрэгжүүлэх хугацаа:** 5 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Зам тавигдаж ашиглалтад орсноор үр ашгийг тогтвортой шууд хүртэнэ

| №25 | **Төслийн нэр, код:** Зо2:Зт1:Хө1:Т2: Түйн голын гүүрийг шинэчлэн засах | **Хөтөлбөр:** Зо2:Зт1:Хө1: Зам гүүрийн нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Түйн гол дээрхи гүүр нь баруун аймгууд, түүнчлэн Баянхонгор аймгийн хувьд гол зам дайран өнгөрдөг чухал байгууламж юм. Ашиглалтад орсноос хойш 16 жилийн хугацаанд үер ус, автомашинд эвдэгдэн ихээхэн муудсан боловч засвар сэлбэлт хийгдээгүй өнөөдрийг хүрсэн билээ. Манай сумын хаяагаар урсдаг Түйн гол хүчтэй хальж задгай үерлэж замын элдэв байгууламжийг эвдэж байсан, үүгээрээ ч алдаршсан юм. Энэ гүүрийг засаж сэргээснээр аймгийн дэд бүтцийг нэлээд сайжруулсан ажил болохын дээр улсын ба орон нутгийн эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр болно. Гүүрийг бүхэлд нь хоёр талын замын тодорхой хэсэгтэй нь хамт шинэчлэн засахад төслийн үйл ажиллагаа чиглэгдэнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Авто замын даац, өнгөрөөх чадвар сайжирна | • Зорчигчид<br>• Тээвэрчид |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Засгийн газар<br>• Сумын ЗДТГ | • Засгийн газар<br>• Сумын ЗДТГ |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Засварын ажлыг урьдчилан тодорхойлж санал бэлтгэсэн байх | • Борооны ба шар усны үер |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 18.0**
- Материал – 12.2
- Ажлын хөлс шимтгэл – 3.0
- Тээвэр – 2.0
- Цахилгаан – 0.8

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | 18.0 | |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010, хотын захирагчийн ажлын албаны менежер П. Баатар, утас: 23614 99448190

| **Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Гүүрийг зассанаар төслийн үр нөлөө нь мэдэгдэнэ |
|---|---|

| №26 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт1.Хө1.Т3: Гэр хороололд хатуу хучилттай зам тавих | **Хөтөлбөр:** Зо2.Зт1.Хө1: Зам гүүрийн нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын нийт өрхийн 90% оршин суудаг гэр хороололд сайжруулсан ба хатуу хучилттай зам байхгүй учраас үргэлжийн тоос ихтэй, ялангуяа автомашин хөрсийг эвдэх, сүйтгэх явдал буурах төлөвгүй байна. Гэр хорооллын замын энэ байдлаас үүдэн хүрээлэн буй орчинд төдийгүй хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлэ буй сөрөг нөлөөл нь цаашид улам нэмэгдэх учраас тодорхой арга хэмжээг цаг алдалгүй авах хэрэгтэй. Иймд гэр хорооллын гудамж хоорондын шороон замыг хатуу хучилттай болгох санхүүжилт олох зорилгоор энэ төслийг стратегид тусгалаа.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Гэр хорооллын зам сайжирна
- Автомашины замбараагүй хөдөлгөөнөөс болж хөрс элэгдэх, эвдрэх явдал багасч тоосжилт буурна
- Автомашины осол авар, эвдрэл буурна

**Зорилтот бүлэг:**
- Нийт хүн ам
- Гэр хорооллын оршин суугчид
- Автомашин, өөрөө явагч техник эзэмшигчид

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Аймгийн ЗДТГ
- Сумын ЗДТГ
- Зам барилгын компаниуд

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Засгийн газар
- Сумын ЗДТГ
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Замын зураг, төсөл хийгдсэн

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Санхүүжилтийн эх үүсвэр дутагдах

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 250.0**
- Материал – 195.5
- Ажлын хөлс шимтгэл – 44.5
- Тээвэр – 7.5
- Цахилгаан – 2.5

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | 150.0 | 100.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010, ЗДТГ–ын менежер П. Баатар, утас: 23614, 99448190

**Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Зам тавих ажил эхлэснээр үр нөлөөг нь иргэд хүртэх боломж нээгдэнэ

| №27 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт2.Хө1.Т1: ЖДҮ хөгжүүлэх чадавхийн судалгаа хийх | **Хөтөлбөр:** Зо2.Зт2.Хө1: Боловсруулах чиглэлтэй ЖДҮ-ийг хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Суманд үйл ажиллагаа явуулж байгаа бизнесийн нэгж, байгууллагын судалгааг жил бүр гаргадаг боловч тэдгээрийн хөгжил, үйл ажиллагааны одоогийн байдал, хэтийн төлөвийн талаархи иж бүрэн мэдээлэл байхгүй, олдоц муутай байна. Сумын бизнес, түүний дотор ЖДҮ-ийн газар зүйн байршил, эдийн засаг-санхүүгийн болон нийгмийн холбогдолтой мэдээлэл бүрдүүлэх, боловсруулах, олон нийтэд түгээх асуудлыг багцлан шийдвэрлэх хэрэгтэй байна. Үүний тулд ЖДҮ хөгжүүлэх чадавхийн судалгааг одоогийн байдал дээр тулгуурлан хийж хэтийн баримжаа бүхий дүгнэлт гаргах, холбогдох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх боломжийг хангах, сумын бизнес хөгжлийн албыг цаашид бэхжүүлж бизнесийн мэдээлэл, зөвлөгөө өгөх чиглэлээр өргөтгөх асуудлыг хамруулан энэ төслийг хэрэгжүүлнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Суманд ЖДҮ хөгжүүлэх чадавхийн судалгаа хийгдэнэ<br>• Мэдээллийн эх үүсвэрт тулгуурлан ЖДҮ-ийг цаашид хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх боломж өргөжих | • Сумын нийт иргэд<br>• Бизнес эрхлэгчид |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• БХАлба | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 5.0**
- Тоног төхөөрөмж – 2.0
- Сургалт сурталчилгаа – 1.3
- Цалин шимтгэл – 1.7

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | | 5.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** ЗДТГ-ын статистикч Л.Гүрсэд, утас: 22542, 99448196, Э.Мөнхтуяа, БХАлбаны менежер, утас: 99444696

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 1 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Нэг жилийн дараа |
|---|---|

| №28 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт2 Хө1.Т2: ХАА–н бүтээгдэхүүн, түүхий эд боловсруулалт, маркетингийн судалгаа | **Хөтөлбөр:** Зо2.Зт2.Хө1: Боловсруулах чиглэлтэй ЖДҮ–ийг хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор сум мал олонтой, тэр чинээгээр МАА–н бүтээгдэхүүн, түүхий эдийг харьцангуй их хэмжээтэй үйлдвэрлэх, дотоодын ба бусад зах зээл, түүний дотор Хятадын зах зээлд нийлүүлэх чадавхитай. Нэн харамсалтай нь, үнэт бүтээгдэхүүн, түүхий эдийг бараг боловсруулалгүй борлуулж, экспортод гаргаж байгаа нь орон нутагт боловсруулах чиглэлтэй ЖДҮ–ийн хөгжил сул байгаатай шууд холбоотой юм. Сүүлийн жилүүдэд газар тариалангийн бүтээгдэхүүн багагүй нэмэгдэх хандлагатай байгаа нь цаашдаа ХАА–н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг сумандаа боловсруулах асуудлыг яаралтай шийдвэрлэвэл улмаар брэнд бүтээгдэхүүн гаргах, экспортын чадавхиа нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд орон нутгийн нөөцийн ба технологийн чадавхи, ханган нийлүүлэх ба борлуулах зах зээлийг ЖДҮ хөгжүүлэх хэтийн чиглэлтэй холбон нарийвчлан судлах ажлыг төсөл хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай байна

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • ХАА–н бүтээгдэхүүн, түүхий эд боловсруулалт, маркетингийн судалгаа хийгдэнэ<br>• ХАА–н бүтээгдэхүүн, түүхий эдийн боловсруулалтын түвшин дээшлэх<br>• Иргэд жижиг үйлдвэрлэгчид, малчдын өрхийн орлого нэмэгдэх | • Баянхонгор хотын захиргаа<br>• Сумын ЗДТГ<br>• Хүнс, ХАА–н газар<br>• Иргэд, малчид |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Баянхонгор хот<br>• Сумын ЗДТГ<br>• ХХАА–н газар | • Хандивлагчид<br>• ХХАА–н газар<br>• Бизнес эрхлэгчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Бүтээгдэхүүн, түүхий эдийн боловсруулалтыг урамшуулах хөшүүрэг, механизм тогтсон байх | • Санхүүгийн эх үүсвэр дутмаг<br>• Байгаль–цаг уурын эрсдэл |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 5.0**

- Судалгаа хийх – 3.5
- Шатахуун – 1.5

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 2.5 | | 2.5 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, ХХАА–н түшмэл С.Батсүрэн, утас: 99445214

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2007–2008 онд | **Үр дүнгийн тогтворжилт:** Боловсруулах түвшин, боловсруулсан бүтээгдэхүүн, түүхий эдийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр үр нөлөө нь өснө |
|---|---|

| №29 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт2.Хө1.Т3: Байгалийн баялаг, ашигт малтмалын олборлолт, барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх сумын хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** Зо2.Зт2.Хө1: Боловсруулах чиглэлтэй ЖДҮ-ийг хөгжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу барилга байгууламж барих, аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бий болгох, орон нутагт элбэг олдоцтой байгаа материал түүхий эдийг ашиглан боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх тэргүүлэх зорилтын хүрээнд барилгын материалын жижиг дунд үйлдвэр хөгжүүлж байгалийн баялаг, ашигт малтмалыг олборлон ашиглах хөтөлбөр боловсруулахад төслийн зорилго оршино. Энэ төслийг орон нутгийн нөөцийг зохистой ашиглах үндсэн дээр ЖДҮ хөгжүүлэх, сумын нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд чухал түлхэц өгөх болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Байгалийн баялаг, ашигт малтмал олборлох, барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх сумын хөтөлбөр боловсруулах
- Суманд байгаа нөөцийг ЖДҮ хөгжүүлэх бодлоготой уялдуулах стратеги арга зам, боломж нэмэгдэх

**Зорилтот бүлэг:**
- Бизнес эрхлэгчид
- Нийт иргэд

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Хандивлагчид
- Сумын ЗДТГ

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Сумын ерөнхий төлөвлөгөө батлагдсан
- Түүхий эд, нөөцийн судалгаа хийгдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Хөрөнгө оруулалт дутагдах

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 9.3**
- Судалгаа хийх – 5.8
- Тоног төхөөрөмж – 2.5
- Цалин шимтгэл – 1.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.0 | 2.5 | 5.8 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010, ЗДТГ-ын статистикч Л.Гүрсэд, утас: 22542, 99448196

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэний дараа үр өгөөж нь шууд гарна

| №30 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт3.Хө1.Т1: Үзэсгэлэн худалдаа зохион байгуулж бренд бүтээгдэхүүнийг сурталчлах | **Хөтөлбөр:** Зо2.Зт3.Хө1: Худалдааны нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** "Нэг баг – нэг шилдэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг багуудад өрнүүлэн брэнд бүтээгдэхүүнтэй болгох, сумын бренд бүтээгдэхүүнийг тодруулах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төслийг хэрэгжүүлнэ. Сумын иргэдийн үзэж байгаагаар, үзэсгэлэн худалдаа жил бүр зохион байгуулах замаар энэ арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой. Брэнд бүтээгдэхүүнийг сумын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчид бүрэн хүлээн зөвшөөрсөн, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд тэднийг идэвхтэй татан оролцуулах боломжийг хангах замаар үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг хэтийн чиглэлийг барьж төслийг хэрэгжүүлэх шаардлагатай. Брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эзэмшихийг сонирхогчдод зориулсан сургалт, үзүүлэх сургууль, сурталчилгаа төслийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг байх юм.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Сум, багийн бренд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа жил бүр зохион байгуулах
- Бренд бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэх хэмжээ нэмэгдэх
- Шилдэг арга, технологи, туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ өргөжих

**Зорилтот бүлэг:**
- Нийт үйлдвэрлэгчид
- Бизнес эрхлэгчид

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Үйлдвэрлэгчид

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 17.0**
- Сургалт сурталчилгаа – 5.5
- Тоног төхөөрөмж – 6.0
- Тээвэр – 2.5
- Цалин шимтгэл – 3.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 2.0 | | 15.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ-ын түшмэл Ч.Дариймаа, утас: 99449215, Ж.Билгүүн-Очир, төслийн багийн гишүүн, утас:99092010

**Хэрэгжүүлэх хугацаа:** Жил бүр /2008-2015/

**Үр дүнгийн тогтворжилт:** Тогтвортой хэрэгжүүлэх

| №31 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт3.Хө1.Т2: "Бизнес инкубатор"-ын төв байгуулах | **Хөтөлбөр:** Зо2.Зт3.Хө1: Худалдааны нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор сумын хөгжлийн бэрхшээлтэй 4500 гаруй иргэдэд зориулж энэ төслийг тусгайд нь хэрэгжүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дурын ажил, үйлчилгээ эрхлэн орлого олж өөрсдийгээ болон өрх гэрийнхнийгээ дэмжих чадамж, боломж муутай учраас орон нутагт тохирсон, амьдрал дээр шалгаж баталгаажуулсан технологи, арга ажиллагааг тэдэнд эзэмшүүлэх нь хамгийн чухал юм. Эдгээр хүмүүст туслалцаа болгон үр өгөөжтэй технологи нутагшуулах "Бизнес инкубатор"-ын төв байгуулах томоохон зорилтыг сумын захиргаанаас дэвшүүлж байгаа юм. Үүнээс гадна энэ төвийг сумын бизнес эрхлэгчдэд технологи нутагшуулах үйлчилгээ үзүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник технологийн мэдээллээр хангадаг нэгдсэн сүлжээ байгуулах гол түшиц газар болгон ашиглах боломжтой.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлт, амьжиргаа дээшлэх<br>• Төвөөр дамжуулан нутагшуулсан ба нутагшуулж буй технологийн талаар болон бусад мэдээллээр бизнес эрхлэгчдийг хангах | • Хөгжлийн бэрхшээлтэй иргэд<br>• Бизнес эрхлэгчид |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо" ТББ<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>Шаардагдахгүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 15.0**

- Сургалт – 1.2
- Байрны зардал – 10.0
- Тоног төхөөрөмж – 2.5
- Цалин шимтгэл – 1.3

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 5.0 | | 10.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт , утас: 22945, 99442010, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн зөвлөлийн дарга Ж. Төмөрбаатар, утас: 96446688

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2007 оноос | **Үр дүнгийн тогтворжилт:** Жилийн дараа тогтвортой үр нөлөө бий болно |
|---|---|

| **No32** | **Төслийн нэр, код:** Зо2.Зт3.Хө1.Т3: Төрөлжсөн зах, бөөний худалдааны төв байгуулах | **Хөтөлбөр:** Зо2.Зт3.Хө1: Худалдааны нөхцлийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор сум нь аймгийнхаа бусад сумд болон хил залгаа аймгийн сумдад хүнс, бараа ханган нийлүүлдэг бүсийн төв болох хэтийн зорилго тавин ажиллаж байгаа тухай стратегид тодорхой өгүүлсэн болно. Сумын ЭЗХ–ийн стратегийн алсын хараанд тусгагдсан энэхүү томъёоллыг хэрэгжүүлэхэд хөгжлийнхээ одоогийн ба ирээдүйн төлөв, хандлага, чадавхийг сайтар судлах, үнэлэх ёстой. Бүсийн төвийн үйлчилгээнд хамрагдах аймаг, сумын иргэдэд чанартай бүтээгдэхүүн, бараа нийлүүлж байх нэг нөхцөл нь одоо байгаа захуудыг тохижуулж бөөний худалдааны төв, төрөлжсөн зах болгон өөрчлөх явдал юм. Ингэснээр үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд соёлтой боловсон үйлчлэх боломжийг сумын зүгээс хангахын зэрэгцээ төрөлжсөн үйлчилгээ авахад дөхөм үзүүлнэ. Бараа бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг дээшлүүлэх, үнийг хямдруулах, хүнсний бүтээгдэхүүний зориулалтын баталгаатай агуулах байгуулах зэрэг нь төслийн үр дүн, өгөөж байх болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Бүсийн бөөний худалдааны төв сүлжээ бий болно.<br>• Бөөний худалдааны сүлжээгээр нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал сайжрах | • Аймгийн ба бүсийн хэрэглэгчид<br>• Бизнес эрхлэгчид |

| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
|---|---|
| • Бүс, аймгийн бизнес эрхлэгчид<br>• Сумын ЗДТГ<br>• Аймгийн Стандарт, хэмжил зүйн алба | • Бизнес эрхлэгчид<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |

| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
|---|---|
| • Одоо задгай зах ажиллаж байгаа<br>• Бөөний худалдааны цэг байгуулагдах эхлэл тавигдсан | |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 50.0**
- Барилга засвар – 30.0
- Тоног төхөөрөмж – 12.0
- Сургалт – 3.0
- Цалин шимтгэл – 3.5
- Бусад – 1.5

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 20.0 | | 30.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** ЗДТГ–ын статистикч Л.Гүрсэд, утас: 22542, 99448196, Ж.Билгүүн–Очир, төслийн багийн гишүүн, утас: 99092010

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл дууссаны дараа хагас жил өнгөрөхөд үр өгөөж нь гарч эхлэх |
|---|---|

| №33 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт4.Хө1.Т1: “Дэд бүтэц, ахуйн үйлчилгээг сайжруулах” сумын хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** Зо2.Зт4.Хө1: Хотын ахуй үйлчилгээг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын ЭЗХ–ийн стратегид тусгагдсан нэлээд олон төслийг хэрэгжүүлэхийн тулд дэд бүтцийн инженерийн байгууламжийг шинэчлэх, сэргээн засварлах, сайжруулах ажлыг зохих хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай байгаа билээ. Үүнтэй холбогдуулан: (i) ашиглалтад байгаа үндсэн ба туслах ямар дэд бүтцийг хэдийд ямар хэмжээнд сэргээн засварлах, нэмж тоноглох, өргөтгөх, (ii) шинээр ямар дэд бүтцийг хаана, хэдийд ямар хэмжээнд бий болгох, (iii) дээрхи хоёр бүлэг асуудлыг шийдвэрлэхэд ямар хэмжээний ажил, хөрөнгө, оролцоо шаардлагатайг нарийн тодорхойлсон сумын хөтөлбөрийг хотын барилгажсан ба гэр хорооллыг хамруулан боловсруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Дэд бүтэц, инженерийн байгууламжийг сайжруулах сумын хөтөлбөр боловсрогдоно.

**Зорилтот бүлэг:**
- Барилгажсан ба гэр хорооллын айл өрх
- Хот төлөвлөгчид

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Мэргэжлийн байгууллагууд

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Мэргэжлийн байгууллагууд
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Мэргэжлийн байгууллагуудтай урьдчилан зөвлөдсөн тохиролцсон байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Хөрөнгө санхүү дутагдах

**Шаардагдах санхүүжилт: сая: 325.5**
- Материал – 207.8
- Тоног төхөөрөмж – 42.3
- Ажлын хөлс шимтгэл – 55.3
- Тээвэр – 6.0
- Цахилгаан – 2.9
- Сургалт сурталчилгаа – 8.0
- Бусад – 2.7

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 35.7 | 189.4 | 100.4 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010

**Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жил

**Үр дүнгийн тогтворжилт:** 3 жилийн дараагаас тогтвортой ашиглагдана

| №34 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт4.Хө1.Т2: Хөдөөгийн баг, гэр хороололд цэвэр ус, нийтийн халуун усны хүртээмж, үйлчилгшээг сайжруулах | **Хөтөлбөр:** Зо2.Зт4.Хө1: Хотын ахуй үйлчилгээг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор хотын гэр хороолол болон Шаргалжуут тосгон зэрэг алслагдсан газруудад нийтийн халуун ус ашиглалтад оруулснаар иргэдийн ахуйн соёлын түвшинг дээшлүүлэх, халуун рашаан, голын усны бохирдлыг багасгахад чухал хувь нэмэр болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Гэр хороололд нийтийн халуун ус баригдана | • Шаргалжуут тосгоны иргэд<br>• Сумын төвийн гэр хорооллын иргэд |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Засгийн газар<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид<br>• Бизнес эрхлэгчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Цэвэр ба нийтийн халуун усны хэрэгцээг тодорхойлсон байх<br>• Халуун ус барих газрыг тогтоосон байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |
| **Шаардагдах санхүүжилт, сая төгрөг:** | **6.8** |

| **Орон нутгийн төсөв** | **Улсын төсөв** | **Хандивлагчид** |
|---|---|---|
| 2.6 | | 4.2 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, С.Готов, Шаргалжуут багийн засаг дарга

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 6 сар | **Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжсэнээс нэг жилийн дотор үр дүн нь тодорхой болно |
|---|---|

| №35 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт5.Хө1.Т1: Аялал жуулчлалын дэмжих алба байгуулж, үндэсний сүлжээнд хамрагдах | **Хөтөлбөр:** Зо2.Зт5.Хө1: Аялал жуулчлал хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сум аймгийн хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал урсгалын байдалтай явагдаж байгаагаас аялал жуулчлалын салбарыг бодлого төлөвлөгөөтэй хөгжүүлэх талаар тоймтой хэлэх зүйлгүй шахам явж ирлээ. Түүнчлэн одоо хэчнээн аялагч, жуулчин, амрагч тус суманд ирж очиж байгаа, хэдий хэмжээний орлого энэ бизнесээс оруулж, хэн хувь ашиг хүртэж буйг мэдэж, бүртгэж ч чадахгүйд хүрч байна. Угаасаа тогтсон менежмент, энэ ажлыг эрхэлсэн бүтэц суманд байгүй учраас үндэсний сүлжээтэй холбогдох, аялал жуулчлал эрхэлдэг бусад байгууллагатай харьцах асуудал хүндрэлтэй байгаа юм. Иймээс аялал жуулчлалтай холбогдол бүхий нийтлэг болон аялал жуулчлал эрхэлж буй этгээдийн үйл ажиллагааг нэгтгэн зангидах, удирдлагаар хангах асуудлыг хариуцсан аялал жуулчлалын албыг сумандаа байгуулах шаардлага зайлшгүй тулгарч байна. Энэ албаар дамжуулан үндэсний нэгдсэн сүлжээнд нэгдэх, аялал жуулчлалын салбарыг тодорхой бодлого, төлөвлөгөөний үндсэн дээр тэргүүлэх чиглэл болгон сумандаа эрчимжүүлэн хөгжүүлэх асуудлыг төлөвлөх зэрэг олон чухал арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдсон сумын алба байгуулагдах
- Амрагч, аялан жуулчлагчдын тоо нэмэгдэнэ

**Зорилтот бүлэг:**
- Сумын ЗДТГ
- Дотоод, гадаадын амрагчид
- Аялагчид, жуулчид

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Засгийн газар
- Сумын ЗДТГ

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Аялал жуулчлалын үндэсний алба дэмжиж байгаа

**Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 10.0**
- Сургалт – 2.1
- Тоног төхөөрөмж – 2.5
- Байрны зардал – 2.8
- Цалин шимтгэл – 2.6

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 4.5 | | 5.5 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010, ЗДТГ-ын статистикч Л.Гүрсэд, утас: 22542, 99448196

**Хэрэгжүүлэх хугацаа:** 1–2 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл хэрэгжиж дууссанаас хоёр жилийн дараа цаашид тогтвортой хөгжих боломжтой болно.

| No 36 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт5.Хө1.Т2: Аялал жуулчлалын байнгын маршрут бий болгох, бусад сумтай үйл ажиллагаагаа уялдуулах | **Хөтөлбөр:** Зо2.Зт5.Хө1: Аялал жуулчлал хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Монгол улсын аялал жуулчлалын үндэсний сүлжээнд нэгдэж орох бэлтгэл ажлыг хангахын тулд өөрийн сум болон зэргэлдээ сумдыг хамруулсан аялал жуулчлалын маршрут гаргах боломжийг нухацтай судлах, тогтоохоос ажлаа эхлэх ёстой. Өөрөөр хэлбэл, энэхүү шинэ маршрутыг хаагуур, хэдийд нээх, хэрхэн ажиллуулах асуудлыг үндэслэлтэй шийдвэрлэхийн тулд бусад сумдын чадамж боломж, сонирхлыг тусгасан стратегийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай юм. Үндэсний сүлжээний хүрээнд орон нутгийн чанартай аялал жуулчлалын шинэ маршрут нээх нь цаашдаа аймгаа хамарсан сүлжээ бий болгох эхлэлийг тавих чухал асуудал гэдэг талаас нь энэхүү төслийн ач холбогдлыг томъёолж болох юм.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Сумын аялал жуулчлалын шинэ маршрут тодорхойлогдоно.
- Аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд хамрагдах асуудал шийдвэрлэгдэх
- Аялал жуулчлалын үндсэн ба дагалдах үйлчилгээ өргөжих
- Суманд хүлээн авах аялагчид, амрагч, жуулчдын тоо нэмэгдэх

**Зорилтот бүлэг:**
- Дотоод, гадааын амрагчид, аялагчид, жуулчид
- Аялал жуулчлалын бизнес эрхлэгчид

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Хандивлагчид
- Орон нутгийн бизнес эрхлэгчид

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Аймгийн ЗДТГ
- Сумын ЗДТГ
- Бусад сумд
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Шинээр маршрут нээх асуудлаар бусад сумдтай зөвшилцсөн, тохиролцсон байх
- Маршрутыг урьдчилан тоймлож аялал жуулчлалын үндэсний байгууллагуудтай зөвшилцсөн, санал солилцсон байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай
- Хөрөнгө оруулалт дутагдалтай

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 10.5**
- Тоног төхөөрөмж – 6.5
- Судалгаа, сурталчилгаа – 2.0
- Цалин шимтгэл – 2.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 0.5 | 2.0 | 8.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ М. Цогт, утас: 22945, 99442010, ЗДТГ–ын статистикч Л.Гүрсэд, утас: 22542, 99448196

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** Шинэ маршрут нээгдэж хангалттай тооны жуулчид, амрагчид, аялагчид хүлээн авсны дараа буюу 3 дах жилээс үр өгөөж нь тогтворжино

| №37 | **Төслийн нэр, код:** Зо2.Зт5.Хө1.Т3: Аялал жуулчлалын дагалдах үйлчилгээ /гар урлал, урлагийн тоглолт, боловсон үйлчилгээ/-г дэмжин хөгжүүлэх | **Хөтөлбөр:** Зо2.Зт5.Хө1: Аялал жуулчлал хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын аялал жуулчлалын маршрут тогтоогдож үндэсний сүлжээнд хамрагдсан нөхцөлд дагалдах үйлчилгээ болон жуулчид, аялагчдыг татах бусад арга хэмжээг дэмжин хөгжүүлэх асуудлыг нэн тэргүүний зорилтын хэмжээнд авч үзэх ёстой. Тухайлбал, гар урлал, эсгий эдлэл, нэхмэл, уран зураг, урлагийн үзүүлбэр, үндэсний хувцас, наадгай гэх мэт орон нутгийн урчууд хийж чадах зүйлс, түүнчлэн түр зогсоол чухал газруудад цэвэр, тохитой үйлчилгээ бий болгох, замын дагуу бие засах боловсон газар байгуулах зорилго бүхий төслийг сумын ЭЗХ-ийн стратегид тусган хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг дээр оролцогчид санал нэгдсэн болно. Энэ төслийн хүрээнд дээр дурьдсан чиглэлээр аялал жуулчлалын дагалт үйлчилгээ хөгжүүлэхэд түлхэц өгөх эхлэлийн чанартай арга хэмжээ хэрэгжүүлнэ.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Аялал жуулчлалын дагалт үйлчилгээ хөгжүүлэхэд түлхэц өгөх эхлэлийн чанартай арга хэмжээ хэрэгжүүлж эхлэнэ
- Аялагч, жуулагчдад зориулсан зарим боловсон үйлчилгээ нээгдэнэ.

**Зорилтот бүлэг:**
- Гар урчууд
- Бизнес эрхлэгчид

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Гар урчууд
- Хотын аялал жуулчлалын алба
- Бизнес эрхлэгчид

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Хандивлагчид
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Аялал жуулчлагчдын эрэлт хэрэгцээ, сонирхдог зүйлийн талаар судалгаа хийгдсэн байх

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Жуулчдын тоо цөөн, чанар, борлогдолт муу байх

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 10.0**
- Сургалт сурталчилгаа – 2.2
- Барилга засвар – 5.3
- Цалин шимтгэл – 2.5

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 4.5 | | 5.5 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423

**Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил

**Үр дүнгийн тогтворжилт:** 2 жилийн дараа

| №38 | **Төслийн нэр, код:** Зо3.Зт1.Хө1.Т1: ТББ, албан бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** Зо3.Зт1.Хө1: Иргэдийн оролцоог идэвхжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Өөрсдийн ивээл, үзэл баримтлалын дор олон нийтийг зөв үйлсэд идэвхжүүлэн зохион байгуулахад төр засгийн байгууллагаас илүү ажиллаж чаддаг нөлөө бүхий хүчин болох ТББ, холбоод болон иргэний нийгмийн бусад нэгж, бүтцүүдтэй хоёр талын ашиг сонирхолд нийцсэн харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар сумын төр захиргааны байгууллагууд талаар учир дутагдалтай ажиллаж байгаа гэсэн дүн бизнес орчны судалгаанаас гарсан билээ. Түүнчлэн сумын захиргаанаас санаачлан ахмадууд, эмэгтэйчүүд, залуучууд, хөршийн, шашны ба бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, сумын ЭЗХ–ийн стратегийг хэрэгжүүлэхэд тэдний идэвхтэй оролцоог авах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлага тулгараад байна. Тулгамдаж буй эдгээр асуудалтай холбогдуулан үр өгөөжтэй түншлэл, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх замаар иргэний нийгмийн албан ба албан бус байгууллага, нэгжүүдийг дэмжих сумын хөтөлбөр боловсруулах зорилгоор санал болгож буй төсөл хэрэгжүүлнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • ТББ, албан бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр боловсруулах<br>• Сумын ЭЗХ–д иргэний нийгмийн байгууллагуудаас оролцох чин эрмэлзэл, хувь нэмэр нэмэгдэх | • Иргэний нийгмийн байгууллагууд<br>• Сумын ЗДТГ |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Иргэний нийгмийн байгууллагууд<br>• Сумын ЗДТГ<br>• Албан бус бүлгүүд | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Иргэний нийгмийн байгууллагууд<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, хүсэл сонирхол, чадавхи боломжийн талаар урьдчилсан судалгаа хийгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 25.0**
- Хэвлэл мэдээлэл – 3.8
- Сургалт сурталчилгаа – 3.4
- Тоног төхөөрөмж – 14.3
- Бусад – 3.5

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 5.0 | | 20.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, Э.Мөнхтуяа, БХАлбаны менежер, утас: 99444696

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** 2 жилийн дараа үр өгөөж нь тогтворжино. |
|---|---|

| №39 | **Төслийн нэр, код:** Зо3.Зт1.Хө1.Т2: Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөтгөх хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** Зо3.Зт1.Хө1: Иргэдийн оролцоог идэвхжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Гадаад харилцаагаа өргөжүүлэх талаар сумын захиргаа идэвхтэй ажиллаж ирсэн боловч энэ чиглэлийн үйл ажиллагааг аль салбарт ямар хэлбэрээр хөгжүүлэх асуудлыг нарийвчлан тусгасан хэтийн чиглэл, бодлогоо иж бүрэн тодорхойлж чадаагүй байна. Япон, Польш, БНХАУ, ОХУ зэрэг уламжлалт түншүүд болон бусад этгээдүүдтэй тогтоосон гадаад харилцаагаа байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, брэнд бүтээгдэхүүнийг солилцох, экспортод гаргах, эдийн засгийн үндсэн салбарт өсөлт бий болгож тогтворжуулах зэрэг сумын ЭЗХ–ийн нэн тэргүүний зорилгыг хэрэгжүүлэхэд чиглүүлэхтэй холбоотой асуудлыг урт хугацааны хөтөлбөрийн үндсэн дээр шийдвэрлэх нь хамгийн зохистой юм. Иймд дээр дурдсан зангилаа асуудлыг төсөл хэрэгжүүлэх замаар шийдвэрлэх хувилбарыг стратегид тусгасан болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Гадаад хамтын ажиллагааны удаан хугацааны хөтөлбөр боловсруулна<br>• Гадаад түнш бүртэй хэрэгжүүлэх хамтын ажиллагааны чиглэл, хэлбэр тогтоогдоно | • Гадаад түншүүд<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид<br>• Иргэний нийгмийн байгууллагууд |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Аймгийн ЗДТГ<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• ТББ |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Түнш орнуудтай хамтран ажиллах чиглэлээ урьдчилсан тоймолсон байх | Эрсдэлтэй хүчин зүйл: Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 225.0**
- Гадаад томилолт – 45.5
- Замын зардал – 159.0
- Зочид хүлээн авах – 21.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 25.0 | | 200.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын Засаг дарга М. Цогт, утас: 22945, 99442010, ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423

| **Хэрэгжүүлэх хугацаа:** Нэг жилд багтаан хэрэгжүүлж жил бүр хянан шинэчилж байх | **Үр дүнгийн тогтворжилт:** Нэг жилийн дараа үр өгөөж нь тогтворжино |
|---|---|

| No40 | **Төслийн нэр, код:** ЗоЗ.Зт1.Хө1.Т3: Гэр бүлийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах | **Хөтөлбөр:** ЗоЗ.Зт1.Хө1: Иргэдийн оролцоог идэвхжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Энэхүү төсөл нь хүн амын насны бүтцийн өөрчлөлтөөс үүдэн гарах тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гэр бүл төвтэй бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулах зорилготой. Дурдсан үзэл баримтлал ёсоор хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлэх анхдагч нэгж нь өрх айл байх болно. Гэр бүлийг нийгмийн янз бүрийн орчин, харилцааны нөхцөлд бодлогын үндсэн дээр хөгжүүлэх асуудлыг сургалт, сурталчилгаа, олон нийтийг хамарсан бусад хэлбэрийн арга хэмжээний хүрээнд авч үзнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • “Гэр бүлийн хөгжлийн сумын хөтөлбөр” боловсрогдоно. | • Сумын бүх өрх, гэр бүл |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Аймгийн ЗДТГ<br>• Сумын ЗДТГ | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• ТББ |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** Шаардагдахгүй | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 8.0**

- Сургагч бэлтгэх – 1.5
- Техник хэрэгсэл – 1.5
- Сургалт сурталчилгаа – 4.5
- Бусад – 0.5

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 0.8 | 1.6 | 5.6 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ-ын дарга Ш.Лхагвасүрэн, утас: 22353, 99447332, Нийгмийн бодлогын ажилтан Н. Сайханцэцэг, утас: 23616, 88446266

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Нэг жилийн дотор |
|---|---|

| №41 | **Төслийн нэр, код:** Зо3.Зт1.Хө1.Т4: "Хөршийн холбоо" хөдөлгөөнийг дэмжин өргөжүүлэх | **Хөтөлбөр:** Зо3.Зт1.Хө1: Иргэдийн оролцоог идэвхжүүлэх |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Хамт нутагладаг, хөрш айл өрхүүд өдөр дутмын ойр харилцаатай байдгийг туршлага харуулж байна. Анхан шатанд хөгжлийг эрчимжүүлэх хөдөлгөөн өрнүүлэхэд хөршийн харилцааны энэхүү найдвар төрүүлсэн онцлогийг ашиглах боломжтой хэмээн оролцогчид үзсэн болно. Уг хөдөлгөөнийг эхнээс нь зөв чиглэлд залах зорилго бүхий төслөөр дамжуулан оролцогчдоос санаачлан дэвшүүлсэн энэ зорилтыг хэрэгжүүлэх нь хамгийн үр дүнтэй байх болно. Ийм үйл ажиллагаа манай иргэд, сумын захиргааны хувьд урьд өмнө нь хийгдэж байгаагүй шинэ зүйл мөн тул олон улсын туршлагаас суралцах зайлшгүй шаардлагатай юм. Хашаандаа мод тарьж орчноо тохижуулан сайжруулах, бохирдсон ба хог хаягдал хуримтлагдсан газрыг цэвэрлэх, амбаар, орон сууц маягийн жижиг байшин барилга барихад зарцуулах хуримтлалын дундын санд зориулан хөрөнгө босгоход хөршүүдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа төслийн гол зорилго байх болно.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Хөгжлийн баримжаа, зорилт бүхий хөршийн холбоог дэмжих арга замууд туршигдсан байх<br>• Гэр хороололд хөршийн холбоог идэвхжүүлэн хөгжүүлнэ | • Гэр хорооллын хөршийн холбоод |

| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
|---|---|
| • ТББ–ууд<br>• Сумын ЗДТГ | • Сумын ЗДТГ<br>• Хуримтлалын бүлгүүд<br>• Хандивлагчид |

| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
|---|---|
| • Иргэдийн оролцоонд тулгуурлан амьдрах орчныг тохижуулах хөдөлгөөн өрнөж байгаа | • Банк бус санхүүгийн байгууллагад иргэд бүрэн итгэхгүй байх |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 15.0**

- Материал – 8.1
- Тээвэр – 1.8
- Үр, суулгац – 1.9
- Ажлын хөлс – 3.2

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 1.0 | | 14.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт , утас: 22945, 99442010, багийн засаг дарга нар

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Хөршийн холбоо өргөжсөнөөр төслийн үр өгөөж нь тогтворжих ба үнэлгээгээр тогтооно. |
|---|---|

| No42 | **Төслийн нэр, код:** Зо4.Зт1.Хө1.Т1: Баянхонгор хотын цахим мэдээлэл, сурталчилгааны төв байгуулах | | **Хөтөлбөр:** Зо4.Зт1.Хө1: Хот байгуулалт, тохижилтыг сайжруулах |
|---|---|---|---|
| **Төслийн товч тодорхойлолт:** Цаг хугацаа, хөрөнгө хүч аль болох бага зарцуулж шаардлагатай чухал мэдээллийг олж авах хамгийн дөт арга замыг иргэд хүсэн эрэлхийлэх боллоо. Энэ байдлыг харгалзан сумын ЗДТГ–аас цахим мэдээлэл, сурталчилгааны төв байгуулах асуудлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй зөвлөлдөн үндсэндээ тохиролцоод байна. Энэхүү төв нь сумын бизнес эрхлэгчид, иргэд төрийн байгууллагуудын мэдээллийг тавьж олон нийтэд түргэн шуурхай хүргэж байх зориулалт бүхий мэдээлэл–сурталчилгааны цахим самбар ажиллуулна. Түүний зэрэгцээ олон нийтийн мэдээлэл сурталчилгааны үйлчилгээ эрхлүүлэх чиглэлээр сумын төр, захиргаанаас уг төвийг ажиллуулна. | | | |
| **Хүлээгдэж буй үр дүн:**<br>• Олон нийтэд мэдээлэл, зар сурталчилгаа хүргэх шинэ, эрэлт ихтэй үйлчилгээний төв байгуулагдах<br>• Мэдээлэл, зар сурталчилгааны шинэ хэлбэр төлөвших<br>• Иргэд, байгууллагуудаас мэдээлэл сурталчилгаа түгээх, авах, түгээн дамжуулахад хялбар болно | | | **Зорилтот бүлэг, хамрах хүрээ:**<br>• Хотын иргэд<br>• Бизнес эрхлэгчид<br>• Бусад мэдээлэл хайгчид |
| Төслийн хамтран хэрэгжүүлэгчид:<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнесийн холбоод | | | Төсөлд хувь нэмэр оруулах боломжит оролцогчид:<br>• Сумын ЗДТГ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>Шаардагдахгүй | | | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Харуул хамгаалалтын асуудал |
| **Шаардагдах санхүүжилт: сая төг:** | | | 7.7 |
| **Орон нутгийн төсөв** | | **Улсын төсөв** | **Хандивлагчид** |
| 1.8 | | | 5.9 |
| **Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын засаг дарга М.Цогт, утас: 22945, 99442010 | | | |
| **Хэрэгжүүлэх хугацаа:** 7 сар | | Төслийн үр дүнгийн тогтворжилт: Мэдээлэл зар сурталчилгаа өргөжихийн хэрээр төслийн үр нөлөө, өгөөж цаашид өснө | |

| №43 | **Төслийн нэр, код:** Зо4.Зт1.Хө1.Т2: Эрдэнэмандал хайрхан, төв цэцэрлэгийн тохижилт | **Хөтөлбөр:** Зо4.Зт1.Хө1: Хот байгуулалт, тохижилтыг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Эрдэнэмандал хайрхан нь Баянхонгор хотын төв хэсэгт харагдахуйц байрласан, хотыг эргэн тойронтой нь бүрэн харж болох өвөрмөц тогтоцтой уул юм. Энэ уулын орчмын ногоон бүс бий болгож өргөжүүлэх, хүмүүс амралт, чөлөөт цагаа өнгөрөөхөд зориулсан тохижилт хийх зэргээр "Эрдэнэмандал цогцолбор" нэртэй парк байгуулах ажлыг цаашид хот төлөвлөлт, хотжилттой нийцүүлэн өргөжүүлэх эхлэлийг тавих явдал эн тэргүүнд шаардагдаж байна. Парк маягийн байгууламж бий болсноор сумын бизнес эрхлэгчдээс энэ орчимд шинэ үйлчилгээ бий болгох бүрдэнэ.

| Хүлээгдэж буй үр дүн: | Зорилтот бүлэг: |
|---|---|
| • Хотын барилгажилт, хөгжилтэй нийцсэн парк байгуулагдаж хотын өнгө үзэмж сайжирна<br>• Иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх шинэ газар байгуулагдах | • Нийт иргэд<br>• Аялал жуулчлал эрхлэгчид |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Аялал жуулчлал эрхлэгчид<br>• Сумын аялал жуулчлалын алба | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Аялал жуулчлал эрхлэгчид<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Зураг, төсөв зохиогдож бэлэн болсон | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** Байхгүй |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 659.0**

- Материалын зардал – 101.3
- Бут сөөг – 3.2
- Тээвэр шатахуун – 59.1
- Тоног төхөөрөмж – 124.0
- Цалин шимтгэл – 41.6
- Асфальтан зам – 319.8

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 5.0 | 50.0 | 604.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Ө. Амаржаргал

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 5 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Үр нөлөө нь тогтвортой үргэлжилнэ |
|---|---|

| No44 | **Төслийн нэр, код:** Зо4.Зт1.Хө1.Т3: Хотын төвийн зам, талбайг тохижуулах, усан оргилуур бүхий цогцолбор хөшөө байгуулах | **Хөтөлбөр:** Зо4.Зт1.Хө1: Хот байгуулалт, тохижилтийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын иргэд, байгууллага, стратеги боловсруулахад оролцсон нийт оролцогчдоос (i) тусгаар тогтнолын талбай, Энхтайвны гудамжны гэрэлтүүлгийг засаж сайжруулах, (ii) явган хүний зам тавих, хуучныг нь сэргээн засах, (iii) төв замын уулзварт нэрт зохиолч Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит цогцолбор хөшөө байгуулах бүрдэл бүхий тохижилтын томоохон төсөл хэрэгжүүлэх саналыг дэмжиж стратегид тусгасан болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Сумын төв хэсгийн гэрэлтүүлэг, явган хүний зам сэргээн засварлагдаж сайжирна
- Нэрэмжит цогцолбор баригдана
- Гудамж, талбай тохижно

**Зорилтот бүлэг:**
- Нийт иргэд

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- ААН, байгуулагууд
- Сумын ЗДТГ
- Хот тохижилтын алба

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- Хандивлагчид
- Зохиолчийн төрөл төрөгсөд

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Цогцолборын зураг төсөв бэлэн болсон байх
- Зам, талбайн тохижилтыг сайжруулах олон нийтийн хүсэлт шаардлага нэмэгдэж байгаа

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Харуул хамгаалалтын асуудал

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 90.0**
- Материалын зардал – 13.8
- Загвар гаргах – 27.6
- Тээвэр шатахуун – 8.6
- Ажлын хөлс – 10.3
- Бусад – 29.7

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 10.0 | 20.0 | 60.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ИТХ–ын нарийн бичгийн дарга Ө.Амаржаргал

**Хэрэгжүүлэх хугацаа:** 3 жил, 2008–2010

**Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл дууссанаас нэг жил өнгөрөхөд хүмүүс үр өгөөжийг нь хүртэж эхлэнэ

| №45 | **Төслийн нэр, код:** Зо5.Зт2.Хө1.Т1: Хотын хог хаягдлын менежментийг сайжруулах | **Хөтөлбөр:** Зо5.Зт2.Хө1: Эрүүл хот бий болгох |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Хотын төв, гэр хорооллын орчмын газар ахуйн болон үйлдвэрлэлийн хатуу хог, хаягдлаар бохирдох явдал нэмэгдсээр байгааг иж бүрэн цогц арга хэмжээ авахгүйгээр цэгцлэн шийдвэрлэх боломжгүй нь тодорхой боллоо. Иймд хогийн цэгийг цэгцлэн журамлах, хуримтлагдсан хуучин хог, хаягдлыг дарж устгах, боломжтойг нь боловсруулах, цэвэрлэх зэргээр юуны өмнө орчны ба хөрсний бохирдлыг бууруулах, түүнчлэн хотын хог хаягдлын менежментийг сайжруулахад энэ төслийн зорилго, үйл ажиллагаа чиглэгдэнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Хот, түүний орчмын бохирдолтын гол эх үүсвэр болсоор ирсэн хатуу хог хаягдлын менежмент хэрэгжинэ<br>• Бохирдсон газар, орчныг цэвэрлэх, бохирдолгүй болгох ажил хийгдэнэ | • Нийт иргэд<br>• Айл өрх<br>• Аж ахуйн нэгж, байгууллага |

| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
|---|---|
| • Сумын ЗДТГ<br>• Чандмань ХХК<br>• Айл өрх, байгууллага | • Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид<br>• Хандивлагчид |

| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
|---|---|
| • Хуучин хогийн цэгийг цэвэрлэх, хог хаягдал дарж устгах ажил хэсэгчилсэн байдлаар эхэлж байгаа<br>• Хогийн цэгийг тохижуулах зураг төсөв хийгдсэн | • Хог, хаягдлыг зориулалтын бус газар замбараагүй хаядаг явдал буурахгүй байх<br>• Хог хаягдал түүгчид олшрох |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 63.0**

- Машин тоног төхөөрөмж – 32.0
- Ажлын хөлс шимтгэл – 9.9
- Тээвэр – 20.1
- Бусад – 4.0

| Орон нутгийн хөрөнгө | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 5.0 | 8.0 | 50.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Захирагчийн ажлын албаны менежер П. Баатар, утас: 2 614, 99448190, Т.Цэрэндолгор, сумын ЗДТГ-ын ажилтан

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Хог хаягдлын менежмент иргэд, байгууллагуудад хүрч хэрэгжиж эхлэснээр үр өгөөж нь тогтворжино, барагцаалбал 2 жил шаардагдана |
|---|---|

| No46 | **Төслийн нэр, код:** Зо5.Зт2.Хө1.Т2: Хотын төвийг зүлэгжүүлэх, ногоон бүс бий болгох | **Хөтөлбөр:** Зо5.Зт2.Хө1: Эрүүл хот бий болгох |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор хотын захын гэр хороолол төдийгүй төв орчмын газрын элсжилт ихээхэн нэмэгдэхийн хажуугаар элсний нүүдэл идэвхжиж буй хандлага сүүлийн жилүүдэд илт ажиглагдах боллоо. Юуны өмнө элсжилт, элсний нүүдлийг багасгах, зогсоох арга хэмжээг яаралтай авах, цаашилбал хүн амын тав тухтай амьдралын орчинг хамгаалах чиглэлээр төсөл хэрэгжүүлж, энэ хүрээнд зүлэгжүүлэх, ногоон бүсийг өргөтгөх, зарим хэсэгт шинээр бий болгох ажил хийх шаардлагатай байна. Түүнчлэн төслийн зорилгыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хамтад нь авах, өөрөөр хэлбэл хашаандаа мод бут тарих, ногоо тарианы газраа хамгаалах зурвас байгуулах, зүлэг суулгах ажлыг сайн дурын үндсэн дээр өрнүүлэх болно.

**Хүлээгдэж буй үр дүн:**
- Хотын ногоон бүс өргөжих
- Элсжилт, элсний нүүдэл багасах

**Зорилтот бүлэг:**
- Нийт иргэд
- ААН байгууллагууд

**Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- ААН, байгууллагууд

**Боломжит хувь нэмэр оруулагчид:**
- Сумын ЗДТГ
- Бизнес эрхлэгчид
- Хандивлагчид

**Урьдчилсан боломж, нөхцлүүд:**
- Төв цэцэрлэгт мод тарих, олон настаар зүлэгжүүлэх ажил эхлэж байгаа
- Усалгааны төхөөрөмж тавих, байршуулах асуудал яригдаж байгаа

**Эрсдэлтэй хүчин зүйлс:**
- Хөрс, ногоон бүсийг мал амьтан, автомашин эвдлэх
- Усны эх үүсвэр хомсдох

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 80.0**
- Материал – 58.5
- Ажлын хөлс шимтгэл – 13.5
- Тээвэр – 5.0
- Бусад – 3.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | 30.0 | 50.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Захирагчийн ажлын албаны менежер П. Баатар, утас: 23614 99448190, В.Гүрсэд, Хот тохижилтын алба

**Хэрэгжүүлэх хугацаа:** Стратеги хэрэгжүүлэх хугацаанд

**Үр дүнгийн тогтворжилт:** Гурав дахь жилээс цааш

| №47 | **Төслийн нэр, код:** Зо5.Зт2.Хө1.Т3: Элсний нүүдлийг багасгах, үерийн далан байгуулах | **Хөтөлбөр:** Зо5.Зт2.Хө1: Эрүүл хот бий болгох |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Баянхонгор хот нь Түйн гол гольдролоо өөрчилж нэлээд өргөн сайр үүсгэн зүүн урагш эргэж буй нугалбарын доор оршдог учраас хотод гол, уулын үер буух аюул бий. Түүнчлэн аадар, үргэлжилсэн усан бороо орсон үед аймгийн төвийн гэр хорооллын дундуур, ялангуяа Хөх толгойн баруун биеэр хүчтэй үер, урсац ихээр бууж хашаа байгууламж урсгах, хороололд хог, элс бөөгнөрүүлэх, зам гарц, дэд бүтцийг эвдэлж үлэмж хохирол учруулдаг явдал үе үе гарсаар байгаа болно. Иймд хотын гол хэсгүүдээр үер буух аюул бүхий газруудад үерийн далан байгуулах нь зөвхөн үерээс хамгаалах төдийгүй борооны ус хуримтлуулж тариалангийн усалгаанд ашиглах, элсний нүүдлийг тогтоох, багасгах зэрэг олон ач холбогдолтой.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Үерийн далан, хамгаалалт баригдана<br>• Хотын бүсэд хөрсний элэгдэл, элсжилт, элсний нүүдэл багасна<br>• Борооны усыг хуримтлуулах, зохистой ашиглах боломж бүрдэнэ | • Нийт иргэд<br>• Тариалан эрхлэгчид<br>• Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Аймгийн байгаль орчны алба<br>• Бизнес эрхлэгчид | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Зураг төсөв хийгдсэн байх | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Элсний нүүдэл, цөлжилт нэмэгдэх |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 18.0**
- Материал – 12.0
- Ажлын хөлс шимтгэл – 2.3
- Тээвэр – 2.5
- Бусад – 1.2

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| | 18.0 | |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГын ажлын албаны менежер П. Баатар, утас: 23614, 99448190, Л.Мандал, БОХА–ны дарга

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Далан, хамгаалалт баригдаж, ус хуримтлуулах ажил эхлэснээр үр дүн тогтворжино. |
|---|---|

| **No48** | **Төслийн нэр, код:** Зо5.Зт2.Хө1.Т4: Гэр хорооллын утааг багасгах | **Хөтөлбөр:** Зо5.Зт2.Хө1: Эрүүл хот бий болгох |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Гэр хорооллын айл өрхүүдээс гарч байгаа асар их хэмжээний утаа хотыг бүхэлд нь хамарсан агаар, түүнчлэн хөрс, усны бохирдлын гол эх үүсвэр болдог. Гэр хорооллын айл өрхүүд түлшиндээ нүүрс ихээр хэрэглэдэг бөгөөд нүүрсний дутуу шаталтын улмаас ялгарч буй хорт утаа хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлж буйг анхаарах асуудал мөн. Энэхүү төсөл утаа багатай зуух, шахмал хатуу түлшийг сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлж, орчны бохирдол багатай технологи нэвтрүүлэх зорилгын дор хэрэгжинэ. Гэр хорооллын утааг багасгах, хот, түүний орчмын бохирдлыг бууруулах нэг үндэс нь энэ төслийг хэрэгжүүлэх явдал юм.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Агаар, түүнчлэн хөрс, усны бохирдол буурна<br>• Утаагүй шахмал түлш, утаа багатай зуух нэвтрүүлж эхлэнэ<br>• Агаарын бохирдол, утаатай холбоотой өвчлөл, эрүүл мэндийн сөрөг нөлөө бүхий асуудал буурна | • Нийт иргэд<br>• Гэр хорооллын айл өрх |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• Бизнес эрхлэгчид | **Боломжит хувь нэмэр оруулагчид:**<br>• Сумын ЗДТГ<br>• ЭМНХ, БОЯ<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:**<br>• Утаагүй түлш болон утаа багатай зуухыг орон нутагт үйлдвэрлэж эхэлж байгаа | **Эрсдэлтэй хүчин зүйлс:**<br>• Санхүүжилт дутагдах<br>• Хатуу түлш, утаа багатай зуухны хэрэглээ удаан өсөх |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 84.0**
- Материал – 38.8
- Тоног төхөөрөмж – 13.0
- Ажлын хөлс шимтгэл – 13.9
- Тээвэр – 3.5
- Цахилгаан – 4.5
- Сургалт сурталчилгаа – 1.8
- Зураг төсөв – 8.5

| **Орон нутгийн төсөв** | **Улсын төсөв** | **Хандивлагчид** |
|---|---|---|
| 4.0 | 30.0 | 50.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ–ын ажлын албаны менежер П. Баатар, утас: 23614, 99448190, Л.Мандал, БОХАлбаны дарга

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 7 жил буюу стратеги хэрэгжих хугацаанд | **Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл эхлэснээс хойш 2 жилийн дотор үр нөлөө нь үнэлэгдэх хэмжээнд хүрнэ. |
|---|---|

| №49 | **Төслийн нэр, код:** Зо5.Зт2.Хө1.Т1: Сумын газар зохион байгуулалтын зураглалыг шинэчлэх | **Хөтөлбөр:** Зо5.Зт2.Хө1: Газар, бэлчээрийн менежментийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Сумын ЭЗХ–ийн стратегид тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой олон үйл ажиллагаа газар, түүнийг олгох, өмчлөх, эзэмших, ашиглах асуудалтай янз бүрийн байдлаар уялдаж байгаа юм. Одоо ашиглагдаж байгаа нутаг дэвсгэрийн зурагт ЭЗХ–ийн шинэ стратегийн хүрээнд газартай холбоотойгоор хэрэгжүүлэх, шийдвэрлэгдэх хөгжлийн шинэ нөхцөл, дэвшил өөрчлөлтийг тусгаж, багтаах боломж байхгүй. Сумын газар ашиглалт, зохион байгуулалтын зураглалыг шинэчлэснээр газартай холбоотой олон асуудлууд, ялангуяа стратегид тусгагдсан олон төслийг амжилттай хэрэгжүүлэх урьдал нөхцөл, зэхцийг бүрдүүлж чадах юм. Баянхонгор сумын газар зохион байгуулалт, ашиглалтын ерөнхий зураглалыг шинэчлэн боловсруулах төсөл хэрэгжүүлж энэ асуудлыг нэн яаралтай шийдэх нь зүйтэй гэж оролцогчид үзсэн бөгөөд энэ зураглалд Баянхонгор хотын газрын төлөвлөлтийг давхар тусгаж, сум ба хотын хөгжлийг газар ашиглалтын хүрээнд уялдуулах боломжийг хангаж өгнө.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Сумын газар зохион байгуулалт, ашиглалтын ерөнхий зураг шинэчлэгдэнэ<br>• Газар зохион байгуулалт, ашиглалтын төлөвлөгөө боловсрогдоно | • Сумын ЗДТГ<br>• Нийт иргэд<br>• ААН байгууллагууд |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • Аймаг, сумын ЗДТГ<br>• Мэргэжлийн байгууллагууд<br>• Бизнес эрхлэгчид | • Сумын ЗДТГ<br>• Аймгийн газрын алба<br>• Бизнес эрхлэгчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Газар өмчлөгч, ашиглагч, эзэмшигчдийн бүртгэл, судалгаа гарсан байх | • Хөрөнгө санхүү хомсдол |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 25.0**

- Кадастрын зураглал хийх – 10.5
- Судалгаа хийх – 6.5
- Тээвэр шатахуун – 2.8
- Ажлын хөлс – 3.2
- Бусад – 2.0

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 5.0 | 5.0 | 15.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** Сумын ЗДТГ, С.Лочинлхам, утас: 22130, 99449423, газар зохион байгуулагч Ш. Хүрэлбаатар

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Бизнес эрхлэгчид, иргэд, байгууллагуудад газар олголт, өмчлөл, эзэмшил ашиглалтыг зохистой хэрэгжүүлэх явдал төслийн үр дүнгийн тогтворжилтыг хангана |
|---|---|

| №50 | **Төслийн нэр, код:** Зо5.Зт2.Хө1.Т2: Бэлчээр, тариалангийн талбайг усжуулах, менежментийг сайжруулах | **Хөтөлбөр:** Зо5.Зт2.Хө1: Газар, бэлчээрийн менежментийг сайжруулах |
|---|---|---|

**Төслийн товч тодорхойлолт:** Малын тоо толгойг аль болох өсгөх малчдын стратеги, сонирхол, сүүлийн жилүүдэд тохиолдож буй ган, гандалт, даацаас нь хэтрүүлэн менежментгүй ашигладаг сөрөг үйл ажиллагааны улмаас бэлчээрийн ургац муудан ихээр талхлагдаж буйн зэрэгцээ цөлжилт эрчимжиж байгаа өнөө үед бэлчээр, тариалангийн газрыг ашиглах зохистой менежментийг нэвтрүүлэх явдал тус сумын хувьд хөдөө аж ахуйн газар ашиглалтын тулгамдсан асуудлын нэг болоод байна. Усалгаа, газар тариаланг мал аж ахуйтай хоршин эрхлэх зэрэг үр өгөөжтэй арга технологийг нэвтрүүлэх явдал газрын нөөцийн менежментийн сайжруулахад шийдвэрлэх ач холбогдолтой. ХАА-н газрын хязгаарлагдмал нөөцийг олон өмчлөгч, ашиглагч, эзэмшигчдэд олгох, зөв эдэлбэрлүүлэх менежмент нэвтрүүлэх, тогтвортой хэрэгжүүлэх үндсэн дээр төсөлд дэвшүүлж буй зорилтуудыг шийдвэрлэж чадна. Санал болгож буй төслийн хүрээнд бэлчээр, тариалангийн талбайг усжуулах, менежментийг сайжруулахтай холбоотой дээр дурьдсан асуудлуудыг шийдвэрлэнэ.

| **Хүлээгдэж буй үр дүн:** | **Зорилтот бүлэг:** |
|---|---|
| • Бэлчээр, тариалангийн газрын зохистой менежментийг нэвтрүүлнэ<br>• Эрчимжсэн, усалгаатай газар тариалан хөгжүүлэх ба бэлчээрийг улирлаар хуваарьтай ашиглах менежмент хэрэгжинэ | • Малчид<br>• Тариаланчид |
| **Төсөл хэрэгжүүлэхэд оролцогчид:** | **Боломжит хувь нэмэр оруулагчид:** |
| • ЗДТГ<br>• ХХАА-н газар<br>• Бизнес эрхлэгчид, ХАА-н үйлдвэрлэгчид | • Сумын ЗДТГ<br>• МАА, газар тариалан эрхлэгчид<br>• Хандивлагчид |
| **Урьдчилсан боломж, нөхцлүүд:** | **Эрсдэлтэй хүчин зүйлс:** |
| • Тухайн жилийн газар ашиглалтын төлөвлөө боловсруулж батлуулсан байх<br>• Бэлчээр, тариалангийн газрын эзэмшигч, ашиглагчдыг тогтоосон байх | • Санхүүгийн эх үүсвэр дутагдах<br>• Байгаль-цаг уурын эрсдэл, сөрөг нөлөөлөл |

**Шаардагдах санхүүжилт, сая төгрөг: 203.0**

- Худаг уст цэг гаргах – 58.5
- Бэлчээр хөрс хамгаалах – 43.0
- Тариалангийн талбайг сайжруулах – 25.5
- Бэлчээр, талбайг усжуулах – 60.9
- Судалгаа хийх – 15.1

| Орон нутгийн төсөв | Улсын төсөв | Хандивлагчид |
|---|---|---|
| 10.0 | 93.0 | 100.0 |

**Холбоо барих байгууллага, хүн, хаяг, утас:** ЗДТГ С.Лочинлхам, утас: 22130, 99449423, ХХАА-н түшмэл С. Батсүрэн, утас: 99445214

| **Хэрэгжүүлэх хугацаа:** 2008 оноос эхэлж 7 жил | **Үр дүнгийн тогтворжилт:** Төсөл дууссанаас хойш 3-4 жилийн дараа бодит үр дүн гарч эхлэнэ |
|---|---|